



**ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ:
ЗАРИМ АСУУДАЛ**

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

НАА 67
ДАА 340
Э-81

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ: ЗАРИМ АСУУДАЛ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

Энэхүү судалгааг ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэн нийтлэв.

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

© Г.Эрдэнэбат, Ц.Арилдийпүрэв, Г.Оюунболд, 2020 он

ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАСАХ АРГАЧЛАЛЫН ХЭРЭГЛЭЭ

© Б.Мөнхдорж, 2020 он

ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ

© Б.Одонгэрэл, 2020 он

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9574-4-5

ЭМХЭТГЭЛД БАГТСАН СУДАЛГААНУУД

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	5
ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАСАХ АРГАЧЛАЛЫН ХЭРЭГЛЭЭ.....	61
ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ	99

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ БАГ:

Монголын Криминологичидын Холбооны
ерөнхийлөгч Г.ЭРДЭНЭБАТ

Хуульч, судлаач, хууль зүйн ухаан магистр
Г.ОЮУНБОЛД

Удирдахуйн ухааны доктор, хууль зүйн магистр
Ц.АРИЛДИЙПҮРЭВ

ГАРЧИГ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.....	7
Судалгааны үндэслэл.....	7
Судалгааны зорилт.....	7
Судалгааны арга зүй.....	7
Судалгааны баг.....	8
1. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	9
1.1 Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ойлголт, онцлог.....	9
1.2 Монгол Улсын Эрүүгийн процессын хууль тогтоомжийн түүхэн уламжлал.....	12
1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинэчлэл- шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг.....	15
2. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ.....	22
2.1 Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн орчин үеийн чиг хандлага.....	22
2.2 Гадаадын зарим орны Эрүүгийн процесс дахь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг.....	23
2.3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хийсэн дүн шинжилгээ.....	33
ДҮГНЭЛТ.....	51
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	55
СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	58

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Шударга ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалах үзэл хандлагын үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтыг шинээр тодорхойлсон билээ. Хэдийгээр Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлт хэрэгжиж эхлээд хоёр жил гаруй болсон хэдий ч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас аль болох зайлсхийх, улмаар хохирогч, яллагдагч, бусад оролцогчийн эрхийг бүрэн хангахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх хандлагатай байна. Иймд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зохих ёсоор явуулж, мөрдөн шалгах ажиллагаа шударга явагдах нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний эрхийг үр дүнтэй хангах шаардлагатай.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, хуулийн зүйл, хэсгийн хэрэгжилтийг судлах;
2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж буй гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж давуу болон сул талыг тодорхойлох;
3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах арга замыг тодорхойлсон санал зөвлөмж боловсруулах.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- *Статистик, тоо баримт цуглуулах:* Өгөгдсөн болон цуглуулсан тоо баримтад тулгуурлан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хэрэгжилтэд дүгнэлт хийх;
- *Харьцуулалт хийх:* Оросын Холбооны Улс болон Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн онол, практикийг Монгол Улсынхтай харьцуулах;

- *Кейс баримтжуулалт, ажиглалт хийх:* Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн хэргүүдээс санамсаргүй түүврийн аргаар 5 хувьтай тэнцэх хэрэгт судалгаа хийж, дүгнэлт гаргах;
- *Прокурор, өмгөөлөгчөөс асуулга авах:* Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон прокурор, өмгөөлөгчөөс асуулга авч, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх ойлголт, мэдлэг чадварын түвшнийг тогтоон дүгнэх.

Дээрх аргуудыг хэрэглэн хуулийн зүйл, хэсгийн хэрэгжилтийг судалж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулсны дүнд хэрэгжилтийг сайжруулах арга замыг тодорхойлсон санал зөвлөмж боловсрууллаа.

СУДАЛГААНЫ БАГ

Судалгааг Монголын Криминологичдын Холбооны ерөнхийлөгч Г.Эрдэнэбат, зөвлөх Ц.Арилдийпүрэв, судлаач Г.Оюунболд, УЕПГ-ын ахлах прокурор Х.Батчимэг, туслах судлаач Б.Ариунтуяа нар хийж гүйцэтгэв.

-НЭГДҮГЭЭР БҮЛЭГ-

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1.1 ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

Урьдчилсан хэлэлцүүлэг бүхий шүүхийн анхны тогтолцоо Англи Улсад 1200-аад онд бий болохын¹ зэрэгцээ гэмт хэргийг шашин, ёс суртахуун эсвэл тусгайлсан хууль цаазаар тухайн орон нутгийн хашир туршлагатай ахмад настан, хошуу ноёд, түшмэдээр шийдвэрлүүлж байсан ажээ. Шүүхийн тогтолцоо бий болсноос хойш 1700-аад оны үед Европын тэргүүлэх гүрнүүдийн колоничлол, соёлын нөлөөгөөр *trial* буюу шүүх ажиллагаа дэлхий нийтэд түгж, шударга ёсыг тогтоох үзэл санаа хууль дээдлэх зарчимд тулгуурлан хөгжиж ирсэн түүхтэй.

Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн хөгжлийн явцад XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед “хэдийгээр шүүх шударга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ?” гэсэн асуудал тулгамджээ. Чухамхүү энэ л шалтгаанаар шударгаар шүүлгэх эрхийн шаардлагын үүднээс “*due process*” үүсэн бий болсон байна. “*Due process*” нь хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм.

“*Due process*”-ийн зөвхөн нэг арга хэрэгсэл бол “шүүхийн өмнөх хэлэлцүүлэг” бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагаа шударга байх явдлыг хангах үүднээс эрүүгийн хэрэг үүсгэх, нотлох баримтыг үнэлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт процессын ажиллагааг алдаагүй явуулах төрөл бүрийн хэлэлцүүлгүүдээс /*hearing*/ бүрддэг.

¹ Judges and the law. 2016. The open University. page 11.

Орчин үед “*Due process*”-ийг хангахыг олон улсын хүний эрхийн байгууллага шаардаж, дэмжиж ирсэн. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос илтгэснээр “шүүх ажиллагааны шударга байдал нь шууд болон шууд бус байдлаар хөндлөнгөөс нөлөөлөөгүй байх, ямар нэгэн зорилгоор, аль нэг талаас нэхээгүй, шаардаагүй, дарамтлаагүй, саад болоогүй гэдгээр илэрхийлэгдэнэ” гэжээ.² Мөн шударга байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бол яллах, өмгөөлөх талын хооронд тэгш байдлыг³ хангах явдал гэсэн байна.

Бүх тал эрүүгийн процессын тэгш эрхээр хангагдах ёстой бөгөөд хэрэв хуулиар аль нэг талыг ялгаатай авч үзсэн бол тэр нь тодорхой үндэслэл, бодит нөхцөлөөр тогтоогдсон байх ёстойн зэрэгцээ, энэ нь өмгөөлөх талд ямар нэгэн сул талыг бий болгосон, шударга бус ямар нэг нөхцөл байдлыг тогтоосон шинжтэй байх ёсгүй.⁴ Европын Хүний эрхийн хороо талуудын ашиглах арга хэрэгсэл тэнцүү байх ёстойг тогтоохдоо аливаа тал өөрийн хэргийг танилцуулахдаа үндэслэл бүхий тэгш боломжоор хангагдсан байх ёстой бөгөөд ийнхүү танилцуулахдаа нөгөө талаа тэгш бус байдалд оруулах нөхцөлд хүргэж болохгүй, энэ хүрээнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ шударга байдлыг нэмэгдүүлэхийг дэмжих ёстой гэж үзжээ.⁵

Гэхдээ олон улсын байгууллага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхийг хангах процесс заавал нэг хэлбэртэй байх ёстой гэж албадахгүй гэдгийг онцолж, үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн төрөл бүрийн арга хэлбэрээр дээрх шаардлагыг хангасан байж болохыг тэмдэглэсэн⁶ нь шүүхийн өмнөх шатанд тодорхой мөрдөн шалгах процессыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн төрөл, хэлбэрийг хуульчлах тухай зөвлөмж юм.

² Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж, 25-р догол мөр.

³ Шүүхэд талуудын эрх тэгш байдлыг хангах талаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай ОУ-ын пактын 14 /1/-т, ялгаварлан гадуурхахгүй байхыг 2-р зүйлд тогтоожээ.

⁴ Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж, 13-р догол мөр, Мөн Харилцаа №1347/2005 Дудко, Австрали, 7.4-р зүйл.

⁵ Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж, 13-р догол мөр, Мөн Харилцаа №1347/2005 Дудко, Австрали, 7.4-р зүйл.

⁶ Хүний эрхийн Европын хороо. Браншеттерийн хэрэг, Австри Улс. 1991 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн шүүхийн шийдвэр, Цуврал А, №211, 27-28-р бүлэг, 67-р зүйл.

Монгол Улсын хувьд дээрх олон улсын чиг хандлагыг харгалзан үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэнд “...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрх...”, 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрх”, 19 дүгээр зүйлд заасан төрийн “хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор 2015, 2017 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус батлан хэрэгжүүлээд даруй хоёр жил гаруй болж байна. Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд энэхүү эрүүгийн эрх зүйн шинэчлэл чиглэсэн.⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан “...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох...” эрхэд нийцүүлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.8 дугаар зүйлд яллагдагч буюу шүүгдэгчийг анхан шатны шүүх хуралдаанд биечлэн оролцуулахаар хуульчилсан бөгөөд яллагдагч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргавал талуудын саналыг харгалзан шүүх шийдвэрлэхээр заажээ.

Мөн Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 13 дах хэсэгт заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хууль бусаар халдсан, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур мөрдөн шалгах ажиллагаа явуулж, оролцогчдын эрхийг зөрчсөн тохиолдолд тухайн асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлүүлэх боломжийг олгожээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой баталгааг хангахын тулд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан хүний эрхийн зөрчил, алдааг олж тогтоох, залруулах, хөндөгдсөн эрхийг сэргээх, хэргийг бүрэн дүүрэн шалгаж шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн төслийн анхны буюу 2015 оны үзэл баримтлалд хэд хэдэн ухралт гарч, 2017 онд шинээр өөрчлөгдөн батлагдахдаа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар тусгасан дэвшилтэт шийдлүүд хасагдаж “хавтаст хэрэг

⁷ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, 2015 он. ХЗЯ

дагадаг” уламжлалт тогтолцоо, “бодит үнэнийг тогтоох зарчим” хэвээр үлдсэн. Ингэхдээ бүтэн бүлэг байсан 6 төрлийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг танаж, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааны талаарх бүлгийн нэг зүйл хэсэгт багтаан тусгасан байна. Дээрх ухралтаас үүдэж одоогийн байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн гүйцэтгэх үүрэг сарнин хүний эрхүүдийг зохистойгоор хангах боломж хаагдаж, урьдчилсан хэлэлцүүлгийг буруу жишиг, хандлагаар хэрэглэх суурь тавигдсан гэж үзэж болохоор байна.

Ялангуяа хавтаст хэрэг дагадаг, шийдвэр гаргахдаа процесст бус “төв рүү тэмүүлэх хүч” буюу албан тушаалтан эрх мэдлийнхээ хүрээнд хэргийн хувь заяаг шийддэг энэхүү тогтолцоог аажмаар халах нь зүйтэй. “Цаашид мэтгэлцэх зарчим руу шилжих, оролцогчдын тэгш боломжийг хангасан шүүхийн урьдчилсан шатны хэлэлцүүлгийн төрлийг нэмэх, зөвшөөрлийн системийг уян хатан болгох чиглэл рүү хөгжих нь зүйтэй ” гэж судлаачид дүгнэсэн⁸ байна.

1.2 МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн шинэ үеийг Ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн 1921 оноос хойш эхлэн тооцож үзвэл өнгөрсөн 90 гаруй жилд 1926, 1935 онуудад “Аливаа хэргийг байцаан шийтгэх тухай, 1949, 1963, 1986, 2002 онуудад “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-иуд тус тус батлагдаж, өөр хоорондоо залгамж шинжтэй, нөгөө талаар тухайн цаг үеийн улс төр, үзэл суртлын өнгө аясыг агуулсан, тухайн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэн түүхэн үүргээ гүйцэтгэж иржээ.

⁸ Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь, судалгааны тайлан. Эрүүгийн эрх зүйн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, дэд тайлан. ХЗҮХ. 2017 он

Монгол Улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь цоо шинэ ойлголт биш бөгөөд 1949, 1963 онуудын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “бэлтгэл цуглаан” гэсэн нэртэйгээр шүүх хуралдааны бэлтгэлийг хангах зорилгоор явуулж байжээ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг /бэлтгэл цуглаан/ тусгасан 1949 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ гэх)-иар прокуророос ял төлөвлөж ирүүлсэн бүх хэргийг шүүхэд шилжүүлэх асуудлыг нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй бэлтгэл цуглаанаар хэлэлцдэг байсан бол 1963 оны ЭБШХ-иар ялын төлөвлөгөөний дүгнэлт болон гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хуулийн зүйл, ангийг зөвшөөрөхгүй, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх шаардлагатай байвал нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй захиран тушаах хурлаар хэлэлцэж, бусад тохиолдолд яллагдагчийг шүүгчийн тогтоолоор шүүхэд шилжүүлэхээр зааж байжээ⁹ (ЭБШХ, 1963 он. III хэсэг, 24 дүгээр бүлэг 219-237 дугаар зүйл).

Бэлтгэл цуглаанаар дараах асуудлыг шийддэг байжээ. Үүнд:

1. Шүүгч хэргийг ялын төлөвлөгөөний хамт прокуророос хүлээн авмагц “бэлтгэл цуглаан”-аар хянан хэлэлцүүлэхээр оруулах ёстой байсан бол яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг хэрэг хүлээн авснаас хойш шүүгчийн тогтоолоор 7 хоногийн дотор, захиран тушаах хурлаар 10 хоногийн дотор шийдвэрлэх (ЭБШХ, 1963 он. 219-221 дүгээр зүйл);
2. “Бэлтгэл цуглаан”-д хэргийн талаар прокурор илтгэгчээр оролцох буюу мөрдөн байцаагчийг бэлтгэл цуглаанд оролцуулах бөгөөд илтгэгчээр томилон явуулах эрхтэй байсан бол захиран тушаах хуралд шүүгч ялын төлөвлөгөөний дүгнэлтүүд, хуулийн зүйл, анги, таслан сэргийлэх арга хэмжээг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлийн талаар илтгэж, мөн холбогдох байгууллага, хүмүүсийн гаргасан хүсэлт, прокурорын дүгнэлтийг сонсож зөвлөлдөх тасалгаанд магадлал гаргах журмаар шийдвэрлэх;

⁹ “Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2011 он”, ХЗҮХ, ХЗДХЯ. 2012 он

3. Яллагдагч оргон зайлсан, оршин суугаа газар нь мэдэгдэхгүй байвал түүнийг олдох хүртэл, түүнчлэн яллагдагч сэтгэл мэдрэлийн буюу бусад хүнд өвчний улмаас шүүх хуралд оролцох бололцоогүй нь эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа их эмчийн магадалгаагаар нотлогдож байвал эдгэртэл нь шүүх хурлыг түдгэлзүүлэх, уг хэрэг өөр шүүхэд харьяалагдахаар байвал харьяаллын дагуу шилжүүлэх;
4. Урьдчилсан мөрдөн байцаалт бүрэн биш бөгөөд тэр нь шүүх хурлаар нөхөн гүйцэтгэх бололцоогүй, хэрэг бүртгэх буюу урьдчилсан мөрдөн байцаалт явуулах үед эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, урьд сонгосон ял дээр нэмж ял сонсгох, эсхүл ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь ялын төлөвлөгөөнд дурдсанаас онцын ялгаатай болгон өөрчлөх үндэстэй, уг хэрэгт өөр хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах үндэстэй бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлах боломжгүй, хэргийг буруугаар тусгаарласан буюу нэгтгэсэн бол нэмж мөрдөн байцаалт явуулахаар хэргийг прокурорт буцаах;
5. Хуульд заасан үндэслэл байвал хэргийг хэрэгсэхгүй болгохоор тус тус заажээ.

Монгол Улсад социализм байгуулалтын үе буюу 1960-аас 1990-ээд оныг хүртэлх үеийг авч үзвэл эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн гол зарчмуудыг хуульд тусган тогтоосон бөгөөд харин түүнийг хэрэгжүүлэх нөхцөл боломж тэр бүр хангагдаагүй байсан¹⁰ гэж дүгнэжээ. Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжлийн явцад саяхныг болтол шүүхээс өмнөх шатанд яллагдагчийг байцаахад өмгөөлөгч байлцаж, асуулт тавих, нүүрэлдүүлэх болон гэрчийг байцаахад асуулт тавих, нотлох баримт гаргаж өгөх зэрэг эрхийг эдлэхэд зарим талаар хязгаарлагдмал байдал гардаг байв. Тухайлбал, өмгөөлөгчийн нотолгооны процесст оролцох эрх шүүхийн шатанд харьцангуй боломжтой боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд нотлох баримтыг цуглуулах, шалгахад санаачилгатай,

¹⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 2011 оны. ХЗҮХ

эрх мэдэлтэй оролцох боломж хязгаарлагдмал байсан.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн үндсэн томоохон шинэчлэл нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль байсан бөгөөд тус хуулийн 226 дугаар зүйлд яллагдагчийг шүүхэд шилжүүлэхтэй холбоотой шүүхэд шийдвэрлэвэл зохих асуудлыг тусгаж өгсөн. Хэдийгээр энэ нь урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн нэртэй байгаагүй ч шүүх хурлын бэлтгэл хангахын тулд хийгдвэл зохих үндсэн ажиллагаа байсан. Тус хуулийн 226 дугаар зүйлийн 1.1-1.4-т хэрэг уг шүүхэд харьяалагдах эсэх, хэргийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэх, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох эсэх; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүх хуралдааныг явуулж болохгүй байдалд хүргэхүйц Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн явдал байгаа эсэх зэргийг шийдвэрлэхээр зохицуулж байжээ.

1.3 ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ- ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хууль зүйн яамнаас (тухайн үеийн нэршлээр) 2013 онд Гэмт хэргийн тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдийг боловсруулж, нийт 5 удаа албан ёсны санал авахаар явуулсан байна. Энэ хооронд эдгээр хуулийн төсөл үзэл баримтлалын хувьд нэг удаа өөрчлөгдөн өргөн баригдаж, батлагдсан нь бодлого боловсруулагчид эрүүгийн эрх зүйн бодлогын хувьд харилцан адилгүй байр суурьтай болохыг харуулж байна.

Тухайлбал, 2015 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь “Урьдчилсан хэлэлцүүлэг” гэсэн тусгай зүйл, хэсэгтэй байсан бөгөөд хэлэлцүүлгийг таван төрөлтэй байхаар зааж, “*due process*”-ийн үндсэн зарчмыг бүрэн тусгасан байв. Гэвч энэ хуулийг тухайн үеийн УИХ ёсчилж чадаагүйн улмаас 2017 онд ахин өөр хувилбарыг боловсруулж, ингэхдээ “урьдчилсан хэлэлцүүлэг” нь тусгай бүлэг, зүйлгүйгээр “Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх” гэсэн зүйлд тодорхой нэг хэсэг байхаар, мөн таслан сэргийлэх арга хэмжээний тухай 14 дүгээр бүлэгт цагдан хорих

таслан сэргийлэх арга хэмжээ авахад хэлэлцүүлэг хийхээр тусгасан нь ухралт болсон гэж зарим судлаач¹¹ үзсэн байна.

“Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь” судалгаанд “Эрүүгийн эрх зүйн хувьд шинээр батлагдсан хуулиудын үзэл баримтлалаас ухрахгүй байх, зарчмын гол гол ололтууд болох хохирол барагдуулах тогтолцоо, ялын шинэлэг бодлого, хүний халдашгүй эрхийг хангах, баривчлах саатуулах, цагдан хорих, мөрдөн шалгах, хууль сахиулах, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр тогтоосон хэм хэмжээнүүдийг бататгахад анхаарч, хуульч, хууль сахиулагчдын хандлагыг өөрчилж, шинэ мэдлэг олгох... шаардлагатай.” гэсэн нь судалж буй асуудалтай холбоотой бодит дүгнэлт гэж үзлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-ийг 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аас баталсан. Тус хуулийн төслийг боловсруулахдаа хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь УДШ, УЕПГ, хууль сахиулах байгууллагын бүхий л төлөөллийн оролцоог хангаж, дөрвөн жилийн хугацаанд байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэг, дэд хэсгээр хэлэлцүүлэн батлуулсан байна. Гэсэн хэдий ч ЭХХШТХ-ийн төслийг боловсруулах явцад үзэл баримтлалыг хоёр ч удаа өөрчилсөн нь анхаарал татаж байгаа юм.

1998 онд баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх явцад хэлэлцэгдэж байсан “байцаалтаас бусад аргаар нотлох, хүний халдашгүй эрхийг хуульчлан баталгаажуулж, цагдан хорих явдлыг багасгах” зэрэг асуудлууд энэ хуулийн төслийг боловсруулахад мөн яригдсан төдийгүй, “бодит үнэнийг тогтоох зарчим”-д суурилах эсхүл “мэтгэлцэх зарчим”-д суурилах тал дээр онолын болон практикийн олон хэлэлцүүлэг маргаан явагдаж, дундын хувилбарыг сонгожээ. Өөрөөр хэлбэл, “бодит үнэнийг тогтоох зарчим” бүхий хавтаст хэрэг дагадаг тогтолцоо хэвээр үлдсэн хэдий ч шүүхийн өмнөх хэлэлцүүлэг, цагдан хорих

¹¹ Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь, судалгааны тайлан. Эрүүгийн эрх зүйн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, дэд тайлан. ХЗҮХ. 2017 он

хугацааг бууруулсан, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын суурь өөрчлөлтүүд, байцаахаас бусад аргаар гэмт хэргийг нотлох, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад прокурор, шүүх зөвшөөрөл өгдөг байх зэрэг олон дэвшилтэт, зоримог өөрчлөлт хийгдсэн байна.

Өмнөх Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ)-д зааснаас өөрчлөгдсөн, мөн шинээр нэмэгдсэн онцлог зохицуулалт бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг тунхаглалын шинжтэй бус, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн тухайн шатны ажиллагаа, оролцогчийн эрхтэй холбон зааснаар уг зарчим бодитой хэрэгжих боломжтой болсон. Хуулиудын харьцуулалтыг доор хүснэгтэд харуулав.

2002 оны ЭБШХ	2017 оны ЭХХШТХ
<p>226 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд шийдвэрлэвэл зохих асуудал</p> <p>226.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ шүүгч дараах асуудлыг тодруулсан байна:</p> <p>226.1.1. хэрэг уг шүүхэд харьяалагдах эсэх;</p> <p>226.1.2. хэргийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэх;</p> <p>226.1.3. яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох эсэх;</p> <p>226.1.4. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүх хуралдааныг явуулж болохгүй байдалд хүргэх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн явдал байгаа эсэх.</p>	<p>33.1 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх</p> <p>4. Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргаагүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахгүй байж болно.</p> <p>5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг энэ хуульд заасан үндэслэлээр хаалттай явуулж болно.</p> <p>6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана:</p> <p>6.1. өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;</p> <p>6.2. хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;</p> <p>6.3. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;</p> <p>6.4. прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;</p> <p>6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;</p> <p>6.6. хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт;</p> <p>6.7. яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;</p>

227 дугаар зүйл.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед гаргасан хүсэлтийг хянаж хэлэлцэх

227.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед шүүгч нь таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, иргэний нэхэмжлэл хангах арга хэмжээ авах талаар улсын яллагч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчөөс гаргасан хүсэлтийг хянаж үзэх үүрэгтэй.

227.2. Шүүгч хүсэлт гаргасан хүмүүсээс тайлбар авч болох ба түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэнэ.

227.3. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргаж болохгүй боловч хүсэлт гаргагч шүүх хуралдаан дээр түүнийг дахин гаргаж болно.

6.8. яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;

6.9. шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт;

6.10. шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал, хүсэлт;

6.11. шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;

6.12. таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;

6.13. нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;

6.14. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;

6.15. мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;

6.16. хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;

6.17. эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.

7. Энэ зүйлийн 6.5, 6.6, 6.7-д заасан хүсэлтийг шүүх хүлээн авах үндэслэлтэй байвал хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг даруй үргэлжлүүлэн явуулж болно.

8. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

9. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ.

10. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 11.7, 11.8 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэж, прокурор, оролцогчид танилцуулна.

11. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.

12. Урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6.13, 6.14, 6.15, 6.16-д заасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг гомдол, хүсэлтийг шийдвэрлэнэ.

Шүүх хуралдааны ажиллагаа нь эрүүгийн процессын нийтэд илүү нээлттэй байдаг хэсэг тул түүний шударга үр дүнтэй ажиллагаа нь шүүх эрх мэдлийн шударга ёсны байдалд итгэх олон нийтийн итгэлийг бий болгодог. Иймд эрх тэгш байх ба шударга шүүхийн зарчмыг хангах үүднээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлж, шүүх ажиллагааны журмыг тогтоож өгсөн байна. Эдгээрийг тоймлон дурдвал:

1. Өмгөөлөгчийн явуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлэхээр тусгасан. Тухайлбал, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх тухай хүсэлт тавьж, урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргуулж болохоор заасан. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед өмгөөлөгчөөс гаргасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх санал, хүсэлтийг шүүх хангахаар тусгасан.
2. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн талаар тусгаж, энэхүү урьдчилсан хэлэлцүүлгийн тогтолцоог бий болгосноор анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас прокурорт хэрэг буцаахгүй байхаар тусгажээ. Ингэснээр Үндсэн хууль болон энэ хуульд заасан “гэм буруугүйд тооцох” зарчим хэрэгжих боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болно. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аливаа шатанд хамаарах гэм буруугүйд тооцогдох эрх нь шүүхийн шатанд чухал ач холбогдолтой. Гэм буруугүйд тооцогдох эрхийн дагуу шүүх бүрэлдэхүүн өөрийн үүргээ хэрэгжүүлэхдээ яллагдагч тухайн яллаж буй хэргийг үйлдсэн гэсэн урьдчилсан бодолтой шүүх хурлыг эхлүүлж болохгүй, гэм бурууг нотлох нь прокурорын үүрэг бөгөөд ямар нэгэн үндэслэл бүхий эргэлзээ төрвөл тэр нь яллагдагчид ашигтайгаар хэрэглэгдсэн байх, тухайн этгээдийн гэм буруу нотлох баримтаар үндэслэлтэй, эргэлзээ төрөхөөргүйгээр нотлогдсон бол гэм буруутай гэж үздэг олон улсын хэм хэмжээнд нийцүүлсэн байна. Гэвч дээрх үзэл баримтлалаас

ухралт хийж Монгол Улсын Их хурлаас 2019 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 болон 40.8 дугаар зүйлийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж эрүүгийн хэргийг прокурорт, эсхүл анхан шатны шүүхэд буцааж болох тухай зохицуулалт оруулсан байна.

3. Түүнчлэн, ЭХХШТХ-д зааснаар хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрхийг эдлэхээр заажээ. Үүнд:

- өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
- хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
- мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад эрүүгийн хэргийн оролцогчдыг хавтаст хэргийн материалтай танилцуулах талаар: Хавтаст хэргийн материалаас оролцогч хүсэлт гаргавал яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт талуудын оролцоог хангах зорилгоор шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангаж талууд хуулбарлан авсан нотлох баримтыг шүүхэд шинжлэн судлахаас өөр зорилгоор ашиглавал хүлээлгэх хариуцлагыг сануулна.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд яллах болон өмгөөлөх талын оролцоог хангах, шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүн таслах ажиллагааг шуурхай, тасралтгүй, чирэгдэлгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, процесс ажиллагааны зөрчлийг илрүүлж зөвтгөх зорилготойгоор ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хуульчлагдсан.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчдод мэдэгдэх ба хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй гэж заажээ.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үед хэргийг буруу тусгаарласан бол, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх бол, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ.

Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргаагүй, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зайлшгүй явуулах нөхцөл үүсээгүй гэж шүүгч үзсэн, талууд нэгдсэн саналд хүрсэн буюу маргаангүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах шаардлагагүй. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулахаар заасан байна.

-ХОЁРДУГААР БҮЛЭГ-

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

2.1 ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Эрх зүйн онолын үүднээс хүний эрх нь ямар ч тохиолдолд хэмжээ хязгааргүй дур зориг биш юм. Олон улсын гэрээ, конвенц болон аливаа улсын дотоодын эрх зүйн хэм хэмжээнд хүний эрх, эрх чөлөө бусдын эдлэх эрхээр хязгаарлагдах нийтлэг жишиг шаардагддаг жамтай. Орчин үед хүний халдашгүй эрхийн орон зайд нэвтрэх нөхцөл, хязгаар нь гагцхүү хуульд заасан процессын арга хэрэгслээр хангагдах ёстойг ихэнх улс орон хүлээн зөвшөөрчээ.

Төрийн эрүүгийн бодлого (*public criminal policy*) нь нийгэмд шууд нөлөө үзүүлдэг төдийгүй Эрүүгийн эрх зүйн чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад нийгмийн харилцаанд оролцогчид бодлогын шийдлийг шууд буюу шууд бусаар сонирхож байдаг. Эрүүгийн бодлого гэдэг нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг оногдуулах, эсхүл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм¹² гэж доктор С.Жанцан тодорхойлжээ.

Баруун Европ буюу эх газрын системийн онол, хандлагаар авч үзвэл өмгөөлөх тал нь нотлох баримтыг шалгах, үнэлэх эрхгүй, харин нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэхэд зарим хязгаарлагдмал эрх эдлэх ба шүүхээс өмнөх шатанд мэтгэлцээний зарчим шууд утгаар үйлчлэхгүй, харин шүүх хуралдаан дээр

¹² Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2002. т.24

мэтгэлцэх процесс нь шүүхийн дэг, шүүхийн хяналтаар дамжиж хэрэгждэг ажээ. Шүүхээс өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчийн эрхийг хамгаалж өмгөөлөгчөөр оролцох боломжтой боловч эрүүгийн процессын болон органик хууль, процедурын журмуудаар нэлээд тохиолдолд хязгаарлагдсан шинжтэй байдаг.¹³

Тэгвэл Англи-Америкийн эрүүгийн процессын онол, зарчмаар авч үзвэл хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий хуульч - өмгөөлөгч нь нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх эрхээс гадна прецедент, жишиг, хуулиар хориглоогүй нөхцөлд нотолгооны үйл явцад идэвх санаачилгатай оролцох, нотлох баримтыг шалгахад оролцох, мөн үнэлэх тохиолдолд санал хүсэлт гаргах, чөлөөт мэтгэлцээн, ялын тохиролцооны хэлбэр, зарчмыг үйл ажиллагааны гол баримтлал болгох, шүүхийн төдийгүй шүүхээс өмнөх шатанд яллагчтай харилцан ажиллах, нотолгоог хамтран явуулах зэрэг өргөн эрхтэйн дээр өмгөөллийн үйл ажиллагаа харьцангуй уян хатан, нээлттэй явагддаг байна.¹⁴

Дээрхээс дүгнэн үзвэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах чухал баталгаа бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа шударга явагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг арга болдог байна.

2.2 ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2.2.1 Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс (ОХУ) нь Европын дорнод хэсэг, Азийн хойд хэсэгт орших 89 эрх тэгш субъект буюу 21 Бүгд найрамдах улс, 6 хязгаар, 49 муж, холбооны зэрэглэлтэй 2 хот, 1 автономит муж, 10 автономит тойргоос бүрдэх холбооны улс юм. Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Ерөнхийлөгчийн засаглалтай Холбооны улс бөгөөд

¹³ Головка Л.В Реформа уголовного процесса во Франции //Государство и право 2001 №8

¹⁴ Гученко К.Ф Филипинов Б.А Уголовный процесс зарубежных государств I.,2004

хууль тогтоомж нь холбооны ба холбооны субъектуудын гэсэн хоёр түвшинтэй байдаг. Эрх зүйн хэм хэмжээний актын тэргүүнд ОХУ-ын Үндсэн хууль, дараа нь холбооны бусад хуулиуд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хуульчилсан актууд, хууль тогтоох байгууллагаас гаргасан хэм хэмжээ тогтоосон акт байна.

Оросын Холбооны Улсын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь холбооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгэн адил үйлчилдгээрээ бусад холбооны улсуудаас ялгаатай ба Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг. Мөн ОХУ-ын дээд шүүхийн бүгд хурлын удирдамж, хууль тайлбарласан акт, албан ёсоор нэгтгэн дүгнэсэн шүүхийн практик нь хууль тогтоомжийг хэрэглэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

ОХУ-д шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шүүгчдээс гадна тангарагтны 9 төлөөлөгч оролцдог. Тангарагтны төлөөлөгч нь ОХУ-ын иргэн байх бөгөөд тангарагтны төлөөлөгчийн жагсаалтад орсон, хуулиар тогтоосон журмын дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох боломжтой байна.

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2001 оны 12-р сарын 18-ны өдөр батлагдаж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Энэ хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар 38-р бүлгийн 234-239-р зүйлд анх тусгаж өгсөн байна. Энэхүү хуулиар шүүх талуудын хүсэлтээр, эсвэл өөрийн санаачилгаар дараах тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг хийхээр тусгасан. Үүнд:

1. Яллагдагчид яллах дүгнэлтийг гардуулснаас хойш долоо хоногийн дотор эрүүгийн хэргийн материалыг уншиж танилцуулсны дараа буюу эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага, хэрэг бүртгэгч хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж бэхжүүлсэн нотлох баримт нь нотлох хүчин чадлаа алддаг. Хуульд заасан

шаардлагыг зөрчиж олж авсан нотлох баримт нь хүчин төгөлдөр бус бөгөөд аливаа нөхцөл байдлыг нотлоход ашиглах яллах үндэслэл болдоггүй төдийгүй хэргийн ямар ч нөхцөл байдлыг нотлох үндэслэл болохгүй байхаар заасан.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөөгүй нотолгоо нь дараах зүйлийг агуулна. Үүнд: сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчгүй явуулсан мөрдөн шалгах ажиллагаа, өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд өмгөөлөгчтэй явуулахаар заасан ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсан, тухайн ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсныг сэжигтэн яллагдагч баталгаажуулаагүй бол; гэрч, хохирогч өөрийн таамаглал, дам сонссон ярианд үндэслэн мэдүүлэг өгсөн, мэдүүлгийн эх сурвалжаа тодорхой заагаагүй, хуулийн шаардлагыг зөрчиж мэдүүлсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдохгүй. Талуудын аль нэг нь нотлох баримтыг хүчингүйд тооцохыг эсэргүүцэж байгаа бол шүүгч эрүүгийн хэрэгт байгаа мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл болон бусад баримт бичгийг нөгөө талд танилцуулах эрхтэй.

Өмгөөлөгчийн зүгээс хуульд заасан шаардлагыг зөрчиж бэхжүүлсэн нотлох баримтыг хүчингүй болгох хүсэлт гаргасан тохиолдолд прокурор түүнийг бусад баримт сэлтийг няцаах үүрэгтэй. Харин хэрэгт авагдаагүй баримт сэлтийг үндэслэж нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргаж байгаа тохиолдолд түүнтэй холбоотой нотлох баримтыг өмгөөлөгч өөрөө гаргаж өгөх үүрэгтэй.

Хэрэв шүүгч нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байгаа бол шүүх ямар нотлох баримтыг хүчингүйд тооцож байгаа, хүчингүйд тооцох болсон үндэслэл, шүүх хуралдаан дээр тухайн нотлох баримтыг танилцуулах, шинжлэн судлахыг хориглосон тухай тогтоол гаргана.

2. Шүүгч талуудын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулж дараах тохиолдолд шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаана. Үүнд: Яллах дүгнэлт болон ялын санал нь хуулийн шаардлагад нийцээгүй, яллах дүгнэлт болон ялын саналыг яллагдагчид гардуулаагүй,

эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах үндэслэлтэй хэрэгт яллах дүгнэлт болон ялын саналд энэ тухай тусгаагүй, эдгээр тохиолдолд шүүгч гаргасан зөрчлийг 5 хоногийн дотор арилгахыг прокурорт үүрэг болгох ба ингэхдээ шүүгдэгчид оногдуулсан таслан сэргийлэх арга хэмжээг мөн шийдвэрлэнэ. Хуучин ЗСБНХУ-ын хуулиар мөрдөн байцаалтад хэргийг буцааж шийдвэрлэдэг байжээ.

3. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байвал шүүх урьдчилсан хэлэлцүүлэг явуулна.

Шүүгч дараах тохиолдолд эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана. Үүнд:

1. яллагдагч оргон зайлсан, хаана байгаа нь тодорхойгүй;
2. яллагдагч хүнд өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр нотлогдсон;
3. тухайн хэрэгт хэрэглэгдэх хуулийн талаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргасан
4. яллагдагчийн хаана байгаа нь тодорхой боловч шүүх хуралдаанд оролцох боломжгүй.

Шүүгч дараах тохиолдолд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана. Үүнд, хөөн хэлэлцэх хугацаа дууссан; яллагдагч нас барсан; гомдлоор үүсгэх эрүүгийн хэрэгт хохирогч гомдол гаргахаас татгалзсан; хэрэг хариуцах чадваргүй этгээдээс гомдол гаргасан; эрүүгийн хэрэг үүсгэх, эсвэл яллагдагчаар татахаас шүүх татгалзсан бол; прокурор яллахаас татгалзсан; талууд эвлэрсэн; цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гэмт хэргийн нийгэмд аюултай шинж чанар үгүйсгэгдсэн; талуудын аль нэгний хүсэлтээр идэвхтэй гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн зэрэг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож болно.

4. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт дараах тохиолдолд тангарагтнуудыг оролцуулж болно. Үүнд:

Мөрдөгч нь яллагдагч болон түүний өмгөөлөгчид эрүүгийн хэргийг танилцуулахдаа тангарагтнуудыг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргах эрхтэй болохыг нь тайлбарлаж өгөх ёстой. Энэ тохиолдолд мөрдөгч нь тангарагтнууд оролцох шүүх хурлын онцлог, шүүгдэгчийн эрх, шүүхийн шийдвэрийг давж заалдах журмыг тайлбарлаж өгнө. Хэд хэдэн яллагдагчтай эрүүгийн хэрэгт тангарагтны оролцоотой шүүх хурал явуулахаас зарим яллагдагч нь татгалзсан тохиолдолд мөрдөгч эдгээр яллагдагчид холбогдох эрүүгийн хэргийг тусад нь шүүхээр шийдвэрлүүлнэ. Хэрэв эрүүгийн хэргийг тус тусад нь шүүх хурал явуулах боломжгүй тохиолдолд тангарагтныг оролцуулж хэргийг хянан шийдвэрлэнэ.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнд шүүгч эрүүгийн хэргийн харьяаллыг тогтоох, прокурорт буцаах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, шүүх хуралдааныг товыг тогтоох тухай шийдвэрийн аль нэгийг гаргана.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүхэн уламжлал нь ОХУ-ын нөлөөгөөр хөгжиж ирсэн бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зарим зохицуулалтын хувьд ойролцоо, ижил төстэй зүйл, хэсгийг харьцуулан судлах, манай улсын хууль тогтоомжид байхгүй дэвшилтэт шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх боломжтой болно.

2.2.2 Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

АНУ-ын эрх зүйн тогтолцоо нь ихэнх улс үндэстэнтэй харьцуулахад илүү олон шат давхаргаас бүрддэг. Энэ нь нэг талаас хууль тогтоомжоо холбооны болон муж улсын гэж хуваадагтай холбоотой юм. Үүнийг ойлгохын тулд АНУ анх байгуулагдахдаа нэгдсэн нэг үндэстэн бус харин Британийн эзэнт улсаас тусгаар тогтнолоо олж авсан 13 колони улсын холбоо маягаар үүссэн гэдгийг санах нь зүйтэй. АНУ-ын Үндсэн хууль 1787 онд батлагдаж, 1788 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд энэхүү үндсэн хуулиар

холбооны болон муж улсуудын хууль тогтоомжийн заагийг тогтоож, Конгрессын баталж болох хуулийн төрлийг тодорхойлж өгчээ¹⁵.

Хэдийгээр Үндсэн хууль ба бусад хууль тогтоомж нь нийтлэг эрх зүйг орлодог ч шүүх Үндсэн хуульд дурдаагүй, Конгресс хуульчлаагүй асуудлаарх цоорхойг нөхөх үүднээс бичигдээгүй нийтлэг эрх зүйг ашигласан хэвээр байна. АНУ-ын хуулийг Конгрессоос батлаад зогсохгүй зарим салбарт Конгресс хуулийн тодорхой шаардлагуудад нарийвчилсан заалт нэмж батлах эрхийг захиргааны байгууллагад олгодог тогтолцоотой. Уг тогтолцоо нь АНУ-ын эрх зүйн тогтолцооны товчоон бүхлээрээ Английн нийтлэг эрх зүйн хуулийн уламжлалт зарчмууд дээр суурилдаг болохыг харуулж байгаа юм.¹⁶

Эдгээр хуулийн нэг нь АНУ-ын Холбооны эрүүгийн процессын дүрмүүд юм. Энэхүү холбооны дүрмүүд нь анх 1945 оны 3 дугаар сард хүчин төгөлдөр болсон бөгөөд хамгийн сүүлийн нэмэлт, өөрчлөлт 2018 оны 12 дугаар сарын 1-ний өдөр орсон байна. Энэхүү журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэснээс эхэлж, баривчлах, ял төлөвлөж, шүүх хурал үргэлжлэх ажиллагааг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улсын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь ял тохиролцох, гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргах, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх, шүүхийн өмнөх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны дагуу явагдах баталгаа болдог зэрэг өргөн агуулга, ач холбогдол бүхий процессын үе шат юм.

Хэдийгээр АНУ нь холбооны Эрүүгийн процессын жишиг хуультай боловч муж бүр шүүх үйл ажиллагааг зохицуулдаг хууль, журамтай. Өөрөөр хэлбэл, муж улсуудын эрүүгийн процесс, түүнийг зохицуулдаг журмууд харилцан адилгүй боловч нийтлэг нэг үзэл баримтлал, Үндсэн хуулиар тогтоосон зарчимд захирагддаг байна.

¹⁵ АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон, <https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf>

¹⁶ АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон, <https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf>

АНУ-д Эрүүгийн хэргийн шүүх хурлын өмнө мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан байхыг холбооны Үндсэн хууль болон муж улсуудын тусгайлсан хууль шүүхийн шийдвэрийн дагуу байхыг шаарддаг. Энэхүү ажиллагааг нийтэд нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэх бөгөөд өөр өөр зорилготой хэд хэдэн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж болдог байна. Ерөнхийдөө шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэгт холбогдсон тухайн хүнийг гэмт хэрэгт буруутгах хангалттай үндэслэл байгаа эсэх, байгаа бол яллагдагчаар татах, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг батлан даалтад гаргах эсэх, нотлох баримтыг хуулийн дагуу цуглуулсан эсэх, нотлох баримтыг үнэлэх, хэргээ хүлээсэн тохиолдолд ял наймаалцах, иргэдийн төлөөлөгчдийг сонгох, талуудыг мэдээллээр хангаж, шүүх хурал болохоос өмнө хэргийн талаар тодорхой шийдвэр гаргах, ял төлөвлөх эсвэл хэргийг хаах, мэтгэлцэх нөхцөлийг тодорхой болгох гэх мэт зорилгоор явагддаг бөгөөд хамгийн гол нь шүүгчдэд хэргийн талаарх бодит мэдээллийг өгөх, хүний эрхийг хангах талаар оновчтой шийдвэр гаргахад туслах зорилгоор явагддаг.

Хүний эрхийг хангасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа баривчлах үеэс эхэлдэг. Баривчлах нь төр ба сэжигтэн хооронд үүсэж буй анхны бодит харилцаа юм. АНУ-ын эрх зүйн тогтолцоогоор хоёр төрлийн баривчилгаа байдаг бөгөөд нэг нь зөвшөөрөлтэй, нөгөө нь зөвшөөрөлгүй баривчилгаа юм. Зөвшөөрлийг доод шатны шүүгчид танилцуулж шүүгч баривчлах үндэслэл байна гэж үзсэний дараа олгоно. Гэмт хэргийг цагдаагийн ажилтны нүдэн дээр үйлдсэн, эсвэл хэн нэгэн гэмт хэрэг үйлдсэн (эсвэл үйлдэх гэж байна) гэж үзэх үндэслэл тухайн мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан бол зөвшөөрөлгүйгээр баривчилж болно. АНУ-д бүх баривчилгааны 95 хувийг зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэдэг.

Урьдчилсан сонголт–Preliminary Hearing

1991 онд АНУ-ын Дээд шүүхээс баривчлагдсан хувь хүний баривчилгаа нь хууль ёсны байсан эсэхийг шүүхээр хэлэлцэхгүйгээр 48 хүртэлх цаг албадан саатуулж болно гэж заасан. Албадан саатуулагдсан этгээдэд хэрэг үүсгэх эсэхийг шийддэг дараагийн ажиллагаа бол урьдчилсан сонголт юм.

Урьдчилсан сонголт нь сэжигтнийг «гэм буруутай», «буруугүй» биш, харин түүнийг шүүх хуралдаанд оролцохыг албадах хангалттай нотлох баримт байгаа эсэхийг шийддэг «шүүх хурлын өмнөх шүүх хурал» юм. Сэжигтэн гэм буруугүй гэсэн мэдүүлэг өгсөн ихэнх тохиолдолд урьдчилсан сонголт хийгддэг бөгөөд энэ үед прокурор нь сэжигтнийг буруутгах хангалттай үндэслэл байгааг нотлох ёстой. Урьдчилсан сонголын үеэр шүүгч яллагчийн гаргаж ирсэн нотлох баримт, тангарагтнуудыг ятгаж чадаж байгаа эсэхийг хуулийн «магадлалтай шалтгаан» стандартын дагуу үнэлэн хэрэг үүсгэх эсэхийг шийддэг.

Энэ ажиллагааны үеэр ямар зүйл, хэсгээр ял сонгож, яллагдагчаар татаж байгаа тухай сэжигтэнд тодорхой мэдээлэх, Үндсэн хуулиар олгогдсон түүний бүх эрх, баталгааг мэдээлэх ёстой. Мөн сэжигтнийг барьцаагаар суллах эсэх, хэрэв тийм бол барьцаа нь ямар хэмжээтэй байхыг шийдвэрлэж тодорхойлно. Сэжигтэн барьцааны хэмжээнээс үл хамааран мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй гэж үзэж байгаа тохиолдолд барьцаагаар суллахыг хориглодог байна. Сэжигтнийг барьцаагаар суллах боломжгүй тохиолдолд батлан даалтаар суллаж болно. Энэ нь үндсэндээ сэжигтэн шүүх хурал болохоор товлосон өдөр шүүхэд ирнэ гэдгээ баталж буй хэрэг юм.

Их суудлын тангарагтны шүүх буюу урьдчилсан хэлэлцүүлэг /Grand Jury-Pretrial/

АНУ-д холбооны хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдсан бүх этгээд хэргээ их суудлын тангарагтны шүүхээр хэлэлцүүлэх эрхтэй бөгөөд энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар нэмэлт, өөрчлөлтөөр хангагдсан байдаг. Гэхдээ Дээд шүүх энэ эрхийг муж улсууд заавал биелүүлэх албагүй болохыг тогтоож өгсөн. Өнөөгийн байдлаар муж улсуудын зөвхөн тал хувь нь их суудлын тангарагтны шүүхийг хэрэгжүүлдэг бол бусад нь урьдчилсан хэлэлцүүлэг, эсвэл шалгах шүүх хурал явуулдаг (зарим муж улсад энэ хоёрыг хамтад нь хэрэглэдэг) байна. Энэ шатны гол зорилго нь яллагдагчийг албан ёсны шүүх хурлаар хэлэлцэх үндэслэл байгаа эсэхийг тогтоох явдал юм.

Их суудлын тангарагтны шүүх нь сонгогчдын бүртгэлийн жагсаалтаас сонгосон 16-23 иргэнээс бүрдэх бөгөөд тэд олонхын саналаар шийдвэр гаргана. Ийм шүүх нь нэг сараас нэг жил хүртэл ямар ч хугацаагаар ажиллаж болох бөгөөд зарим нь хугацааныхаа туршид 1000-аас илүү ч хэрэг сонсох тохиолдол байдаг. Прокурор дангаараа их суудлын тангарагтны шүүхэд нотлох баримт гаргаж өгнө. Дээрх ажиллагааны явцад буюу эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбоотой хэлэлцүүлгийн явцад өмгөөлөх тал оролцдоггүй байна. Хэрэв шүүхийн олонх үндэслэлтэй байна гэж үзвэл буруутгах гэмт хэрэг, оногдуулах ялыг сонгоно. Дээрх үндэслэл тогтоогдохгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байна.

Урьдчилсан хэлэлцүүлэг

Их суудлын тангарагтны шүүхийн тогтолцоо хэрэглэхээ больсон ихэнх муж улсад яллагдагчийн хэргийг шүүх хурлаар хэлэлцэх магадлалтай үндэслэл байгаа эсэхийг тодорхойлохын тулд урьдчилсан хэлэлцүүлэг явуулдаг. Энэ хэлэлцүүлэгт яллах тал хэргийг танилцуулж, шүүгдэгч гэрчтэй нүүрэлдэх болон өөртөө туслах нотолгоог гаргах эрхтэй байдаг.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хийгддэг гол ажиллагааны нэг бол нотлох баримтыг үнэлэх явдал юм. Шүүх эрүүгийн хэргийг шалган прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж олж авсан нотлох баримтыг хүчингүйд тооцож, хасдаг. Өмгөөлөгчөөс хуулийн шаардлагыг зөрчин олж авсан нотлох баримтыг хасуулах хүсэлт гаргавал түүнийг няцаах үүрэг нь прокурорт байдаг. Бусад тохиолдолд нотлох баримтыг үндэслэлтэйд тооцох үүрэг нь хүсэлт гаргаж байгаа талд хамаарна.

Яллах

Яллах гэдэг нь хариуцагч шүүхэд шүүгчийн өмнө их суудлын тангарагтны шүүхийн яллагаа, эсвэл прокурорын ялын төсөлд хариулах ажиллагаа юм. Прокурор эсвэл шүүхийн ажилтан ялыг ихэвчлэн нээлттэй хуралдаанд уншиж танилцуулна. Өмгөөлөгч тал нь сонгосон ялд хэд хэдэн янзаар хариулж болно. Хамгийн түгээмэл хариу нь гэм буруутай, эсвэл гэм буруугүй гэсэн хариу байдаг. Хэрэв яллагдагч өөрийгөө гэм буруугүй гэж мэдэгдвэл шүүгч

шүүх хурал явагдах өдрийг товлони. Шүүх гэм буруутай гэсэн мэдэгдлийг хүлээж авахаас өмнө шүүгч уг мэдэгдлийг хариуцагч сайн дураараа хийсэн эсэх, ийм мэдэгдлийн үр дагаврын талаар мэдэж байсан эсэхийг нягтална.

Энэ тохиолдолд ял наймаалцах боломж үүснэ. Муж улс ба холбооны түвшний аль алинд эрүүгийн нийт хэргийн 90 орчим хувийг ял тохиролцох замаар, хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг. Учир нь шүүх хурал товлосон өдрөөс өмнө харилцан тохиролцож гэм буруугийн асуудлаар маргаагүй тохиолдолд хэргийг ял тохиролцох замаар буюу яллагдагчид ашигтай байдлаар хэргийг хянан шийдвэрлэдэг. Ял наймаалцсанаар хариуцагчийн хувь заяаг шүүх хурлын өмнө шийдэж байгаа тул шүүгч зөвхөн эрх зүйн болон үндсэн хуулийн журмыг зохих ёсоор мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж оролцдог.

Яллагдагчийн хувьд ял наймаалцсанаар ялын хэмжээ буурахаас гадна шүүх хурал явагдаагүй тохиолдолд тухайн хэрэг олон нийтэд мэдэгддэггүй бөгөөд гэмт хэрэгтэн гэм буруугаа хүлээж, өөрт байгаа асуудлыг ойлгох нь засан хүмүүжих эхний алхам гэж үздэг байна.

Мэтгэлцэх журам

Урьдчилсан хэлэлцүүлгийн дараагийн чухал зорилго бол мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх боломжоор хангах явдал юм. Оролцогч талуудаас гаргасан үндэслэл, шалтгаан, түүнтэй холбоотой баримт сэлтийг харилцан танилцах боломжоор хангах нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, оролцогчдын гаргасан гомдол, хүсэлт түүнтэй холбоотой үйл баримт, хууль зүйн факттай танилцах, хариу няцаалт бэлтгэх боломжийг бий болгодог. Ингэснээр гэм буруугийн шүүх хурлын үед алдаа гарах магадлалыг багасгаж хэргийг мөрдөн байцаалтад буцааж, хэрэг шийдвэрлэх ажиллагааг сунжруулахаас урьдчилан сэргийлдэг давуу талтай.

Мэтгэлцэх журам нь хэрэг хоёр талтай байдаг гэсэн үзэл дээр үндэслэдэг. Эрүүгийн хэрэгт төр яллагдагчийг буруутай гэж ялладаг бол яллагдагч нь буруугүй гэж мэдүүлдэг. Шүүх танхимд тал бүр болсон явдлыг өөрийн талаас тайлбарладаг. Энэ журмын

үндэслэсэн онол нь хараат бус шүүгч (ба тангарагтны шүүх)-ийн өмнө нотлох баримт, үйл баримт, баталгааг бүрэн хэмжээгээр гаргаж ирэх боломжийг тал бүрт дээд хэмжээгээр олгосон тохиолдолд үнэнийг олно гэсэн үзэл юм.

Талуудыг төлөөлж байгаа хуульчид нь шүүх танхимд гол мэтгэлцэх үүргийг гүйцэтгэдэг. Шүүгч хоёр талд хууль журам, шүүх хуралдааны горимыг сахиулах үндсэн үүрэгтэй. Талууд хэргийн талаар бүх тайлбараа гаргасны дараа шүүгч шийдвэр гаргана.

2.3. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.3.1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан байдал¹⁷

Судалгааны хүрээнд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд прокуророос шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон байдалд дүн шинжилгээ хийв. Судалгаанд хамруулсан дээрх хугацаанд анхан шатны шүүхээр 5225 хэрэг хэлэлцэгдсэнээс 734 хэрэг буюу 14 хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгджээ.

Урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргээс 334 хэрэг буюу 45.5 хувийг шүүх прокурорт буцааж, 400 хэрэг буюу 55.5 хувийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Улсын ерөнхий прокурорын газраас гаргасан дээрх тоон мэдээллээс үзэхэд урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргийн бараг тал орчим хувь нь тодорхой шалтгаанаар прокурорт буцаж, тал орчим хувийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх боломжтой гэж үзэж шийдвэрлэсэн байна.

¹⁷ Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой статистик мэдээлэл нь прокурорын байгууллагын статистик судалгаанаас харагдах боломжтой учир прокурорын байгууллагын гаргасан статистик мэдээллийг авч ашигласан болно.

Анхан шатны шүүхээр хэлэлцсэн хэргийн дотор урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргийн хувь



Прокурорын хүсэлтээр 32 хэрэгт, шүүгдэгчийн өмгөөлөгчийн хүсэлт, гомдлоор 392 хэрэгт, хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлт, гомдлоор 75 хэрэгт, шүүгчийн санаачилгаар 225 хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг явуулжээ. Дээрхээс үзвэл шүүгдэгч, хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлтээр нийт урьдчилсан хэлэлцүүлгийн 65 хувийг явуулсан байна.

Талуудын урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар гаргасан хүсэлт



2.3.2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явц дахь мэтгэлцээний хэрэгжилт

Эрүүгийн хэргийг байцаан шүүдэг хуучин тогтолцооноос мэтгэлцэх зарчмаар шүүн таслах ажиллагааг явуулах шинэ тогтолцоонд шилжиж байгаа энэ үйл явц практикт ямар байдалтай байгаа, тэдгээрийн ололттой ба дутагдалтай талууд юунд байгааг олж тогтоон цаашид энэ талаар авах арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох зорилгоор ярилцлагын судалгаа явууллаа.

Судалгаанд оролцогчдын 49 хувь нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан, 37.4 хувь нь чадаагүй гэж үзжээ. Урьдчилсан хэлэлцүүлгийн явцад мэтгэлцээн хэрэгжиж чадаагүй гэж судалгаанд хамрагдсан прокурорын 39, өмгөөлөгчийн 42.1, мэтгэлцээний хэрэгжилт бүрэн бус байна гэж прокурорын 50, өмгөөлөгчийн 50.6 хувь гэж тус тус дүгнэсэн байна. Энэ нь хуулийн дагуу мэтгэлцээнийг хэрэгжүүлэгч болох шүүгчид мэтгэлцээн хэрэгжиж чадсан гэж дүгнэж байхад мэтгэлцэгч талуудын энэ талаарх дүгнэлт тэдгээрээс өөр байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 65 хувь нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг практикт хэвшил болж чадаагүй буюу учир дутагдалтай гэсэн байр суурьтай байсан юм.

Өмгөөлөгч Ц.Б “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мөрдөгчөөс нотлох баримтыг хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж бэхжүүлсэн, өөрөөр хэлбэл миний өмгөөлж байгаа яллагдагчийг төөрөгдүүлэх замаар гэрчийн мэдүүлэг авч, тэр мэдүүлгийг нь үндэслэж прокурор яллагдагчаар татаж, ял сонсгодог. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хуульд заасан журмыг зөрчиж цуглуулсан тухайн нотлох баримтыг хүчингүйд тооцуулах гэхээр хоёр талд мэтгэлцэх боломж олгодоггүй, шүүгч гагцхүү урьдчилан уншсан хүсэлт, хавтаст хэргийн хүрээнд шийдвэр гаргах гээд байдаг, гэтэл анх энэ хуулийн үзэл баримтлалыг мөрдөн шалгах тодорхой ажиллагааны талаар маргаж мэтгэж, түүнийг шийдвэрлэнэ гэж ойлгож байсан”

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцээн хэрэгжихгүй байгаа буюу мэтгэлцээн бүрэн бус хэрэгжиж байгаа шалтгааны талаар судалгаанд оролцогчид харилцан адилгүй дүгнэлт хийсэн байх бөгөөд судалгаанд оролцогчдын 41.4 хувь нь мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудыг мэтгэлцээнд оролцогчид нэг мөр ойлгож чадахгүй байгаа, 21.1 хувь нь шүүх хуралдаан даргалагч талуудад мэтгэлцэх боломж олгодоггүй, 40.2 хувь нь мэтгэлцээнд оролцогчдын мэтгэлцэх ур чадвар дутагдаж байгаа, 19.7 хувь нь хуулийн зарим заалтыг шүүхийн практикт хэрэглэхэд бодитой бэрхшээл учирч байгаа гэж дүгнэжээ.

Энэхүү асуулгад хариулсан оролцогчдын дийлэнх нь урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүх хуралдаан даргалагч талуудад мэтгэлцэх боломж олгодоггүй гэж үзжээ. Мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудын хэрэгжилт жигд бус буюу учир дутагдалтай байгаа нь хуулийн заалтуудын хэм хэмжээний хийдлээс бус ихэнхдээ шүүгч нар болон талуудын мэдлэг, ур чадвар, хандлагаас шалтгаалж байна гэж дүгнэж байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүгч хавтаст хэргийг уншсан төсөөлөл болон мэтгэлцээний үр дүнг харьцуулан шийдвэр гаргах ёстой атлаа зарим тохиолдолд шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй өөр бусад юм унших, зарим оролцогчийн ярьж буй зүйлийг таслан зогсоох, аль нэг талд ашигтай асуулт асуух зэрэг байдал арилаагүй байгаа гэж зарим оролцогч дүгнэн ярьсан.

Шүүгчдийн хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцогчдын эрх, үүргийг ухуулан ойлгуулах нь шүүхийн мэтгэлцээний хэрэгжилтийг хангах чухал үзүүлэлт юм. Зарим шүүгч оролцогчдын эрх үүргийг тайлбарлах биш зөвхөн танилцуулдаг бол зарим нь урьдчилсан хэлэлцүүлгийн учир холбогдол, үр дагаврыг маш ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгдөг гэж өмгөөлөгчид үзсэн байна. Судалгаанд шүүгчид оролцохоос татгалзсан бөгөөд энэ нь тэдний хараат бус байдалд нөлөөлнө гэж үздэгтэй холбоотой ажээ.

Судалгаанд оролцогчдын 40 хувь нь яллах, өмгөөлөх талуудын тал хувь нь л шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шийдвэрлүүлэхээр гаргасан нотлох баримтыг шинжлэх, цагдан

хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар санал хэлэх зэрэг ажиллагааг мэтгэлцэх байдлаар явуулж чаддаг гэж, 26 хувь нь цөөн тохиолдолд чаддаг гэж үзжээ. Харин ярилцлагад оролцсон прокурорын 40.2 хувь (33 прокурор) нь шүүхээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх боломжоор хангахгүй байгаа нь мэтгэлцэх боломжгүй байдалд хүргэдэг, нөгөө талд давуу байдал олгодог гэж үзжээ.

Хяналтын прокурор Б.Г: Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн гол агуулга нь тухайн мөрдөн шалгах, нотлох ажиллагаа болон цагдан хорих ажиллагааны талаар гарсан алдаа эндэгдлийг олж илрүүлэх, түүнийг засаж залруулах боломжийг аль аль талд олгодогт оршино. Ихэнх тохиолдолд өмгөөлөх талаас урьдчилсан хэлэлцүүлэг хийх талаар хүсэлт гаргахдаа тодорхой үйл баримт, сэлтийг тогтоолгох, түүнийг үгүйсгэх талаар зарим эрх зүйн хэлбэр, баримтыг гаргаж, хавсаргасан байдаг. Гэтэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт тухайн баримтыг үгүйсгэх эсхүл хүлээн зөвшөөрөх зэргээр бэлдэх, тухайн өмгөөлөгчийн гаргасан хүсэлт, баримттай танилцах ёстой. Гарааны тэгш боломж олгож байж л мэтгэлцэх зарчим явагдах учиртай. Гэтэл шүүх энэ боломжоор хангахгүй байна. Ямар асуудлаар урьдчилсан хэлэлцүүлэг хийх гэж байгааг хэлэлцүүлгийн өмнөхөн л халт, ёс төдий мэдэж амжиж байна.

Судалгаанд хамрагдагсдын 83.1% нь байцаан шүүдэг тогтолцооноос мэтгэлцүүлэн шүүдэг тогтолцоонд шилжсэн явдлыг зөв гэж үзсэн ба 14% нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцээн төлөвшиж чадсан гэж дүгнэжээ. Үүнээс үзвэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн мэтгэлцээний хэрэгжилт тааруу байна гэж дүгнэхэд хүргэж байна.

2.3.3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явагдсан эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа

1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан хууль зүйн үндэслэл, шалтгаан

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээс өмнө прокурор болон оролцогч

талуудын гаргасан хүсэлт, гомдлоор эсхүл шүүгчийн санаачилгаар хийгдэж болохоор хуульчилсан бөгөөд шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа юм.

Прокурорын байгууллагын 2019 оны эхний хагас жилийн мэдээгээр анхан шатны шүүхээр 7334 хэрэг хэлэлцэгдсэнээс 1068 хэрэг буюу 14.6 хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн байна. Урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргээс шүүх 465 хэрэг буюу 43.5 хувийг шүүгчийн захирамжаар прокурорт буцааж, 603 хэрэг буюу 56.5 хувийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гарган шийдвэрлэжээ.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн хууль зүйн үндэслэлийг судлахдаа Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зарласан 2019 оны эхний хагас жилийн тоон судалгаанаас санамсаргүй түүврийн аргаар сонгож үзэхэд дараах нөхцөл тогтоогдлоо. Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтээр 52 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.13 дахь заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдлоор 39 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.12 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтээр 31 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдлоор 27, 6.5 дахь заалтад заасан яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт 5 хэрэг;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дэх заалтад заасан өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт 2 хэрэг;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.10 дахь заалтад заасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал хүсэлтээр тус тус 2;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дэх заалтад заасан прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлтээр 1 удаа тус тус шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгджээ.

Үндэслэлийг судлан үзэхэд мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтийг давхардуулан гаргах явдал нийтлэг байна.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.2 дахь заалтад заасан хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт, 6.3 дахь заалтад заасан эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй хуульд заасан зарим нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт, 6.6 дахь заалтад заасан хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт, 6.7 дахь заалтад заасан яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт гаргасан, 6.8 дахь заалтад заасан яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол, 6.9 дэх заалтад заасан шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт, 6.11 дэх заалтад заасан шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт, 6.16 дахь заалтад заасан хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, 6.17 дахь заалтад заасан эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдлууд тус тус судалгаанд хамрагдсан газруудад гараагүй байна.

2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар санаачилсан оролцогч талуудын харьцаа

Санамсаргүй түүврийн аргаар нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн прокурорын газраас авсан тоон судалгаанаас харахад прокурорын санаачилгаар 1, шүүгдэгчийн өмгөөлөгчийн хүсэлт, гомдлоор 42, хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлт, гомдлоор 14 хэрэг, шүүгчийн санаачилгаар 51 хэрэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явагдсан байна. Эндээс дүгнэхэд шүүхийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх ажиллагаа хамгийн их буюу 47.2 хувьтай байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх тухай прокурорын санаачилга хангалтгүй байна. Тухайлбал, 2019 оны эхний хагас жилийн байдлаар прокурорын хүсэлтээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг 11 удаа л хийгдсэн байна.

Прокурор Н.Г “би хувьдаа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт таатай ханддаггүй. Ялангуяа шүүгчийн санаачилгаар хийгдэхээр бол энэ нь хэргийг шийдэхгүй, прокурорт буцаах нь тодорхой байдаг. Миний зүгээс урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэхээр санал гаргаж байгаагүй” гэжээ.

Прокурор дараах үндэслэлээр урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай санал, хүсэлт гаргахаар хуульд заасан.

1. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх;
2. Эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой (хөөн хэлэлцэх хугацаа дууссан, яллагдагч нас барсан, өмнө нь тухайн хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол магадлал хүчинтэй байгаа, үйлдэл эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон);
3. Прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах талаарх;

4. Шүүх хуралдааны товын талаарх;
5. Шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх;
6. Шүүх хуралдааныг хаалттай явуулах тухай;
7. Мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх талаарх;
8. Хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой.

Судалгааны явцад ч прокурорын зүгээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт төдийлөн ач холбогдол өгдөггүй, хэргийг прокурорт буцаах үндэслэл гэж үздэг нь харагдаж байна. Прокурор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт таагүй хандах нэг шалтгаан бол шүүхээс хэрэг буцаах нь прокурорын ажлын алдаанд тооцогддогтой холбоотой гэж үзлээ. Мөн шинээр хууль хэрэгжиж эхлэх үеэс прокурорууд аль болох урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэхээс татгалзах, энэ талаар санал гаргахгүй байх явдал түгээмэл байсан байна.

Өмгөөлөгч Ц.Х: “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг бол өмгөөлөгчид процессын явцад олгосон таатай боломж, ажиллагаа гэж үздэг. Үнэндээ мөрдөн шалгах ажиллагааны явцад нэмж ажиллагаа хийлгэх талаар үндэслэл бүхий хүсэлтийг хангахгүй байх, зарим ажиллагааг гүйцэд бус хийх тохиолдол их гардаг. Үүнийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр л зөвтгөх боломж гардаг шүү дээ. Прокурор, мөрдөгч нар мөрдөн шалгах ажиллагааны явцад тодорхой ажиллагаа хийлгүүлэх талаар гаргасан хүсэлтийг шийдвэрлээгүй мөртөө шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад худлаа тайлбар хэлдэг. Үүнээс шалтгаалж хэрэг буцахаар өмгөөлөгчөөс болж хэрэг буцлаа гэх зэргээр бидэнд таагүй ханддаг. Хүний эрхийн зөрчлийг арилгах том боломж нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэдгийг ерөөсөө ойлгохгүй байгаа нь хамгийн том бэрхшээл.

Урьдчилсан хэлэлцүүлэг бол шүүх хуралдаан биш харин шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа учраас прокурорын зүгээс аль болох урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх санал гаргаж, цаашид гарах алдаанаас сэргийлэхэд ач холбогдолтой болохыг прокуроруудад ойлгуулах, хандлагыг өөрчлөх шаардлагатай байна.

3. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хүсэлтийг шийдвэрлэсэн байдал

Судалгаанд хамрагдсан нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүх урьдчилсан хэлэлцүүлэг зарласан хэргийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар судалж үзлээ. Судалгаагаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх 52 хүсэлтээс 25, 6.13 дахь заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан 39 гомдлоос 12, 6.12 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой 31 санал, хүсэлтээс 11, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай 27 гомдлоос 2, 6.5 дахь заалтад заасан яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай 5 хүсэлт, 6.1 дэх заалтад заасан өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2 хүсэлт, 6.10 дахь заалтад заасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх оролцогчийн 2 хүсэлт, 6.4 дэх заалтад заасан прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах 1 хүсэлтийг тус тус бүрэн хангаж шийдвэрлэжээ.

Дээрх тоон үзүүлэлтээс дүгнэлт хийхэд мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгдсэн, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн нь 41 хувьтай буюу өндөр байх бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүрэн хийгдээгүй, оролцогчдын эрх хангагдаагүй байж болох нөхцөлийг засахад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой гэж дүгнэж болохоор байна.

4. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэж байгаа шалтгаан

Судалгаагаар мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгдсэн үндэслэлээр 52, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар 39, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой 31, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад

оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан талаар 27 гомдлын дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн нь нийтлэг бөгөөд энэ нь 94 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, урьдчилсан хэлэлцүүлгийн 94 хувь нь прокурорт хэргийг буцаалгах, хууль зөрчсөн зөрчлийг засуулах үндэслэлээр хэлэлцэгджээ.

5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шүүх хуралдааны бэлтгэл бүрэн хангагдаж байгаа эсэх

Санамсаргүй түүврийн аргаар 10 прокурортой урьдчилсан хэлэлцүүлгийн талаар санал солилцож, санаа бодлыг нь сонсоход бүгд урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэний дараа шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа бүрэн хангагддаг гэсэн болно. Түүнчлэн урьдчилсан хэлэлцүүлгээр орсон хэрэг дараа нь шүүх хуралдаанаар хэлэлцэхэд илүү амар болдог төдийгүй нотлох баримтуудыг эргэж санахад дөхөмтэй байдаг талаар нийтлэг үзэл бодолтой байлаа. Харин шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэргийг прокурорт буцаах шийдвэрээс шалтгаалж прокурорын ажлын үнэлгээнд сөрөг нөлөөлдөг нь хэлэлцүүлгээс зайлсхийхэд хүргэж байна. Тиймээс прокурорын ажлын үзүүлэлтийг дүгнэдэг байдлыг эргэн харах шаардлагатай тухай саналыг зарим оролцогчид илэрхийлж байсан.

Прокурор нь урьдчилсан хэлэлцүүлэгт ашиглах зорилгоор эрүүгийн хэргээс шаардлагатай нотлох баримтыг хуулбарлах, мөн хэргийн түүвэр хийх зэргээр асуудал нэг бүрийг урьдчилан бэлтгэсэн байвал зохих хэдий ч одоогийн практикт урьдчилсан хэлэлцүүлэг гэнэт зарлагддаг, урьдчилсан хэлэлцүүлэг хийх болсон үндэслэл, шалтгааныг шүүхээс прокурорт мэдэгддэггүйгээс прокурор бэлтгэлгүй орох нь элбэг байна. Зарим тохиолдолд эрүүгийн хэрэгтэй танилцаж амжихгүй, хэргийн ачааллаас хамаараад шүүгчээс ямар нэг шалтгаангүй урьдчилсан хэлэлцүүлэг гэнэт зарлаж хэрэг буцаадаг тухай оролцогчдын ярьсныг дүгнэн үзвэл хуулийн анхны үзэл баримтлал, хүний эрхэд суурилсан хандлага хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Прокурор А.А: “Шүцхээс ямар үндэслэлээр урьдчилсан хэлэлцүүлэг зарласан эсэхийг мэдэгдэхгүй хурлын зар гаргадаг. Хэргийн оролцогч шүцхэд ямар үндэслэлээр урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх тухай хүсэлт гаргасныг мэдэгддэггүй тул урьдчилсан хэлэлцүүлгийн бэлтгэл ажил бүрэн хангагдаж чаддаггүй. Түгнчлэн яллагдагчаар татаагүй өөр хэрэгтэй нэгтгэх үндэслэлээр шүцхээс хэргийг прокурорт буцааж зэргээр хэргийн шийдвэрлэлтийг удаашруулдаг. Уг нь нотлогдсон хэрэг бүрийг шийдвэрлэж болохоор шинэ хуулиар зохицуулсан хэдий ч шүцгдэгчийн эрх зүйн байдал дордож байна гэж үзээд заавал нэгтгэн шийдвэрлэх шаардлагыг зарим шүцгч тавьдаг” гэжээ.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товын талаар прокурорууд нэлээд санал шүүмжлэл гаргаж байлаа. Тухайлбал, Эрүүгийн хуульд заасан “нэг хэрэгт нэг удаа ял оногдуулах” зарчмын хүрээнд зөвхөн тухайн шалгагдаж байгаа хэргийг нотлогдсон байдлаар нь шийдвэрлэхээр заасан байтал яллагдагч, шүүгдэгчээс урьд өмнө нь эсхүл тухайн цаг мөчид өөр гэмт хэрэг нэмж үйлдсэнийг заавал хамтатган шалгах шаардлагатай гэж шүүхээс үзэж байгаа нь хэрэг шийдвэрлэгдэхгүй байх үндсэн нөхцөл болж байна. Шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаадаг хуулийн зохицуулалт орсноос хэрэг шийдвэрлэгдэхгүй удах, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусаж ял завших нөхцөл байдал үүсэж байгаа таагүй дүр зураг ажиглагдлаа.

Улсын Ерөнхий прокурорын газрын Шүцхэд төрийг төлөөлөх хэлтсээс хийсэн судалгаанд “Практикт шүцх урьдчилсан хэлэлцүүлгийн товыг тогтоохдоо прокурорын саналыг харгалздаггүй, саналыг авдаггүй, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурорт ирцүлдэггүй, зарим тохиолдолд утсаар мэдэгддэг, заримдаа урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хэргүүдийн товыг тухайн 7 хоногт хийх шүцх хуралдааны товд оруулан мэдэгддэг боловч ихэнх урьдчилсан хэлэлцүүлгийг 1 хоногийн өмнө эсхүл хэргийг хүлээн авсан тухайн өдөртөө мэдэгдэж, эсхүл шүцхэд шилжүүлсэн хэргийн хэлэлцүүлгийг өдөрт нь хийхээр товыг гаргаж, урьдчилсан хэлэлцүүлэг явуулдаг зэргээр урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө товыг прокурорт мэдэгдэх талаарх ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн заалтыг зөрчдөг” гэж дүгнэжээ.

Шүүх хуралдааны бэлтгэл ажлын буюу урьдчилсан хэлэлцүүлэг хийх үндэслэлүүдийн нэг болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6.9 дэх заалтад заасан шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт гаргах ажиллагаа хангалтгүй явагддаг гэж дүгнэхээр байна. Товын талаар санал, хүсэлт гаргах нь талууд шүүхтэй зөвшилцөн шүүх хурал хойшлогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлж өгдөг сайн талтай.

“Шүүх зайлшгүй тохиолдолд л урьдчилсан хэлэлцүүлэг зарладаг, үзэмжийн асуудал байхгүй, хэргээ уншихаас төвөгшөөж урьдчилсан хэлэлцүүлэг зарладаг зүйл байхгүй, хийх эсэх нь шүүгчийн бүрэн эрхийн асуудал гэж өөрсдөө дүгнэдэг” гэж ярилцлагад оролцогч прокуроруудын зүгээс үзсэн байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь хэдий хоёр тал мэтгэлцэх зарчмаар хэргийг мөрдөн шалгах үйл явц шударга явагдсан эсэхийг шийдвэрлэх “хэлэлцүүлэг” боловч талууд өөр өөр байр суурьтай байна. Тухайлбал, өмгөөлөгчдийн зүгээс өмгөөлөгчийн эрх үүргийг бусад хуульд заасан хэдий ч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг бол хамгийн гол ололт, мөрдөн шалгах ажиллагаа үнэн, зөв явагдсан эсэхийг шийдүүлэх гол “зэвсэг”, шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “амин зүрх” гэж үздэг байна. Ийнхүү шүүгч, прокурор, өмгөөлөгч тал өөр өөр өнцгөөс урьдчилсан хэлэлцүүлгийг дүгнэж байгаа нь шинэ хуулийн сургалт тааруу явагдсантай холбоотой байж болохоор байна. Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг баталснаас ердөө сарын дотор сургалтыг яаравчлан хийсэн нь одоо ч асуудал үүсгэж байна.

Прокурор Г.А: “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх товын талаар санал гаргаж байгаагүй ч урьдчилсан хэлэлцүүлэгт энэ талаар хэлэхэд шүүх огт хэрэгсээгүй. Би эмнэлэгт хэвтэхээр төлөвлөсөн өдрүүд байсан бөгөөд энэ талаар санал хэлэхэд өөр прокурор оролцуул гэсэн утгатай хариу хэлсэн. Тэгээд ч ямар нэгэн шийдвэр гаргаагүй. Миний зүгээс энэ талаар санал, хүсэлт гаргах арга хэлбэрийг мэдэхгүй байна. Цаашид нарийвчилсан байдлаар зохицуулах нь зүйтэй байх” гэжээ.

Үүнээс үзэхэд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх бэлтгэл ажиллагаа болон түүний товыг тогтоох талаар практик тогтоогүй, эрх зүйн зохицуулалтын хувьд цаашид нарийвчлан авч үзэх шаардлагатай нь харагдаж байна. Хэргийн яллах, өмгөөлөх талууд ийнхүү товын талаар санал, хүсэлтээ илэрхийлэхгүйгээс шүүх санаачилгаараа урьдчилсан хэлэлцүүлэг зарлах, нөгөө талаас прокурор, өмгөөлөгч нар нь хэргийн менежментийн талаар суурь ойлголтуугийгээс аливаа асуудалд эмх цэгцтэй хандах хандлагад суралцаж чадахгүй байна гэж дүгнэхээр байна.

Шүүх хуралдааны бэлтгэл хангахтай холбоотой дараагийн нэг анхаарах асуудал бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дах хэсгийн 6.11 дэх заалтад заасан шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт юм.

Шүүх хуралдааныг төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх, өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх гэж байгаа бол, хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах зэрэг тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болдог. Мөн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, хүний нууцтай холбоотой ялангуяа бага насны хүүхдэд хүндээр тусч болох аливаа асуудалд прокурор, өмгөөлөгч нарын зүгээс мэдрэмжтэй хандаж шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлтийг гаргаж байх шаардлагатай байна. Гэтэл энэ талаар хүсэлт гаргасан тохиолдол байхгүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Түүнчлэн шүүх хуралдааны бэлтгэлтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дах хэсгийн 6.10 дах заалтад заасан шүүх

хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал хүсэлттэй холбоотой буюу шүүх хуралдаанд нотлох баримтыг шинжлэн судлахад ямар техник, тоног төхөөрөмж шаардлагатай болох, тэдгээрийг хэрхэн хэлэлцэх талаар санал, хүсэлт гаргах ажиллагаа хангалтгүй байна.

6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр оролцогч талуудын эрх хангагдаж байгаа эсэх, хэрэг шударга шийдэгдэх боломж бүрдэж байгаа эсэх

Санамсаргүй түүврийн аргаар 10 прокурортой урьдчилсан хэлэлцүүлгийн талаар санал солилцож, санаа бодлыг нь сонсоход урьдчилсан хэлэлцүүлгээр талуудын эрх хангагддаг гэсэн хариулт өгсөн. Урьдчилсан хэлэлцүүлэг талуудын тэгш эрхийн үндсэн дээр явагдаж хэвшсэн байна. Харин анхаарах ёстой нэг чухал асуудал бол өнөөдөр нийт хэргийн бараг 60 орчим хувь нь өмгөөлөгчгүй буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

Тухайлбал, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг зарим тохиолдолд өмгөөлөгчгүй явагдаж байгаа бөгөөд шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа гэснээр улсын яллагчтай мэтгэлцдэг жишиг тогтсон байна. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч ямар тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаанд заавал оролцох, хэрэв өмгөөлөгчгүй мөрдөн шалгах ажиллагаа явуулсан тохиолдолд түүнийг хэрхэн баталгаажуулах эсхүл үгүйсгэх тухай зохицуулалт байхгүйгээс дээрх нөхцөл байдал үүссэн байна. Ийнхүү өөрийгөө өмгөөлж байгаа яллагдагчийн хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт орсноор яллагдагчийн эрх бүрэн хангагдах боломжгүй юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогчид Монгол Улсын “Үндсэн хууль”-иар олгогдсон эрх юм. Иймд цаашид яллагдагчийг өмгөөлөгчтэй оролцуулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

7. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар оролцогч талууд болон прокурор, шүүгчдийн зөрүүтэй байр суурь

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь яллагдагчийг шүүхэд шилжүүлэхээс өмнө шүүх хуралдааны бэлтгэлийг хангах зорилгоор хийгдэх ажиллагаа бөгөөд прокурор, оролцогч талуудын гаргасан хүсэлт, гомдлоор эсхүл шүүгчийн санаачилгаар хийгдэх ажиллагаа юм.

Одоогийн практикт гарч байгаа асуудал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дах хэсэг буюу урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дах хэсгийн 6.13 дах заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дах заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ гэдэг заалтаас урган гарч байна. Учир нь шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа болох урьдчилсан хэлэлцүүлгийн дийлэнх нь эдгээр асуудлаар хийгдэж байгаа нь түүвэр судалгаанаас харагдаж байгаа бөгөөд хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Өөрөөр хэлбэл, нэгэнт энэ талаар маргаан өрнөсөн бол анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс илүүтэйгээр хэргийг прокурорт буцаахыг урьтал болгож байна.

Прокурор А.А “Хэргийн оролцогч нар урьдчилсан хэлэлцүүлгийн явцад яллагдагчийн гэм буруу, эрцүгийн хариуцлагын талаар маргадаг нь урьдчилсан хэлэлцүүлгийн зорилгод нийцэхгүй бөгөөд оролцогчид зөрцүтэй байр суурьтай оролцдог гэж би боддог. Өөрөөр хэлбэл, гэм буруугийн талаар ярьж маргадаг нь урьдчилсан хэлэлцүүлгийн зорилгод нийцэхгүй гэж боддог. Учир нь гэм буруугийн талаар ярьж маргахад шүүгчийн байр суурь урьдчилсан хэлэлцүүлэг дээр өөрчлөгдөж юу ч гэсэн буцаагаад үзье гэдэг байдлаар хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцааж байгаа нь анзаарагддаг” гэжээ.

Урьдчилсан хэлэлцүүлэг нь нөгөө талаас шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа тул цаг хугацааны хувьд их биш байх нь зохистой. Гэтэл дээрх маргааны улмаас урьдчилсан хэлэлцүүлэг удаашрах, прокурорын зүгээс өмгөөлөгчтэй мэтгэлцэх, нотлох баримт бүрээр тайлбарлах зэргээр шүүх хуралтай яг адилхан болдог тохиолдлууд гардаг байна.

Прокурор Н.Б “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт сайн бэлдэхгүй бол яг шүүх хурал шиг хийгддэг. Хэрвээ прокурор маш их манлайлан өмгөөлөгчийн гаргасан асуудал бүрээр сайн мэтгэлцэж чадвал шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гаргадаг, харин прокурор сайн хамгаалж чадахгүй бол шүүх шүүд л хэргийг буцаадаг юм шиг санагддаг. Гэтэл урьдчилсан хэлэлцүүлэгт ямар хүсэлт, гомдол гаргасныг шүүх бидэнд мэдэгддэггүй тул барьц алдах, сандрах үе зөндөө л гардаг” гэжээ.

8. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах талаар эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг буюу урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дахь хэсгийн 6.13 дах заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дах заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ гэдэг заалтыг боловсронгуй болгож, энэ талаарх хүсэлт дээр талууд эсрэг байр суурьтай бол хүсэлтийг хэлэлцэхгүй орхих гэсэн өөрчлөлт оруулах;
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон шалтгаан, үндэслэлийн талаар талуудад урьдчилан мэдэгдэх, бэлтгэх боломжийг хууль тогтоомжоор хангах;

- Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт гаргах нь зөв эсэх, одоогийн практикт энэ заалт хэрэгжихгүй байгаа ба прокуророос хэргийг шүүхэд шилжүүлсний дараа хэрхэн ял тохиролцох нь тодорхой бус байдаг тул энэ заалтыг хасах;
- Шүүхээс прокурорт хэрэг буцаах зохицуулалтыг эргэн харж, байгаа нотлогдсон хэмжээнд хэргийг шийдвэрлэх үзэл санааг бататгах;
- Одоогийн практикт шүүх яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарсны дараа талууд болон оролцогчийн хүсэлтийг хүлээн авч урьдчилсан хэлэлцүүлэг явуулаад байгаа асуудал гарсаар байгаа тул яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарсны дараа урьдчилсан хэлэлцүүлэг хийж болохгүй гэсэн заалт оруулах;
- Урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан тогтоож байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай өмгөөлөгч, оролцогчдын гомдол, хүсэлт, шүүгчийн захирамжийг прокурорт заавал хүргүүлдэг байх, шүүх өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулахдаа үндэслэл нь тодорхойгүй байдгийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

ДУГНЭЛТ

Хууль эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал

- 1) Эрүүгийн хэргийн оролцогч талууд болон шүүх энэ ажиллагааны талаар өөр өөр байр суурьтай байгаа нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн “due process” -ийг хангах ач холбогдлыг бууруулж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай асуудлыг орхигдуулж байна. Тухайлбал, шүүх өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг хийхдээ шүүхийн өмнөх процесс шударга явагдсан эсэхэд ач холбогдол өгөхөөс илүү хэргийн ачааллаа бууруулахад ашиглаж байгаа бол, прокурорын хувьд энэ ажиллагаа нь ажлын ачааллын үндсэн шалтгаан, ажлын үнэлгээг бууруулах хүчин зүйл болдог тул огт хэрэггүй процесс гэж үзэх хандлага давамгайлж, харин өмгөөлөгч өөрийн хүсэлтийг хангах, хэргийн шийдвэрлэлтийг удаашруулах хэрэгсэл болгон ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч талууд урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдлыг ойлгоогүй байна.
- 2) Хэдийгээр хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх 17 үндэслэлийг заасан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар үндэслэл журмыг, ямар хэлбэрээр зөрчсөн тохиолдолд явуулах тухай иш татаж, тодорхой заагаагүйгээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлтийг хэрэг бүр дээр гаргах хандлага ажиглагдаж, шүүхийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлж байна. Энэхүү тодорхойгүй байдал нь хуулийн үзэл санаа, ач холбогдлыг алдагдуулж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хэргийг буцаах, өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, сунжруулах зорилгоор ашиглах нөхцөл болж байна. Жишээлбэл, яллагдагч талаас мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогчийн эрхийг зөрчсөн гэсэн ерөнхий үндэслэлийг ашиглаж үндэслэлгүйгээр прокурорын ачааллыг нэмэгдүүлж байгаа нь судалгааны явцад тогтоогдлоо.

- 3) Мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан зөрчил дутагдал, алдаа эндэгдэл, эрүүдэн шүүсэн байж болзошгүй нөхцөлийг зөвтгөх шаардлагатай эрүүгийн хэргүүдэд дээрх хэлэлцүүлэг шүүхийн ачааллаас шалтгаалаад бодитойгоор хэрэгжиж чадахгүй байна.
- 4) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх нарийвчилсан журам байхгүйгээс талууд нотлох баримтыг буюу хэлэлцүүлэг явуулах асуудлын талаар мэдээлэлгүй оролцож байгаа нь мэтгэлцэх зарчим хэрэгжих боломжийг хааж байна. Өөрөөр хэлбэл, урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хоёр талыг тэгш боломжоор хангахгүй байгаагаас хэлэлцүүлгийн үр дүн буурч байна. Тухайлбал, шүүхээс оролцогч талуудын хүсэлтээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх шийдвэр гаргасан тохиолдолд хэлэлцүүлгээс өмнө тухайн хүсэлт, түүнтэй холбоотой баримт сэлтийг харилцан танилцуулахгүй байх, шүүгч өөрийн санаачилгаар зарласан тохиолдолд ямар асуудлаар урьдчилсан хэлэлцүүлэг хийх болсон тухайгаа бусад оролцогчдод танилцуулахгүй байна.
- 5) Ярилцлагын судалгаанаас үзвэл хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй байхад шүүх ажлын ачааллаас шалтгаалан хойрго хандаж өөрийн санаачилгаар шаардлагагүй эрүүгийн хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, хэргийг буцааж шийдвэрлэж байна.
- 6) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлтэд зааснаас өөр асуудлыг нэмэлтээр шийдвэрлэж оролцогчийн эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр гаргаж байна. Тухайлбал, нотлох баримтыг хүчингүй болгох, оролцогчийн эрхийг зөрчсөнтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх талаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шийдвэр гарсан тохиолдол байна.
- 7) ОХУ, АНУ-ын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар эрх зүйн орчныг судлан үзвэл хүнийг хууль бусаар, хилс хэрэгт холбогдуулан шалгах явдлыг шийдвэрлэх, таслан зогсоох зорилгоор олон шатны урьдчилсан хэлэлцүүлэг хийж байна. Өөрөөр хэлбэл, хүнийг хэрэгт холбогдуулан шалгахгаас

эхлээд урьдчилсан хэлэлцүүлгийг өргөнөөр ашиглан хүний эрхийг хангах тогтолцоог бүрдүүлж байна. Жишээлбэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээх буюу эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хууль ёсны байсан эсэх, тухайн шийдвэрийг хүчинтэйд тооцох эсэх асуудлыг олон шатны шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хувийн болон улс төрийн зорилгоор хүн, хуулийн этгээдэд үндэслэлгүйгээр хэрэг үүсгэн шалгаж, удаан хугацаанд чирэгдүүлэх, эрхийг зөрчих явдлаас сэргийлэх зорилгоор эрүүгийн хэргийн анхан шатнаас шүүхэд шилжүүлэх хүртэл үе шатанд тухайн шийдвэр хууль бус байсан эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай.

Зохион байгуулалт, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудал

- 8) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар хандлага өөрчлөх, ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг хуульчдад зохион байгуулах шаардлагатай байна.
- 9) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс оролцогчдын хүсэлтийг хангаж, мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр эрүүгийн хэргийг прокурорт буцаах тухай шийдвэрийг прокурорын ажлын үзүүлэлтийг бууруулах үндэслэлд тооцохгүй байх, энэ нь хүний эрхийг хангах талаар шүүхээс гаргаж буй шийдвэр гэдгийг анхаарч, харилцан нэг ойлголттой болох нь зүйтэй.
- 10) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед хууль зөрчиж, эсхүл эрүүдэн шүүж авсан мэдүүлэг, нотлох баримт гэх мэт хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж цуглуулсан нотлох баримтыг хүчингүйд тооцох боломжийг олгох нь зүйтэй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дах хэсэг буюу урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дах хэсгийн 6.13 дах заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дах заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх

хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ хэмээн заасан. Гэтэл урьдчилсан хэлэлцүүлгийн дийлэнх нь эдгээр асуудлаар хийгдэж, хэргийг буцааж шийдвэрлэж байгаагаас үзэхэд хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна гэж дүгнэлээ.

- 11) Шүүх хуралдааны бэлтгэлтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дах хэсгийн 6.10 дахь заалтад заасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал хүсэлттэй холбоотой буюу шүүх хуралдаанд нотлох баримтыг шинжлэн судлахад ямар техник, тоног төхөөрөмж шаардлагатай болох, тэдгээрийг хэрхэн хэлэлцэх талаар санал, хүсэлт гаргах ажиллагаа хангалтгүй байна.
- 12) Монгол Улсад эрүүгийн хэргийн хөдөлгөөний менежмент, эрүүгийн хэргийн стандарт байхгүйгээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэх үндэслэл байгаа эсэхийг тодорхойлж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2019, 2020 онуудад орсон нэмэлт, өөрчлөлтөөр шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаадаг эрх зүйн зохицуулалтыг эргэн халах нь зүйтэй гэж судалгаанд оролцогчдоос үзсэн бөгөөд эрүүгийн процессын амин чухал үзэл санаа болох хүний эрхэд суурилсан мөрдөн шалгах ажиллагааг шүүхээс баталгаажуулах, оролцогчдод “гарааны тэгш боломж олгох”, мэтгэлцэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хууль, эрх зүйн орчны хүрээнд

- 1) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар зөрүүтэй байр суурь, хэрэглээний явцад хүндрэл бэрхшээлийг арилгахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлсан бүлэг болгон оруулах нь зүйтэй байна. Энэхүү тусгайлсан бүлэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго, ач холбогдол, шийдвэрлэх асуудал, арга хэлбэр, үе шатын талаар дэс дараатайгаар тусгах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭХХШТХ-д яллагдагчийг шүүхэд шилжүүлэх хэсэгт нэг хэсэг байхаар заасан нь энэ үйл ажиллагааны ач холбогдлыг бууруулж байна гэж дүгнэхээр байна.
- 2) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах талаар гомдол, хүсэлтэд тавигдах шаардлага, үндэслэлийг тодорхой болгох. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар үндэслэл, журмыг, ямар хэлбэрээр зөрчсөн тухай үйл баримт, мэдээлэл, бусад эх сурвалжийг гаргах тухай зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.
- 3) Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан алдаа, эндэгдлийг зөвтгөх, хүний эрхийн зөрчлийг арилгах үүднээс урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүгчийн гаргах шийдвэрийн төрөл, хэлбэрийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Тухайлбал, урьдчилсан хэлэлцүүлгийн явцад нотлох баримтыг хүчингүйд тооцох, хүний эрхийн зөрчилтэй холбоотойгоор зарим шийдвэрийг өөрчлөх, тодорхой ажиллагаа хийхийг даалгах зэрэг шийдвэр гаргах боломжийг олгох нь зүйтэй. Өнөөгийн байдлаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шүүгч идэвхгүй байр сууринаас хандах буюу ямар нэг шийдвэр гаргахгүйгээр зөвхөн хүсэлтийг хүлээн авах байдлаар шийдвэрлэж, хүсэлт үндэслэлтэй бол хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж байна.

- 4) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх үүднээс оролцогч талуудаас гаргасан хүсэлт болон шүүгч өөрийн санаачилгаар явагдах хэлэлцүүлгийн үндэслэл, шалтгаан, түүнтэй холбоотой баримт сэлтийг харилцан танилцах боломжоор хангах зохицуулалтыг нэмж тусгах. Өөрөөр хэлбэл, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, оролцогчдын гаргасан гомдол, хүсэлт түүнтэй холбоотой үйл баримт, хууль зүйн факттай танилцах, хариу няцаалт бэлтгэх боломжийг агуулсан журмыг ЭХХШТХ-д тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад тухайн хэлэлцэж байгаа асуудлаас өөр ямар нэг асуудал буюу таслан сэргийлэх арга хэмжээ эсхүл өөр нотлох баримтын тухай хэлэлцэхгүй байх тухай хориглолт, хязгаарлалтыг тусгах
- 6) Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын аль ч шатанд урьдчилсан хэлэлцүүлэг хийх боломжоор хангах нь зүйтэй байна. Өнөөгийн байдлаар хэлэлцүүлгийг зөвхөн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх явцад, шүүх хурлын бэлтгэл ажлыг хангахын тулд дээрх ажиллагааг явуулж байгаа бөгөөд мөрдөгч, прокуророос хэргийн удаан хугацаанд шалган шийдвэрлэж, хэргийг яллах явцад хэт нэг талыг баримталж байгаа субъектив хүчин зүйлийг зөвтгөх боломжгүй байна. Иймээс хүнийг хэрэгт холбогдуулан шалгах, удаан хугацаанд чирэгдүүлэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад гарах хүндрэл, бэрхшээлээс сэргийлэх зорилгоор урьдчилсан хэлэлцүүлэг хийх хүрээг өргөтгөх шаардлагатай.

Зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах чиглэлээр

- 7) Мөрдөгч, прокурор, шүүгчийн сургалтын агуулгыг шинэчлэх, нэг агуулга хэлбэрээр хандлага өөрчлөх, шинэ мэдлэг олгох, мэдлэгийг шинэчлэх, ур чадвар олгох сургалт зохион байгуулах. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн чиглэлээр зохион байгуулж байгаа хуульчийн үргэлжилсэн сургалт, прокурор, өмгөөллийн байгууллагын дотоод сургалтад

“Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” гэсэн тухайлсан сэдвээр, сургалтын хөтөлбөр, модуль, сургагч багш бэлтгэх;

- 8) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд хэргийг шийдвэрлэсэн байдлыг харгалзан прокурорын ажлын үзүүлэлтийг бууруулах үндэслэлд тооцохгүй байх, мөн энэ чиглэлээр прокурорын хяналтын ажилтай холбоотой зарим аргачилсан зааврыг өөрчлөх шаардлагатай.
- 9) Урьдчилсан хэлэлцүүлэг хийх цаг, зардал хэмнэсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэх өөрөөр хэлбэл мөрдөгч, прокурор, шүүгчийг цахим гарын үсгийг ашиглах боломжоор хангах, харилцан мэдээлэл солилцох цахим орчин (портал сайт) үүсгэж, ашиглах замаар хэргийн ачааллыг 20-30 хувиар бууруулах.
- 10) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад нотлох баримтыг шинжлэн судлах, тодорхой үйл баримтыг хэлэлцэж, мэтгэлцэх боломжийг хангахын тулд техник, тоног төхөөрөмжөөр хангах.
- 11) Хэргийн хөдөлгөөний менежментийг /case management/ бий болгох, хөгжүүлэх. Тухайлбал, хүн, хуулийн этгээдээс мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, прокурор, шүүхийн хооронд хэргийг шилжүүлж байгаа талаар, эсхүл тодорхой шийдвэр, нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, урьдчилсан хэлэлцүүлгийн талаар мэдээлэл авах, хурлын тов, шүүх хурлын бэлтгэл ажилтай танилцах, тухайн хэргийг шалгаж, шийдвэрлэж байгаа албан тушаалтантай харилцах зэрэг боломжоор хангах тогтолцоог хөгжүүлэх.
- 12) Эрүүгийн хэргийн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх. Тухайлбал, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, мөн тухайн хэрэгт хийгдвэл зохих ажиллагаа /checklist/ явагдсан эсэхийг хянах аргачлалыг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг үнэлэх, due process-ийг хангах, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах үндэслэл бий эсэхийг тогтоох, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс зохих шийдвэр гаргах ач холбогдолтой.

СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Амарсанаа Б., Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2005 он
2. Минжүүрдорж Б., Даяаршиж буй дэлхий: Харьцуулсан эрх зүй судлал УБ. 2010 он
3. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ. 2001 он
4. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг УБ. 2011 он
5. Сүхбаатар Ж., Харьцуулсан эрх зүй УБ. 2000 он
6. Отгончимэг Н., Харьцуулсан эрх зүй УБ. 2001 он
7. Осакве К., Харьцуулсан эрхзүй судлал: Ерөнхий ба тусгай анги УБ. 2005 он
8. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрхзүйн тогтолцоо олон улсын Симпозиумын илтгэлүүдийн эмхтгэл УБ. 2000 он
9. Давид Р., Основные правовые системы современности. М., 1988.
10. Тихомиров В.А., Курс сравнительное правоведения. М., 1996
11. Сайдов А.Х., Сравнительное правоведение. М., 2007
12. Подред Сухарев А.Я., Правовые системы стран мира. М., 2001
13. <https://www.uscourts.gov/>
14. <http://www.asil.org/resource/pill.htm>
15. <http://www.lib.uchicago.edu/~llou/global.html>
16. <http://europa.eu.int/eurodicautom/Controller>
17. <http://www.lexml.de/rdf.htm>
18. <https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf> АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон
19. Penny Darbyshire, Edey and Darbyshire on the English Legal system, Sweet and Maxwell, 7th ed., 2001
20. Terence Ingman, English Legal Process, Oxford University Press, 9th ed., 2002
21. S.H. Bailey etc., Smith, Bailey and Gunn on the Modern English Legal system, Sweet and Maxwell, 4th ed., 2002
22. English Private Law, Vol. I, ed. Peter Birks QC FBA, Oxford University Press, 2000
23. Richard L. Abel, Legal profession in England and Wales, Blackwell, 1988

24. M. Partington, Introduction to the English Legal System, 2nd ed., Oxford University Press, 2003 (2000)
25. G. Slapper, D. Kelly, The English Legal System, 6th ed., Cavendish Publishing Limited, 2003 (1994)
26. Richard Ward, Walker & Walker's English Legal system, Butterworths, 8th ed., 1998
27. Margaret Z. Johns, Rex R. Perschbacher, The United States Legal System, Carolina Academic Press, 2002
28. William Burnham, Introduction to the Law and Legal system of the United States, 3rd ed., West group, 2002
29. Introduction to the law of the United States, ed. David S. Clark etc., 2nd ed., Kluwer Law International, 2002
30. S. A. Riesenfeld and W. J. Pakter, Comparative law casebook, Transnational publishers, Inc., 2001
31. Fallon, Richard H., Hart, Henry Melvin, and Wechsler, Herbert. Hart and Wechsler's the Federal Courts and the Federal System, 5th ed. New York, NY: Foundation Press, 2003.
32. См. Лукашевич В.З. Назначение судебного заседания по новому УПК РФ, х. 166.
33. Постановление КС РФ от 8 декабря 2003 // Рос. газета. 23 декабря. 2003г. 3.
34. См.: Комментарий к УПК РФ подред. Лебедева, Божьева. М. 2003. С.455.
35. См., например: Лазарев В.А. Предварительное судебное производство. - М. С.54.

ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН
ХАСАХ АРГАЧЛАЛЫН
ХЭРЭГЛЭЭ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДЛААЧ: Б.МӨНХДОРЖ, Хууль зүйн
доктор, математикийн магистр

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ.....	62
1. УДИРТГАЛ.....	63
1.1. Судалгааны үндэслэл, шаардлага.....	63
1.2. Судалгааны зорилго, зорилт	64
1.3. Судалгаа хийсэн хугацаа, арга зүй, хамрах хүрээ	65
1.4. Судалгааны үр дүнгийн төсөөлөл	66
2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ	67
2.1. Эрүүгийн хууль буцаан хэрэглэх онолын үндэслэл.....	67
2.2. Аргачлалыг хэрэглэх тохиолдлуудын томъёолол	70
2.3. Аргачлалыг практикт хэрэглэсэн нь	77
ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ.....	82
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	86
ХАВСРАЛТ	87

ТОВЧИЛСОН ҮГ

- ШЕЗ Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
УДШ Улсын дээд шүүх

-НЭГДҮГЭЭР БҮЛЭГ-

УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 07 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн. Эрүүгийн хуулийн 1.9¹-ийн 1-д “үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ”, мөн зүйлийн 3-д “шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна” гэж тус тус заасан. Мөн Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна” гэж зохицуулсан болно.

Тиймээс Монгол Улсын шүүх хуучин Эрүүгийн хуулиар хорих ял эдэлж байсан ялтнуудын ялыг шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн хасахдаа хорих ялыг дүйцүүлэн хасах математик статистикийн аргачлалыг² практикт хэрэглэсэн юм. Өмнө нь хорих ялыг дүйцүүлэн хасахдаа “интервалын арга”, “ялын дундаж коэффицентийн арга” зэргийг хэрэглэж байсан нь эрүүгийн хуульд заасан шударга ёсны, хууль ёсны зарчим зөрчигдөж байжээ.

Хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах ойлголт, аргачлалыг нэг мөр тайлбарлаж, практикт жишиг тогтоох санал, шийдэл гаргах замаар бодит ажил хэрэг болгох нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах соёлыг төлөвшүүлэхэд нэн шаардлагатай алхам юм.

¹ 1.9 дүгээр зүйл. Хууль буцаан хэрэглэх.

² Математик-статистикч, хууль зүйн доктор Б.Мөнхдоржийн 2016 онд зохиосон.

Иймд хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлал, түүний хэрэглээг онолын үндэслэл, практик талаас нарийвчлан судалж, дүгнэлт, бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх субъектэд хандсан зөвлөмж гаргах шаардлага байв.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Судалгааны зорилго

Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлал, түүний хэрэглээг онолын үндэслэл, практик талаас нарийвчлан судалж, дүгнэлт, бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх субъектэд хандсан зөвлөмж гаргахад оршино.

Судалгааны зорилт

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан дахь хууль буцаан хэрэглэх онолын үндэслэлийг судлах;
2. Хорих ялыг дүйцүүлэн хасах математик статистикийн аргачлал, түүнийг хэрэглэх тохиолдлуудын томъёоллыг тайлбарлах;
3. Аргачлалыг практикт хэрэглэсэн байдалд дүн шинжилгээ хийх;
4. Аргачлалыг шүүхийн практикт нэг мөр хэрэглэх, боловсронгуй болгох талаар дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж боловсруулах;
5. Судалгааны үр дүнг нэгтгэн тайлан хэлбэрээр хэвлүүлж, олон нийтийн хүртгээл болгох.

1.3. СУДАЛГАА ХИЙСЭН ХУГАЦАА, АРГА ЗҮЙ, ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны ажлыг тоон болон чанарын судалгааны арга, тодруулбал баримт бичиг, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, онолын эх сурвалжийг харьцуулан судлах, математик статистикийн аргыг ашигласан.

Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ)-аас хорих ялыг дүйцүүлэн хассан талаар холбогдох тоон судалгаа, мэдээллийг албаны шугамаар гаргуулан авч, үр дүнд дүн шинжилгээ хийж, тайланд тусгав. Холбогдох судалгаа, мэдээллийг авахаар Улсын дээд шүүх (УДШ)-д хандан хүсэлт гаргасан боловч тодорхойгүй шалтгааны улмаас гаргаж өгөөгүй болно.

Харин чанарын судалгааны хувьд ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 3, УДШ-ийн 3 шүүгч, аймаг, дүүргийн анхан шатны шүүхийн 4 шүүгч, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгч, ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 3 алба хаагч, эрүүгийн эрх зүйн чиглэлийн 8 эрдэмтэн, судлаач, нийт 22 хүнтэй уулзаж, хийсэн ярилцлагын³ үр дүнд тулгуурлан энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээний тухайд зөвхөн хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлал, томьёолол, түүний хэрэглээ, онолын үндэслэлийг авч үзсэн болно. Хорих ял нь өөр төрлийн хөнгөн ял болж өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү аргачлал хэрэглэгдэхгүй. Мөн торгох, баривчлах, зорчих эрхийг хасах зэрэг хорихоос өөр төрлийн ял авсан ялтны ялыг дүйцүүлэн хасах асуудал энд хамаарахгүй болно. Үйлдсэн гэмт хэрэг нь шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон тохиолдолд шууд суллагдах тул мөн л судлах зүйлд үл хамаарна.

³ Хорих ялыг дүйцүүлэн хасахад математик статистикийн аргачлал, томьёог хэрэглэсэн үү, хэрэв тийм бол уг аргачлалын давуу болон сул талыг дурьдана уу, цаашид хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг боловсронгуй болгох, хэрэглээг сайжруулах арга замын хүрээнд ярилцсан болно.

1.4. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Судалгааны үр дүнд хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалын онолын үндэслэлийг тайлбарлаж, түүний хэрэглээг шүүхийн практикт нэг мөр, жишиг байдлаар хэрэглэх бодлогын зөвлөмж боловсруулж, бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх субъектэд хандаж буйгаараа судалгааны үр дүн тодорхойлогдох юм. Түүнчлэн, хорих ялыг дүйцүүлэн хасах асуудлыг шударга ёс, хууль ёсны дагуу хийх судлагдахууны эрүүгийн эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачдын хүрээнд оруулж байгаагаараа чухал ач холбогдолтой. Мөн хорих ялыг дүйцүүлэн хасах талаар УДШ-ээс гарах Эрүүгийн хуулийн тайлбарт тодорхой заалтууд орбол энэхүү судалгааны ажлын үр өгөөж илэрхийлэгдэх юм.

-ХОЁРДУГААР БҮЛЭГ-

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ БУЦААН ХЭРЭГЛЭХ ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эрүүгийн хууль буцаан хэрэглэх асуудлыг эрдэмтэн, судлаачид өөрсдийн ном бүтээлдээ тайлбарласан байдаг. Тэдний дундаас эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны тэргүүлэх эрдэмтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор С.Жанцан “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь нэгэнт батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээг уг хууль хүчин төгөлдөр болохын өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт хэрэглэх үйл ажиллагаа”⁴ гэж тодорхойлжээ.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх шаардлага нь эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, эсхүл тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох явцад тодорхой гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн агуулгатай хэм хэмжээ шинээр тогтоосон тохиолдолд бий болно. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх ойлголтын нэг хэсэг болох “тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялыг хөнгөрүүлсэн хууль гэдэг нь өмнөх эрүүгийн хуульд тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг эрүүгийн хуулиар, эсхүл түүний санкцид нэмэлт, өөрчлөлт хийсэн хуулиар хөнгөрүүлсэн байх бүх тохиолдол юм” гэжээ⁵.

Ялын төрөл хэмжээг хөнгөрүүлсэн хууль гэдэгт:

- Өмнөх хуулиар тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээг доош нь татсан;
- Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан ялын доод хэмжээг доош татсан;

⁴ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 170 дахь тал.

⁵ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 172 дахь тал.

- Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан ялын дээд, доод хэмжээг нэг зэрэг доош татсан;
- Тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан тодорхой төрлийн ялыг хөнгөн ялаар сольсон;
- Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан хэд хэдэн төрлийн ялуудаас хүнд ялыг нь хүчингүй болгосон;
- Тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан нэмэгдэл ялыг хүчингүй болгосон зэрэг тохиолдлуудыг хамааруулжээ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль гэдэг нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэл, нөхцөлийг хөнгөрүүлсэн субъектийн хувьд эерэг үр дагавар бий болгож байгаа хэм хэмжээ гэж тодорхойлжээ⁶. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь шинээр батлагдсан хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт шинэ болон урьд үйлчилж байсан хуулиудын аль хөнгөнийг хэрэглэх явдал бөгөөд *ex post facto* буюу шинэ хуулийг түүнээс өмнөх үйл баримтад хэрэглэх гэсэн зарчмыг удирдлага болгодог байна. Шинэ хуулиар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн бол хуулийг буцаан хэрэглэдэг. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон бол шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийг ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлж, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн бол ялыг шинээр тогтоосон хэмжээнд дүйцүүлэн хасах хэлбэрээр хуулийг буцаан хэрэглэнэ гэж тайлбарлажээ⁷.

Эрүүгийн хуулийн хууль ёсны, шударга ёсны зарчим нь тус хуулийг буцаан хэрэглэхэд зайлшгүй дагаж мөрдөгддөг. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн түгээмэл зарчим болох хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим мөн мөрдөгдөх ёстой. Энэ нь хүн бүр нэг адил хэргийн төлөө ойролцоо хариуцлага хүлээнэ гэсэн үг юм.⁸ Гэвч энэ нь нэг ижил хэрэгт

⁶ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 172 дахь тал.

⁷ УДШ-ээс нийт шүүгч нарт хүргүүлсэн зөвлөмж. 2017.07-р сард.

⁸ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 33 дах тал.

хүлээлгэх хариуцлагыг тэгшитгэнэ гэсэн үг биш бөгөөд үйлдсэн хэрэг, учирсан хор уршиг адил байвч гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан ялыг ялгавартай оногдуулах нь тэгш эрхийн зарчим хэрэгжиж байгаагийн нотолгоо юм. Тиймээс эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхдээ эдгээр зарчмыг чанд мөрдөхөд математик статистикийн аргачлалыг хэрэглэх нь зайлшгүй гэж үзсэн.

Монгол Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлтийг тус тус баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөж эхэлсэн билээ. Шинэ Эрүүгийн хуулиар ялын бодлогыг зөөлрүүлсэн, уян хатан болгосон, ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлсэн өөрчлөлтүүд мөн гарсан юм.⁹ Тиймээс ч судлаачид гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэхээс илүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг нийгэмшүүлэх, энэрэнгүй ёсны зарчмыг мөрдлөг болгосон хууль болсон гэж үздэг¹⁰.

Шинэ Эрүүгийн хуулийн 1.9¹¹-ийн 1-д “үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ”, 3-т “шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна” гэж тус тус заажээ. Эдгээр хуулийн заалтыг үндэслэн ялтны ялыг шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн хасах, ялаас чөлөөлөх ажиллагаа хийгдсэн юм.

Ийнхүү ялтны ялыг дүйцүүлэн хасахад оновчтой, зөв аргачлалыг хэрэглэх нь шүүхийн шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах, ялтнуудад ялгамжтай бус хандах боломжийг бий болгож, улмаар Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчимд нийцэж байгаа билээ.

⁹ <http://medee.mn/main.php?eid=92525>.

¹⁰ <http://www.today.mn/p/31426>.

¹¹ Эрүүгийн хууль, 2015 он, 1.9 дүгээр зүйл. Хууль буцаан хэрэглэх.

2.2. АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДЛУУДЫН ТОМЬЁОЛОЛ

Улсын дээд шүүхээс хорих ялыг 2017 онд дүйцүүлэн хасахдаа “ялын дундаж индексийг ашиглах”, эсхүл “ялын интервалаар хуульд нийцүүлэн хасах”, бидний судалж буй “математик статистикийн аргачлал” зэрэг олон арга, аргачлал, хувилбарыг харьцуулан судалж, нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэний үндсэн дээр энэхүү “математик статистикийн аргачлал”-ыг сонгон хэрэглэх шийдэлд хүрсэн байдаг.

Улмаар УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас аймаг, нийслэлийн шүүхүүдэд хорих ялыг хэрхэн дүйцүүлэн хасах, чөлөөлөх талаарх зөвлөмж, хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал, үндсэн томьёог мөн хүргүүлжээ. (Хавсралт)

УДШ-ийн 3 шүүгчтэй хийсэн ярилцлагаас дүгнэн үзэхэд дээрх аргачлалуудаас математик статистикийн аргачлал нь хууль ёс, шударга ёсны зарчимд илүүтэй нийцнэ хэмээн үзэж сонгосон гэж байв.

Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалд үндсэн 1 томьёо байх бөгөөд Эрүүгийн хуульд нийцүүлэн уг томьёог 4 өөр тохиолдолд хэрэглэхээр хувилбаруудыг боловсруулсан. Үндсэн томьёо бол математик статистикийн шинжлэх ухааны “шугаман регрессийн шинжилгээний арга”-ын тэгшитгэлийн үндсэн зарчим дээр боловсруулагдсан болно.

Математик статистикийн аргачлалаар хорих ялыг дүйцүүлэн хасахдаа жилээр тооцох бөгөөд сар, хоногоор тооцох тохиолдолд нэг жилийг 365 хоногт шилжүүлэн тооцох байдлаар боловсруулсан юм.

Аргачлалын үндсэн томьёо:

X_1 - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	Y_1 - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
X_2 - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	Y_2 - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ
$\Delta X = X_2 - X_1$ - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын интервал	$\Delta Y = Y_2 - Y_1$ - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын интервал

Дээрх хувьсагчаар илэрхийлсэн үзүүлэлтийг ашиглан хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын нэгж хэмжээнд харгалзах шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын хэмжээг илэрхийлэх коэффициентийг гаргана.

Өөрөөр хэлбэл, хорих ял дүйцүүлэх коэффициент:

$$K = \frac{\Delta Y}{\Delta X} = \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} \quad \text{/Томьёо 1/}$$

X^* - Тухайн ялтанд хуучин Эрүүгийн хуулиар оногдуулсан хорих ял

Y^* - Шинэ Эрүүгийн хуулиар буурах хорих ял. Өөрөөр хэлбэл, хуучин Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулж, одоо хорих ял эдэлж буй ялтны ялын хэмжээ шинэ Эрүүгийн хуулиар хэрхэн буурах нь бидний тооцоолохыг хүсэж буй судалгааны үр дүн юм.

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны хорих ялын хэмжээ хэрхэн буурахыг томьёо 2-ыг ашиглан бодно.

$$Y^* = Y_1 + K * (X^* - X_1) = Y_1 + \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} * (X^* - X_1) \quad \text{/Томьёо 2/}$$

Судалгааны явцад хуучин, шинэ Эрүүгийн хуулиар хорих ялын доод, дээд хэмжээ өөрчлөгдсөн байгаа учраас 4 өөр тохиолдолд томьёо.2-ыг ашиглан ялын хэмжээг бууруулна. Эрүүгийн хуулийг

буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дордуулахгүй, харин дээрдүүлэх байдлаар үзүүлэлтийг ашиглана.

Нэмж тодотгол хийхэд УДШ-ээс нийт шүүгч нарт зориулан боловсруулж, анхан болон давж заалдах шатны шүүгч нарт хүргүүлсэн “Хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал”-д “Ялыг дүйцүүлэн хасах тухай” захирамж гаргахад дээрх томъёо.2-ыг ашиглахыг тайлбарлан оруулсан байдаг. (Хавсралт.2-оос дэлгэрэнгүй үзнэ үү)

УДШ-ээс “Хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал”-ын хэсгээс..... ”

....Шинэ Эрцүгийн хуулиар дүйцсэн ялын хэмжээг тодорхойлохдоо /Ядүйц/ эхлээд ял дүйцүүлэх коэффициентыг /Кдүйц/ олно. Энэ нь шинэ Эрцүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрцөг /ШЯдээд-ШЯдоод/ өмнөх Эрцүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрцөг /ХЯдээд-ХЯдоод/ харьцуулсан харьцаа /хуваасан/ байна. Уг коэффициентыг /Кдүйц/ өмнөх хуулиар оногдуулсан ял /Яөмнөх/, ялын доод хэмжээ /ХЯдоод/ хоёрын зөрцөгээр үржүүлж шинэ ялын доод хэмжээн дээр /ШЯдоод/ нэмнэ.

Өөрөөр хэлбэл:

Ядүйц = Кдүйц * (Яөмнөх - ХЯдоод) + ШЯдоод

Кдүйц = (ШЯдээд-ШЯдоод)/(ХЯдээд-ХЯдоод)....”

Аргачлалыг хэрэглэх тохиолдлуудын томъёолол:

Дээрх үндсэн томъёо.1, 2-г ялын дээд, доод хэмжээний өөрчлөлтөөс хамааран дараах 4 өөр хувилбараар ялыг дүйцүүлэн хасаж тооцно. Үүнд:

Тохиолдол 1

Өгөгдөл

5 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	2 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
10 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	10 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ?

$X^* = 6$ жил бол $Y^* = 2 + \frac{8-2}{10-5} * (6 - 5) = 3.2$ (хуучин ЭХ-иар 6 жилийн ял авсан ялтны ял 3.2 жил болж буурах үр дүн гарч байна)

$X^* = 5$ жил бол $Y^* = 2 + \frac{8-2}{10-5} * (5 - 5) = 2$ (хуучин ЭХ-иар 5 жилийн ял авсан ялтны ял 2 жил болж буурах үр дүн гарч байна, өөрөөр хэлбэл хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээтэй адилхан болж буурна)

$X^* = 10$ жил бол $Y^* = 2 + \frac{8-2}{10-5} * (10 - 5) = 8$ (хуучин ЭХ-иар 10 жилийн ял авсан ялтны ял 8 жил болж буурах үр дүн гарч байна)

$X^* = 7.5$ жил бол $Y^* = 2 + \frac{8-2}{10-5} * (7.5 - 5) = 5$ (хуучин ЭХ-иар 7 жил 6 сарын жилийн ял авсан ялтны ял 5 жил болж буурах үр дүн гарч байна)

Тохиолдол 2

Өгөгдөл

5 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	2 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
10 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	14 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ?

Энэ тохиолдолд ЭХ-ийг буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээг хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээгээр тооцож бодно.

$$X^* = 6 \text{ жил бол } Y^* = 2 + \frac{10-2}{10-5} * (6 - 5) = 3.6 \text{ жил}$$

$$X^* = 5 \text{ жил бол } Y^* = 2 + \frac{10-2}{10-5} * (5 - 5) = 2 \text{ жил}$$

$$X^* = 10 \text{ жил бол } Y^* = 2 + \frac{10-2}{10-5} * (10 - 5) = 10 \text{ жил}$$

$$X^* = 7.5 \text{ жил бол } Y^* = 2 + \frac{10-2}{10-5} * (7.5 - 5) = 6 \text{ жил}$$

Тохиолдол 3

Өгөгдөл

5 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	6 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
10 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	8 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ?

ЭХ-ийн буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээг хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээгээр тооцож бодно.

$$X^* = 7 \text{ жил бол } Y^* = 5 + \frac{8-5}{10-5} * (7 - 5) = 6.2 \text{ жил}$$

$$X^* = 5 \text{ жил бол } Y^* = 5 + \frac{8-5}{10-5} * (5 - 5) = 5 \text{ жил}$$

$$X^* = 10 \text{ жил бол } Y^* = 5 + \frac{8-5}{10-5} * (10 - 5) = 8 \text{ жил}$$

$$X^* = 7.5 \text{ жил бол } Y^* = 5 + \frac{8-5}{10-5} * (7.5 - 5) = 6.5 \text{ жил}$$

Тохиолдол 4

Хуучин Эрүүгийн хуулийн 551 дүгээр зүйлд¹² зааснаар хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ? гэдгийг энэ хувилбараар тооцоолно. Хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан тохиолдолд хуучин, шинэ Эрүүгийн хуулийн ялын өөрчлөлтийн коэффициентийг ашиглан шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг олж тооцож болно.

Мөн тооцоолол хийхдээ хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүнээс багаар оногдуулсан ялын хэмжээгээр авна.

Өгөгдөл

5 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	2 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
10 жил-Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	8 жил-Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ

$$Y^* = \frac{X^* * Y_1}{X_1} + \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} * (X^* - X_1) \text{ /Томьёо.3/}$$

¹² 551 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах.

551. 1.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна. /Энэ зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/.

$\frac{X^* \cdot Y_1}{X_1}$ - хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан нь шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг бууруулах коэффициент

$$X^* = 3 \text{ жил бол } Y^* = \frac{3 \cdot 2}{5} + \frac{8-2}{10-5} * (3 - 3) = 1.2 \text{ жил}$$

$$X^* = 4 \text{ жил бол } Y^* = \frac{4 \cdot 2}{5} + \frac{8-2}{10-5} * (4 - 4) = 1.6 \text{ жил}$$

Хуучин Эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд хуучин, шинэ Эрүүгийн хуулийн ялын өөрчлөлтийн коэффициентийг ашиглан шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг тооцоолон олж тохиолдол 4 дэх томъёогоор тооцож бодно. Мөн тооцоолол хийхдээ хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүнээс багаар оногдуулсан ялын хэмжээгээр авна. Жишээ нь, хуучин Эрүүгийн хуулиар 5-10 жилийн хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөнгөрүүлэн 4 жилийн хорих ял оноосон тохиолдолд тухайн гэмт хэргийн шинж нь шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн тооцоход ялын интервал нь 2-8 жил болсон бол ялыг дүйцүүлэн хасаж 1.6 жил болно. Хэрэв 5 жилийн хорих ял авсан бол 2 жил болж хасагдах тооцоо гарч байна.

Гэвч УДШ-ийн болон анхан шатны зарим шүүгчтэй хийсэн ярилцлагаас дүгнэхэд 4 дэх тохиолдолд ялтны ялыг харилцан адилгүй хасах талаар шүүгч нар ойлголтын зөрүүтэй байгаа байдал ажиглагдсан. Тухайлбал, Шүүгч Ч.Хосбаяр хэлэхдээ “хуучин эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд шинэ эрүүгийн хуулийн ялын доод хэмжээнд ялыг дүйцүүлэн бууруулна, учир нь дээрх жишээн дээр 3, 4, 5 жилийн ял оногдуулсан байсан ч шинэ эрүүгийн хуулийн ялын доод хэмжээ болох 2 жилийн ял адилхан болж буурах ёстой” гэв. Энэ дүгнэлттэй судлаачийн хувьд санал нийлэхгүй байгаа бөгөөд бидний боловсруулсан аргачлал хууль ёс, шударга ёсны зарчимд илүүтэй нийцнэ гэж үзэж байгаа юм. Энэ аргачлал нь анхны оролдлого байсан бөгөөд цаашид улам сайжруулан хөгжүүлэх нь хэн бүхэнд нээлттэй юм.

Хуучин Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулсан¹³ ялын хэмжээг хэрхэн бууруулах талаар аргачлал байхгүй бөгөөд шаардлагатай бол тохиолдол 4-ийг ашиглан бодох боломжтой. Энэ тохиолдолд хуучин Эрүүгийн хуулийн ялын доод, дээд интервалыг ерөнхий ангид журамласнаар дахин тооцоолж бодох шаардлага үүснэ.

2.3. АРГАЧЛАЛЫГ ПРАКТИКТ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Шинэ Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг 2017 онд хангах хүрээнд 2017 оны 7 дугаар сард Эрүүгийн хуулийн тэгшитгэлд хамруулах ажлыг УДШ, ШЕЗ, ШШГЕГ-аас зохион байгуулжээ.

ШШГЕГ-ын албан ёсны судалгаа, мэдээлэл

2017 оны 7 дугаар сарын байдлаар нийт 41 хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийт 4829 ялтан ял эдэлж байсан. Эдгээрийн 2746 ялтны хорих ялыг дүйцүүлэн хассан судалгаа, мэдээлэл байна¹⁴.

¹³ 60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулах.

60.1.Шүүх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулахдаа гэмт санаагаа хэрэгжүүлсэн хир хэмжээ, завдалт төгссөн эсэх, бэлтгэсэн буюу завдсан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хир хэмжээ, гэмт хэргээ туйлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана.

60.2.Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна./Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

60.3.Гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна. /Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

60.4.Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүй.

¹⁴ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны мэдээлэл

График 1. Эрүүгийн хуулийн тэгшитгэлд хамрагдан суллагдсан хоригдлын судалгаа



Эх сурвалж: ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх алба

Дээрх графикаас үзэхэд нийт ялтны 56.9 хувьд, хорих ангид үлдсэн бусад ялтны 80.6 хувьд нь хорих ялыг дүйцүүлэн хассан судалгаа байна.

Харин хорих ялыг дүйцүүлэн хассан ялтнуудын ямар төрлийн гэмт хэрэг үйлдсэн талаарх судалгаа, улмаар тохиолдол 1, 2, 3, 4-өөр хасагдсан талаар судалгаа нарийвчлан гарах боломжгүй гэж тус байгууллага хариу өгсөн болно.

ШЕЗ-ийн албан ёсны судалгаа, мэдээлэл

Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэний дараагаар 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар эрүүгийн хуулийн тэгшитгэлийн талаарх тоон мэдээллийг нийт эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс ШЕЗ авсан байна.

Анхан шатны шүүхүүдэд 25 хорих анги, 14 шийдвэр гүйцэтгэх албанаас 4878 ялтны материалыг шилжүүлэн, улсын хэмжээнд дүүрэг, сум дундын нийт 28 шүүхийн 70 гаруй шүүх бүрэлдэхүүн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, гэмт хэрэгт тооцохгүй болсон

үйлдэл, эс үйлдэхүйд ял шийтгүүлсэн этгээдийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх, оногдуулсан ял нь тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал дүйцүүлэн хасах шийдвэрийг 2017 оны 7 дугаар сард гаргасан байдаг.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанаас нийт 4878 ялтны материал хүлээн авсанаас 4124 ялтны ялыг дүйцүүлэн хассан байна.

График 2. Эрүүгийн хуулийн тэгшитгэлийн тоон мэдээлэл



Эх сурвалж: ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

Улсын хэмжээнд 4124 ялтны хорих ялыг 2015 оны хуулийн зохих зүйл хэсэгт оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнд дүйцүүлэн хасаж, үүнээс 1050 ялтныг суллаж, үлдсэн 3074 ялтны хорих ялыг дүйцүүлэн хасажээ.¹⁵ Эндээс үзэхэд нийт ялтны 84.5 хувьд ялыг дүйцүүлэн хассан байна.

¹⁵ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл

ШЕЗ нь дээрх судалгааг үүнээс илүү нарийвчлан гаргах боломжгүй гэсэн хариу өгсөн бөгөөд холбогдох судалгаа, мэдээллийг авахаар УДШ-д хандсан ч тодорхойгүй шалтгааны улмаас гаргаж өгөөгүй болно.

ШЕЗ-ийн Мэдээллийн технологийн хэлтэс нь бидний боловсруулсан математик статистикийн аргачлалыг хялбаршуулах үүднээс хуучин болон шинэ Эрүүгийн хуулийн интервалыг 100 хэсэгт хуваан, харгалзуулах байдлаар *excel* програм дээр томъёолол хийн шүүхүүд рүү хүргүүлсэн нь уг аргачлалыг шүүх, шүүгч нар хэрэглэхэд хялбар болгож, цаг хугацаа хэмнэсэн ажил болжээ. Энэ нь шүүгч нар болон ШШГЕГ-ын тоо бүртгэлийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын судалгаагаар баталгаажиг байгаа юм.

Зураг 1. Хорих ялыг дүйцүүлэн хасах тооцоолол /excel программд оруулсан хувилбар/

		Бүтэц		Хуучин ял		Шинэ ял	
		Дээд хязгаар	Доод хязгаар	Жил	хоног	Жил	хоног
Хуучин хууль /өдрөөр/		3650	1095	0,3	109,5		
Шинэ хууль /өдрөөр/		2920	730				
Хуучин хууль /жил/		10	3				
Шинэ хууль /жил/		8	2				
Та доорх заавартай танилцна уу							
Хуучин хуулийн дээд хязгаарыг D 14 нүдэнд оруулна							
Хуучин хуулийн доод хязгаарыг E 14 нүдэнд оруулна							
Шинэ хуулийн дээд хязгаарыг D 15 нүдэнд оруулна							
Шинэ хуулийн доод хязгаарыг E 15 нүдэнд оруулна							
Ногоон талбар дээрх 4 нүдэнд л утга оруулна бусад нүдэнд утга оруулахгүй. Хажуугийн таблицаас хуучин хуулиар оноосон ялын дүйцэх тоог олж тухайн мөрний шинэ хуулиар олгогдох ялыг тодорхойлно. Энэ арга нь хуучин болон шинэ хуулийн интервалыг 100 хэсэгт хувааж харгалзуулсан болно. Бүр нарийвчлан 500, 1000 хэсэгт хувааж тооцоолох файл бэлдэх ч боломжтой.							
Н баганад хуучин хуулийн ялыг жилээр, I баганад хуучин хуулийн ялыг хоногоор илэрхийлсэн. К баганад шинэ хуулийн ялыг хоногоор, L баганад шинэ хуулийн ялыг жилээр илэрхийлсэн.							
Анхаарах асуудал: Н болон L багануудад жилээр илэрхийлсэн байдал нь 10-тын бутархай тул сар өдөрт жилжүүлэхдээ анхааралтай хандана уу. Жишээ: Н баганад 5,5 жил гэж байгаа бол 5 жил 6 сар юм.							
				10	3650	2920	8
				9,93	3624,45	2898,1	7,94
				9,86	3598,9	2876,2	7,88
				9,79	3573,35	2854,3	7,82
				9,72	3547,8	2832,4	7,76
				9,65	3522,25	2810,5	7,7
				9,58	3496,7	2788,6	7,64
				9,51	3471,15	2766,7	7,58
				9,44	3445,6	2744,8	7,52
				9,37	3420,05	2722,9	7,46
				9,3	3394,5	2701	7,4
				9,23	3368,95	2679,1	7,34
				9,16	3343,4	2657,2	7,28
				9,09	3317,85	2635,3	7,22
				9,02	3292,3	2613,4	7,16
				8,95	3266,75	2591,5	7,1
				8,88	3241,2	2569,6	7,04
				8,81	3215,65	2547,7	6,98
				8,74	3190,1	2525,8	6,92
				8,67	3164,55	2503,9	6,86
				8,6	3139	2482	6,8
				8,53	3113,45	2460,1	6,74
				8,46	3087,9	2438,2	6,68
				8,39	3062,35	2416,3	6,62

ШШГЕГ-ын мэдээллээр 2746 ялтны ялыг, ШЕЗ-ийн мэдээллээр 4124 ялтны ялыг дүйцүүлэн хассан албан ёсны судалгаа мэдээлэл байна. Иймд эдгээр байгууллагуудын мэдээллийн уялдааг сайжруулах, эрүүгийн хуулийн тэгшитгэлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн тоон мэдээллийг бодитой гаргах шаардлага байгаа нь зайлшгүй судалгааны явцад ажиглагдав.

ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 3 удирдлага, ажилтан, УДШ-ийн 3 шүүгч, аймаг, дүүргийн анхан шатны шүүхийн 4 шүүгч, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгч, ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 3 алба хаагч нартай хийсэн ярилцлагаас, мөн УДШ-ийн Эрүүгийн хэргнийн танхимаас анхан шатны шүүхэд хүргүүлсэн зөвлөмж, аргачлалаас дүгнэхэд үзэхэд бидний судалж буй “математик статистик”-ийн аргачлал, томъёог хорих ялыг дүйцүүлэн хасахад 2017 онд бүрэн хэрэглэжээ.

ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

Энэ аргачлалыг хэрэглэсний давуу болон сул талыг судалгааны эх сурвалжид үндэслэн тодорхойллоо.

Давуу тал:

1. Хорих ялыг дүйцүүлэн хасахад Эрүүгийн хуульд заасан “хууль ёс, шударга ёсны, хууль буцаан хэрэглэх” зарчмууд үр дүнтэй хэрэгжсэн.
2. Шүүх, шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ажилтнуудаас хорих ялыг дүйцүүлэн хасах талаар материал бүрдүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагааг хөнгөвчилсөн, үүнд зарцуулах цагийг хэмнэсэн; тухайлбал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн материалд үндэслэн бэлэн аргачлалын дагуу бодоод шүүгч шийдвэр гаргаж байгаа нь шүүгч талдаа, мөн ялтан талдаа ойлгомжтой байдлыг бий болгосон гэж шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтнууд ярилцлага хийхэд илэрхийлж байсан.
3. Хорих ялтай ялтнуудын хувьд ялын хэмжээ нь шударгаар хасагдсанд сэтгэл ханамжтай байсан нь давж заалдах шатанд гаргадаг гомдол, санал өмнөх түвшингээс буурсан¹⁶ гэдгийг давж заалдах шатны шүүгч нар дүгнэсэн.
4. Хууль зүй, тэр дундаа эрүүгийн эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачдаас уг салбарын шинжлэх ухаанд

¹⁶ Аргачлалыг хэрэглэх явцад анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч, ялаа дүйцүүлэн хасуулах талаарх 2 гомдол 2017 оны 08 дугаар сард ирснийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан үзжээ. Тус шүүх гомдлыг хянан үзсэний дүнд иргэн Э-ийн 13 жилийн хорих ялыг 12 жил 2 сар 13 хоног, иргэн Б-ийн 18 жилийн хорих ялыг 14 жил 4 сар 26 хоногийн ялтай байхаар тогтоосон анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж үндэслэлтэй байгааг дурдаж шийдвэрээ гаргаж, хариу өгсөн байдаг.

математик статистикийн арга, аргачлал хэрэглэсэн нь нийгмийн инноваци буюу *social innovation* болсон гэж үзэж буй нь холбогдох эрдэмтэн, судлаач, УДШ-ийн шүүгч нартай ярилцлахад илэрхийлэгдэж байв. Цаашид шүүхээс ял оногдуулах аргачлал, зөвлөмжийг (*Sentence Guide*) боловсруулж, шүүхийн практикт нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн шинэ санал гарч байв.

5. Шударга ёсыг тогтоох, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд математик, статистикийн аргачлалыг хэрэглэх оролдлого хийсэн нь хууль зүй, гэмт хэрэг судлалын шинжлэх ухааны салбарт судалгааны шинэ арга зүйг нэвтрүүлж, хуулийн практикт шинэ хэрэглээг оруулж байгаагаараа онцлог юм.

Сул тал буюу цаашид анхаарах асуудал:

1. Эрүүгийн хууль буцаан хэрэглэх, ялыг дүйцүүлэн хасах талаар онолын үзэл баримтлалын хувьд УДШ, давж заалдах, анхан шатны шүүх, шүүгч нар нэгдмэл ойлголтгүй байсан, тухайлбал, ялыг нийцүүлэх, эсхүл дүйцүүлэн хасах хэмээн ялгаатай тайлбарлаж байв. Шинэ Эрүүгийн хуулийн 1.9-ийн 3-т “шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна” гэж заасан ч Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна” гэж заасан байна. Тиймээс ялыг нийцүүлэн хасах, дүйцүүлэн хасах тухай ойлголтыг тайлбарлаж, нэг мөр болгох шаардлага тулгарч байна. Дүйцүүлэх гэдгийг “харилцан дүйж тохирох, дүйлцэх”, нийцүүлэн гэдгийг “зохицох, тааламжтай байх, санаанд, хууль дүрэмд, зүйд” гэж тайлбарласан байна. Эндээс дүйцүүлэн гэх үг нь оновчтой гэж үзлээ.

2. Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдсан, өршөөл үзүүлсэн тохиолдолд хорих ялыг дүйцүүлэн хасах талаар тогтсон нэг аргачлалгүй, тухайн үед сонгон хэрэглэх байдалтай явж ирсэн байна.
3. Эрүүгийн хуулийн тэгшитгэлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн ШЕЗ, УДШ, ШШГЕГ-ын тоон мэдээлэл зөрүүтэй, нэгдмэл байдал хангагдаагүй.
4. Хорих ялыг дүйцүүлэн хасах асуудлаар салбарын эрдэмтэн, судлаачдын сонирхол, судалгаа, оролцоо дутмаг явсанаас энэ институци боловсронгуй бус явж иржээ.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Тулгамдсан асуудал: Эрүүгийн хууль буцаан хэрэглэх, ялангуяа хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах аргачлал шүүхийн практикт нэг мөр жишиг байдлаар тогтоогүй байна.

Зөвлөмж 1: Эрүүгийн хууль буцаан хэрэглэх, ялангуяа хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах аргачлалыг нэг мөр жишиг байдлаар хэрэглэдэг байх талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах, эсхүл Эрүүгийн хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын нийцлийг хангах, цаашид “ялыг дүйцүүлэн хасах” гэдгээр нэришиж хэвших, шаардлагатай бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хүргүүлэх.

Тулгамдсан асуудал: Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг Улсын дээд шүүх, давж заалдах, анхан шатны шүүх, шүүгч нар харилцан адилгүй ойлгож, хэрэглэж байна.

Зөвлөмж 2: Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын шийдвэрээр стандартчлан, Эрүүгийн хуулийг шинээр мөрдөх, өршөөл үзүүлэх үед нэг мөр шүүх хэрэглэдэг байх.

Тулгамдсан асуудал: Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг өршөөл үзүүлэх үед хэрэглэх асуудал тодорхой бус байна.

Зөвлөмж 3: Өршөөлийн хууль батлан хэрэгжүүлэх тохиолдолд энэ аргачлалыг хэрэглэх асуудлыг авч үзэж, практикт хэрэглэх.

Тулгамдсан асуудал: Эрүүгийн хуулийн тэгшитгэлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн ШЕЗ, УДШ, ШШГЕГ-ын тоон мэдээлэл зөрүүтэй байна.

Зөвлөмж 4: Эрүүгийн хуулийн тэгшитгэлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн ШЕЗ, УДШ, ШШГЕГ-ын тоон мэдээллийг уялдуулах, нэгдмэл байдлыг хангах;

Тулгамдсан асуудал: Хорих ялыг дүйцүүлэн хасах асуудлаар салбарын эрдэмтэн, судлаачдын сонирхол, судалгаа, оролцоо дутмаг явсанаас энэ институци боловсронгуй бус явж иржээ.

Зөвлөмж 5: Ялыг дүйцүүлэн хасах асуудалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, энэ институци судлалыг хөгжүүлэх;

Зөвлөмж 6: Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хууль буцаан хэрэглэх талаар заасан зохицуулалтын хүрээнд завсрын хугацаанд буюу хэсэгхэн хугацаанд нэмэлт өөрчлөлтөөр ороод хүчингүй болсон хэм хэмжээний зохицуулалт, ялыг хэрхэн дүйцүүлэн бодохыг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай. Энэ асуудлыг одоогоор зохицуулсан хэм хэмжээ байхгүй бөгөөд онолын маргаантай асуудалд тооцогддог

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Их Хурал. (2002). Монгол Улсын Эрүүгийн хууль. №5
2. Жанцан, С. (2009). Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (гэмт хэргийн тухай сургааль). Хууль зүйн үндэсний хүрээлэн УБ, 33, 170-172.
3. Монгол Улсын Их Хурал. (2015). Монгол Улсын Эрүүгийн хууль. №7
4. Munkhdorj, B. (2017). Хорих ялыг дүйцүүлэн хасаж тооцох асуудал. Journal of Law. National Legal Institute of Mongolia. 64, 33-36.
5. Munkhdorj, B. (2017). Theoretical and Practical Issues of Crime Statistics. "The Science Academy Bulletin" Peer Reviewed Journal. Proceedings of the Mongolian Academy of Sciences. Issue №01(221). Available at: <http://dx.doi.org/10.5564/pmas.v57i221.758>
6. Улсын Дээд Шүүх. (2017). "Хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал: нийт шүүгч нарт зориулсан зөвлөмж. УБ. Монгол Улс
7. Munkhdorj, B. (2018). Гэмт хэргийн статистик зүй: онол, хэрэглээний асуудал. Journal of Criminology. Law Enforcement University of Mongolia. 62, 25-33.
8. ШЕЗ, ШШГЕГ-ын албан ёсны мэдээлэл, судалгаа. 2020 он.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын зөвлөмж, хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал

/УДШ-ээс анхан шатны шүүгч нарт 2017 онд хүргүүлсэн/

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

1. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан “2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ялыг дүйцүүлэн хасахад математик статистикийн аргачлал ашиглана.

2. Зохих зүйл хэсэг, заалтыг олоход ял шийтгүүлсэн гэмт хэргийн үндсэн шинж шилжиж байгаа гэмт хэргийн үндсэн шинж болоогүй тохиолдолд шилжүүлэхгүй бөгөөд гэмт хэрэгт тооцохгүй болсон гэж үзнэ. Мөн шилжүүлж байгаа гэмт хэргийн үндсэн шинжийг давж хүндрүүлэх бүрэлдэхүүн болсон бол тухайн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон гэж ойлгоно.

Хэрэг тус бүрийн тохиолдол өөр өөр учраас тэгэж зүйлчил гэсэн чиглэл, зааварчилгаа өгөх боломжгүй, бидэнд тийм эрх хуулиар олгогдоогүй учраас ярилцлагын хэлбэрээр нэгдсэн ойлголтод хүрнэ.

3. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэхэд
 - Хуучин хуулийн 107.3-ын болон шинэ хуулийн 15.2-ын ял: доод ял багасаад дээд ял ихэссэн тохиолдол учир 2 хуулийн дээд доод интервалийг харьцуулаад аль хөнгөн байгаа ялаар шийдвэрлэнэ.

- Шилжүүлсэн зүйл ангид нь тухайн төрлийн ял байхгүй бол зүйлчлэлийг шилжүүлээд ялаас чөлөөлнө.
- 216-р зүйл 215-ын 1, 2, 3, 4-тэй нийлмэл байгаа тохиолдолд 216-г 27.11 рүү шилжүүлээд баривчлах, хорих ял хуулиас хасагдсан үндэслэлээр ялаас чөлөөлнө. 223-ын ял хасагдсан байгаа тул 216-тай адил шилжүүлээд ялаас чөлөөлнө.
- 98-д зааснаар ял шийтгүүлсэн этгээдийн үйл баримтад шинэ хуулийн 10.1-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдвол ийнхүү шилжүүлснээс гарсан ял, урьд өгсөн ялын аль хөнгөнийг баримталж хууль хэрэглэнэ.
- 30 жилийн гяндан: Хуульд тухайн төрлийн ял хүнд байвал хөнгөнийг хэрэглэхээр байгаа тул 20 жил буусан хорих ялтай дүйцүүлэн хасна. 30 жилийн хорих ялыг бүх насаар хорих ялтай дүйцүүлэхгүй.

4. Давтанг байнга руу шилжүүлэх эсэх

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад /байнга зодох, байнга гэмт хэрэг үйлдэх, байнга тогтвортой үйлдэх, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон/ зэрэг “байнга” гэсэн ойлголт шинээр хэрэглэгдэж эхэлж байгаа бөгөөд өмнөх Эрүүгийн хуулиар давтан гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдүүдийн ялыг “байнга” гэх ойлголт руу шилжүүлэхгүй.

Мөн хүчиндэх, бэлгийн мөлжлөг зэрэг гэмт хэргүүдийн хувьд “урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн” гэж хүндрүүлэх нөхцөл байдал зааж өгсөн, өөр бусад гэмт хэргийн хувьд энэ хүндрүүлэх нөхцөл байдал хуульд тусгагдаагүй байна. Энэ хүндрүүлэх бүрэлдэхүүнд давтанг шилжүүлж зүйлчлэхгүй.

Байнга гэдэг бол давтангийн нэлээд хүнд хэлбэр бөгөөд гэмт этгээдийн үйл ажиллагааны нэлээд тогтвортой давтагддаг амьдрал, зан төлөвийн хэвшил болсон үйлдлийг хэлнэ, байнга үйлдэх, тогтвортой, үйлдэж амжиргааны эх үүсвэр болгох зэрэг ойлголтыг 3 буюу түүнээс дээш удаа гэсэн шалгуураас гадна гэмт этгээдийн амьдрал, зан төлөвийн хэвшил болсон зан төрхийг нийлбэрээр уг ойлголтыг ойлгоно.

5. Дэглэм тогтоохдоо ялын хэмжээг хэрхэн харгалзах вэ?

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно гэж хуульчилсан тул ийнхүү тогтоохдоо ялтны хувьд дэглэм хүндрүүлэхгүй гэж ойлгох ёстой, өөрөөр хэлбэл ял хөнгөн болж байгаа ч дэглэмийг хүндрүүлэн тогтоож болохгүй гэж ойлгоно.

- Жирийн дэглэмд ял эдэлж буй ялтнуудыг нээлттэй хорих ангид,
- Чанга, онцгой, гянданд ял эдэлж буй ялтнуудыг хаалттай хорих ангид шилжүүлнэ.

6. Хохирлоор нь хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэх эсэх

Хохирол шаардсан гэмт хэргүүдийн хувьд бага хэмжээний хохирол буюу 300,000 төгрөг хүртэлх хохиролтой үйлдлийг хэрэгсэхгүй болгоно.

Харин 2002 оны хуулийн онц их, их, хэмжээг 2015 оны хуулийн их хэмжээ, үлэмж хэмжээг мөн хуулийн үлэмж хэмжээ гэж ойлгож, үнийн дүнд дүгнэлт хийхгүйгээр үг зүйн талаас нь авч хэрэглэнэ. Учир нь тухайн үеийн амьжиргааны хүчин зүйлүүдийн нөлөөгөөр тогтоогдсон хохирлыг одоогийн хүчин зүйлүүд, түүнтэй холбоотой тогтоогдсон хохирлын хэмжээгээр сольж хөнгөрүүлэхгүй. Энэ нь үйл баримтын дүгнэлт болох учраас энэ талаар дүгнэлт хийгдэх учиргүй.

Эрүүгийн хуулийн 17.1 Хулгайлах, 17.4 Хөрөнгө завших гэмт хэргүүдийн тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.” гэсэн нь 300.000 төгрөгөөс доош хохирол учруулсан боловч 17.2, 17.3-т заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдэгдсэн тохиолдол нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг мөн гэж үзнэ.

Өөрөөр хэлбэл 17.1-д заасан хэргийг 17.2, 17.3-д заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн тохиолдолд бага хэмжээнээс үл хамааран зүйлчлэгдэнэ.

7. Ганцаараа танхайрсан үйлдлийг хэрхэн зүйлчлэх вэ?

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 20.16-д “Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж” гэж ганцаараа танхайрах гэсэн ойлголт байхгүй болсон. Энэ зүйлийг хэрэглэхдээ бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан бол Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн аль тохирох зүйл хэсгээр зүйлчилнэ. 181.3, 153-тай давхар зүйлчлэгдсэн тохиолдолд 153-ыг 17.8, 181-ийг 11.4, 11.6-д заасан тохирох шинжээр зүйлчилнэ. Бүлэг танхайн асуудлыг 20.16-д шилжүүлэн зүйлчилнэ.

20.16.2.1-т заасан “зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж” гэж хүндрүүлэх нөхцөл байдлыг заасан тул зэвсэг хэрэглэж танхайрсан гэж үзэж 181.3-т зааснаар зүйлчилсэн ялтнуудын хувьд 20.16.2-оор ялыг хөнгөрүүлэн өөрчилнө.

8. Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.1 дэх хэсэгт,

“зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно.

“Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно гэж заасан.

Жишээ: Бүх төрлийн архины, варианы, пивоны шил, мод, төмөр зэрэг тусгайлан бэлтгэж засаагүй зүйлс энэхүү тайлбараар зэвсгийн чанартай зүйлд орохгүй.

9. Бүлэглэж гэмт хэрэг үйлдэх ойлголт

2002 оны Эрүүгийн хуулийн хулгай, дээрэм, залилан, булаалтын гэмт хэрэгт бүлэглэж гэсэн хүндрүүлэх шинжээр ял шийтгүүлсэн этгээдийн үйлдлийг хүн тус бүрээр тохирох зүйл хэсгийн дагуу зүйлчилж, аль хөнгөн ялаар шийдвэрлэнэ.

Бүлэглэн гүйцэтгэх тухай ойлголт ерөнхий ангид байгаа нь тусгай ангийн бүлэглэж гэмт хэрэг үйлдэх гэсэн нэр томъёог тайлбарласан байна. Иймд тусгай ангидаа бүлэглэсэн гэж хүндрүүлэх шинж тогтоогдоогүй байхад ерөнхий ангиар хүндрүүлэн зүйлчлэхгүй.

10. Эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг болон мал хулгайлах гэмт хэргийн зүйлчлэлийн талаар

Өмнөх Эрүүгийн хуулиар мал хулгайлж 145 дугаар зүйлээр ял шийтгүүлсэн ялтнуудыг мал хулгайлах гэмт хэрэг болгон зүйлчлэл өөрчлөхгүй хэвээр үлдээнэ.

Хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргүүд нь ялын хувьд яг адил учраас эрх зүйн байдал дээрдэхгүйгээс гадна шинээр Эрүүгийн хуульд туссан гэмт хэргээр зүйлчлэл хийгдэхгүй гэж ойлгоно.

11. Эх орноосоо урвах гэмт хэргийн зүйлчлэлийн талаар

Өмнөх Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлд Эх орноосоо урвах гэмт хэргийг тусгахдаа “Монгол Улсын иргэн тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор гадаад улсын тагнуулын албанд элссэн, төрийн нууцыг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн, Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагатай хамтран ажилласан, дайны байдалд буюу дайн бүхий байдал зарласан үед дайсны талд шилжин орсон” гэж тусгасан байдаг бол шинэчилсэн найруулгад эдгээр үйлдлүүдийг 2 салгаж тус тусад нь гэмт хэрэгт тооцсон. Иймд энэ төрлийн гэмт хэргүүдийн аль нэг шинж нь байхгүй, тусгагдаагүй бол байгаа шинжээр нь тохирох зүйлчлэл рүү шилжүүлнэ.

12. Эрүүгийн хуулийн 57, 58 дугаар зүйлээр ялыг багтаасан зарим хэсгийг нэмж биечлэн эдлэх ял тогтоогдсон ялтны хувьд шинэ хуулийн 6.8, 6.9-р зүйлд энэ аргачлал хасагдсан, зөвхөн нэмж нэгтгэх аргачлалыг хэрэглэхээр хуульчилсан. Нэмж нэгтгэсэн зохицуулалтыг хэрэглэвэл эрх зүйн байдал хүндэрнэ, мөн энэ зүйл хэсэгт багтаах, заримыг нэмэх зохицуулалт хасагдсан учраас багтсан ял, нэмсэн ялаас чөлөөлнө.

Жишээ нь: 8 жилийн ялд 4 жилийг багтаасан байвал аль аль хэргийн зүйлчлэлийг хөнгөрч байвал өөрчилж, ялаас нь чөлөөлж шийдвэрлэнэ.

13. Эрүүгийн хуулиас хасагдсан болон тухайн гэмт хэрэгт шийтгүүлсэн ял шинэ хуулиар хасагдсан тохиолдол

- Баривчлах ял шийтгүүлсэн этгээдийн ялыг өөр ямар нэг ялтай дүйцүүлэхгүй бөгөөд тухайн төрлийн ял нь шинэ Эрүүгийн хуульд тусгагдаагүй тул дүйцүүлэх тухай ойлголт үүсэхгүй, ялаас чөлөөлнө.
- Хорих ялын хэмжээ багассанаас гадна тухайн шилжүүлсэн зүйл ангид тухайн төрлийн ял нь байхгүй болсон бол ялаас чөлөөлнө.

ХУУЛЬ БУЦААН ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ЗАХИРАМЖ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ:

/нийт шүүгч нарт зориулав/

Баримтлах зарчмууд

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь шинээр батлагдсан хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт шинэ болон урьд үйлчилж байсан хуулиудын аль хөнгөнийг хэрэглэх явдал бөгөөд ex post facto буюу шинэ хуулийг түүнээс өмнөх үйл баримтад хэрэглэх гэсэн зарчмыг удирдлага болгоно.

Шинэ хуулиар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн бол хуулийг буцаан хэрэглэх үндэслэл болно.

Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон бол шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийг ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлж, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн бол ялыг шинээр тогтоосон хэмжээнд дүйцүүлэн хасах хэлбэрээр хуулийг буцаан хэрэглэнэ.

Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан бол уг хуулийг буцаан хэрэглэхгүй.

Урьд ял шийтгүүлсэн этгээдийг ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх тухай, ялыг дүйцүүлэн хасах тухай хоёр төрлийн захирамжийг шүүгч гаргаж хуулийг буцаан хэрэглэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Захирамжийн бүтэц, агуулга

Шүүгчийн захирамжийг “Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх тухай”, “Ялыг дүйцүүлэн хасах тухай” гэсэн хоёр хэлбэрээр бичнэ.

Шүүгчийн захирамж нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.

Шүүгчийн захирамжийн удиртгал хэсэгт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- шүүгчийн захирамжийг хэзээ, хаана гаргасан;
- шүүгчийн захирамж гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, хорих ангийн тоо бүртгэгчийн нэр;
- ялтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс, төрсөн газар, он, сар, өдөр, боловсрол, регистрийн дугаар, бусад мэдээлэл;
- ялтан нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт зааснаар аль шүүхээр ямар ял шийтгүүлсэнийг бичнэ;
- ялын тооцоо;
- прокурорын санал;

Шүүгчийн “Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх тухай” захирамжийн тодорхойлох хэсэгт дараах зүйлийг тусгана; Үүнд:

- ял шийтгүүлсэн этгээдийн урьд үйлдсэн гэмт хэргийн шинж чанар /ЭХ 2.1.3-д заасан/;
- уг гэмт хэргийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон тухай үндэслэл;

Дээрх захирамжийн тогтоох хэсэгт дараах зүйлсийг тусгана; Үүнд:

- Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлсөн тухай;

Шүүгчийн “Ялыг дүйцүүлэн хасах тухай” захирамжийн тодорхойлох хэсэгт дараах зүйлийг тусгана; Үүнд:

- ял шийтгүүлсэн этгээдийн урьд үйлдсэн гэмт хэргийн шинж чанар /ЭХ 2.1.3-д заасан/;
- түүнд оногдуулсан ялын төрөл, хэмжээг гэмт хэрэг бүрээр зааж ял нэгтгэсэн байдлыг тодорхойлох;
- Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг өөрчилсөн байдал;

- Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний дотор ял оногдуулах жишиг аргачлалын хүрээнд ялыг дүйцүүлэн хасах, хэвээр үлдээх үндэслэл, ялын тооцоолол буюу ял хассан эсвэл хэвээр үлдээсэн байдал, биечлэн эдлэх ялын хэмжээ;
- ял эдлүүлэх дэглэмийг тогтоосон байдал; Үүнд: Өмнөх Эрүүгийн хуулиар жирийн дэглэмд хорих ялыг эдлүүлэхээр заасан бол нээлттэй хорих ангид эдлэхээр бусад тохиолдолд хаалттай хорих ангид хорих ялыг эдлэхээр заах нь зүйтэй;

Шүүгчийн дээрх захирамжийн тогтоох хэсэгт дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Ялыг дүйцүүлэн хасах тухай;
- Дэглэм шинээр тогтоосон тухай;
- Шүүгчийн захирамжид гомдол гаргах журам;

Шинэ Эрүүгийн хуулиар дүйцсэн ялын хэмжээг тодорхойлохдоо /Ядүйц/ эхлээд ял дүйцүүлэх коэффициентийг /Кдүйц/ олно. Энэ нь шинэ Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрүүг /ШЯдээд-ШЯдоод/ өмнөх Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрүүд /ХЯдээд-ХЯдоод/ харьцуулсан харьцаа /хуваасан/ байна. Уг коэффициентийг /Кдүйц/ өмнөх хуулиар оногдуулсан ял /Яөмнөх/, ялын доод хэмжээ /ХЯдоод/ хоёрын зөрүүгээр үржүүлж шинэ ялын доод хэмжээн дээр /ШЯдоод/ нэмнэ. Өөрөөр хэлбэл:

$$\text{Ядүйц} = \text{Кдүйц} * (\text{Яөмнөх} - \text{ХЯдоод}) + \text{ШЯдоод}$$

$$\text{Кдүйц} = (\text{ШЯдээд} - \text{ШЯдоод}) / (\text{ХЯдээд} - \text{ХЯдоод})$$

X_1 Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ

X_2 Хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээ

Y_1 Шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээ

Y_1 Шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээ

$\Delta X = X_2 - X_1$ Хуучин ЭХ-ийн ялын интервал

$\Delta Y = Y_2 - Y_1$ Шинэ ЭХ-ийн ялын интервал

$K = \frac{\Delta Y}{\Delta X} = \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1}$ - Хуучин ЭХ-ийн ялын нэгж хэмжээнд харгалзах шинэ ЭХ-ийн ялын хэмжээг илэрхийлэх коэффициент

X^* Хуучин ЭХ-иар оногдуулсан ял

Y^* Шинэ ЭХ-иар буурсан ял

$$Y^* = Y_1 + K \cdot (X^* - X_1) = Y_1 + \left(\frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} \right) \cdot (X^* - X_1)$$

Кейс-1

5 жил Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ

10 жил Хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээ

2 жил Шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээ

8 жил Шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээ

$$X^* = 6 \text{ бол } Y^* = 2 + \left(\frac{8-2}{10-5} \right) \cdot (6-5) = 3.2 \text{ жил}$$

$$X^* = 5 \text{ бол } Y^* = 2 + \left(\frac{8-2}{10-5} \right) \cdot (5-5) = 2 \text{ жил}$$

$$X^* = 10 \text{ бол } Y^* = 2 + \left(\frac{8-2}{10-5} \right) \cdot (10-5) = 8 \text{ жил}$$

$$X^* = 7.5 \text{ бол } Y^* = 2 + \left(\frac{8-2}{10-5} \right) \cdot (7.5-5) = 5 \text{ жил}$$

Кейс-2

5Жил Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ

10Жил Хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээ

2Жил Шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээ

14Жил Шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээ

Тайлбар: ЭХ-ийн буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээг хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээгээр тооцож бодно.

$$X^* = 6 \quad Y^* = 2 + \left(\frac{10-2}{10-5} \right) \cdot (6-5) = 3.6 \text{Жил}$$

$$X^* = 5 \quad Y^* = 2 + \left(\frac{10-2}{10-5} \right) \cdot (5-5) = 2 \text{Жил}$$

$$X^* = 10 \quad Y^* = 2 + \left(\frac{10-2}{10-5} \right) \cdot (10-5) = 10 \text{Жил}$$

Кейс-3

5Жил Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ

10Жил Хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээ

6Жил Шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээ

8Жил Шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээ

Тайлбар: ЭХ-ийн буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээг хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээгээр тооцож бодно.

$$X^* = 7 \quad Y^* = 5 + \left(\frac{8-5}{10-5} \right) \cdot (7-5) = 6.2 \text{Жил}$$

$$X^* = 5 \quad Y^* = 5 + \left(\frac{8-5}{10-5} \right) \cdot (5-5) = 5 \text{Жил}$$

$$X^* = 10 \quad Y^* = 5 + \left(\frac{8-5}{10-5} \right) \cdot (10-5) = 8 \text{Жил}$$

Кейс-4

$$X^* = 3 \text{ жил}$$

5 жил Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ

10 жил Хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээ

2 жил Шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээ

8 жил Шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээ

Тайлбар: Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан тохиолдолд хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээгээр тооцож бодно.

$$X^* = 3 \text{ бол } Y^* = 2 + \left(\frac{8-2}{10-3} \right) \cdot (3-3) = 2 \text{ жил}$$



ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДЛААЧ: Б.ОДОНГЭРЭЛ, Хууль зүйн магистр

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГС.....	101
УДИРТГАЛ.....	102
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	103
1. МОНГОЛ УЛСАД ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ХЯНАЛТ ТАВЬЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	105
1.1 Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал.....	105
1.2 Хууль хэрэгжиж буй өнөөгийн байдал, шинэ эрх зүйн зохицуулалт.....	110
1.3 Насанд хүрээгүй хүнийг нийгэмшүүлэх үйл явц.....	113
2. ГЭМТ ХЭРЭГТНИЙГ ХЯНАХ, НИЙГЭМШҮҮЛЭХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА.....	116
2.1 Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх талаарх олон улсын эрх зүйн баримт бичгүүд.....	117
2.2 Гадаад орны сайн туршлагаас суралцах нь.....	120
3. ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ БОЛГОХ АРГА ЗАМ.....	127
3.1 Монгол Улсад гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тогтолцоог иж бүрэн бүрдүүлэх нь.....	128
3.2 Хорих ялаас суллагдсан этгээдэд “шилжилтийн үе”-ийг даван туулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх.....	131
3.3 Хяналтын үр нөлөөтэй аргуудыг ашиглах нь.....	135
3.4 Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцооны үүрэг.....	136
ДҮГНЭЛТ.....	140
САНАЛ.....	144
ЭХ СУРВАЛЖ.....	146

ТОВЧИЛСОН ҮГС

ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
ГХЗУСТХ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЦАТХ	Цагдаагийн албаны тухай хууль
ИБУТЭТӨУП	Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт
НМД	Нелсон Манделагийн дүрэм (НҮБ-ын Хоригдлыг засан хүмүүжүүлэх наад захын жишиг дүрэм)
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ЦБ	Цагдаагийн байгууллага
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
СХТБ	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага
ХЭССХ	Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн

Мэргэжлийн нэр томьёо

Пробаци (Probation)	Тэнсэн харгалзах ажиллагаа
Парол (Parole)	Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих ажиллагаа

УДИРТГАЛ

Аливаа улс орон амгалан тайван нийгмийг бүрдүүлэх явдлыг төрийн эрүүгийн бодлогын нэн тэргүүнд тавьж, түүнд хүрэхийг байнга эрмэлздэг хэдий ч бэрхшээлтэй тулгарсаар байдаг нь үнэн билээ. Гэмт хэрэг, зөрчлөөс ангид амар амгалан нийгэмд хөтлөх нэг үндэс бол гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, нийгэмдээ аюулгүй этгээд болгон хүмүүжүүлэх явдал байдаг. Монгол Улсын Эрүүгийн хуулиар “*Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.*”¹ гэж тодорхойлжээ.

Хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналт нь хоёр үндсэн зорилго агуулдаг. Нэгдүгээрт, гэмт хэрэг үйлдээд ял шийтгэлээ эдэлсэн хүн нийгэмд эргээд нэгдэх үйл явцад туслах нь буюу нийгэмшүүлэх явдал байдаг бол хоёрдугаарт, тэрхүү этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Хэрвээ нэгдүгээр зорилгыг биелүүлж чадвал хоёрдугаар зорилго аяндаа биелэх боломжтой. Өөрөөр хэлбэл, нэгэнтээ нийгэмшсэн хүн хяналт тавиагүй байсан ч гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн логик аяндаа үүснэ.

Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдлыг нэн тэргүүнд тавихаас илүүтэйгээр гэмт этгээдийг нийгэмшүүлэх ажиллагааг эрчимжүүлэх нь зохистой ажээ. Дэлхийн улс орнуудын *Criminal Justice system* буюу эрүүгийн хариуцлагын тогтолцоонд “нийгэмшүүлэх” гэсэн тусдаа бүтэц байх нь элбэг байдаг. Тухайлбал, Япон Улсын Хууль зүйн яам “Нийгэмшүүлэх алба” гэсэн тусдаа бүтэцтэй бөгөөд дотроо хорихоос суллагдсан болон тэнссэн этгээдэд хяналт тавих чиг үүрэг бүхий институттэй байна.

Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх зорилтыг биелүүлэх үүднээс олон улсад үндсэн 3 хөтөлбөрийг иж бүрэн

¹ Эрүүгийн хууль, 2015 он, 5.1 дүгээр зүйл.

хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг. Үүнд (i) хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөр, (ii) гэмт хэрэгтнийг хорихоос суллагдсаны дараагаар эргэн нэгтгэх, халамжлах хөтөлбөр, (iii) гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял оногдуулах буюу нийгэмд суурилсан хөтөлбөр юм.²

Бидний энэхүү судалгаагаар олон улсын нийгэмшүүлэх зорилтын хоёрдугаар чиглэл буюу Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих, нийгэмд эргэн нэгтгэх, халамжлах ажиллагаа ямар түвшинд байгааг илрүүлэх, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, өнөөгийн байдлыг олон улсын болон гадаадын улстай харьцуулан жиших, нөхцөл байдлыг шинжлэн судалсны эцэст эрх зүйн болон практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хувилбарыг дэвшүүлэхийг зорилоо.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг бие даасан, хараат бус хандлагаар хийх ба эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, гадаадын зарим орны хууль тогтоомжтой харьцуулан авч үзэх, системчлэх, логик дүгнэлт хийх, задлан шинжилж нэгтгэн дүгнэх зэрэг бичиг баримтын судалгааны арга зүйд үндэслэн гүйцэтгэсэн болно.

Түүнчлэн өнөөгийн нөхцөл байдлыг илрүүлэн тандах зорилгоор иргэд, албан тушаалтны дунд фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын, ажиглалтын, санал асуулгын зэрэг социологийн судалгааны аргуудыг ашиглалаа.

Ганцаарчилсан ярилцлагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (ШШГБ), Цагдаагийн байгууллага (ЦБ) зэрэг төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, ажилтан, төрийн бус байгууллагын төлөөлөөс авлаа. Түүнчлэн фокус бүлгийн ярилцлагыг хугацаанаас өмнө хорихоос суллагдсан этгээд болон энгийн иргэдийн дунд зохион байгуулсан. Нийтдээ ярилцлагын судалгаанд 50 хүнийг хамрууллаа. Санал асуулгын судалгааг

² НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецедивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 5 дахь тал.

100 иргэнээс түүврийн аргаар сонгон авсан ба уг санал асуулгаар гэмт этгээдийг нийгэмд хүлээн авах иргэдийн сэтгэл зүйн нөхцөл, ялгаварлах байдлыг тодруулахыг зорьсон бол ярилцлагын судалгаагаар Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд тавьж буй хяналтын үр нөлөө ямар түвшинд байгааг илрүүлэхийг зорьсон болно.

-НЭГДҮГЭЭР БҮЛЭГ-

МОНГОЛ УЛСАД ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ХЯНАЛТ ТАВЬЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих үйл ажиллагааг хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болох ШШГБ, ЦБ нь Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай зэрэг хуулиудаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаал зэрэг хууль тогтоомжийн хүрээнд³ гүйцэтгэж байна. Төрийн зүгээс тавьж буй дээрх байгууллагуудын хяналт нь дараах 5 төрлийн этгээдэд чиглэсэн байна.

- Шүүхээс тэнсэн суллагдсан этгээдэд (ял оногдуулахгүйгээр тэнссэн);
- Хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан;
- Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан;
- Жирэмсэн болон 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан;
- Хорих ял эдлээд суллагдсан.

1.1 ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай хуулийн зохицуулалт нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам, 2014 он, www.legalinfo.mn

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмаар зохицуулагдаж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хугацаанаас өмнө суллах талаарх эрх зүйн зохицуулалт нь дараах байдлаар тусгагджээ. Ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын тодорхой хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно гээд:

- А. таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;
- Б. таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;
- В. арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн бол⁴ гэжээ.

Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоодог.⁵ Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд түүнд хүлээлгэсэн үүргийг зөрчвөл Эрүүгийн хуулийн зохих зүйлийн дагуу эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр шийдвэрлэдэг байна.⁶ Түүнчлэн ЭХХШТХ-ийн 37.6 дугаар зүйлд хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох талаарх процессыг дэлгэрэнгүй заасан.⁷ Тухайлбал, хорих ялаас хугацаанаас өмнө суллах асуудлыг хорих байгууллагын тодорхойлолтыг үндэслэн прокурорын дүгнэлтээр шүүх шийдвэрлэх тухай, хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх ялыг нэмж нэгтгэх тухай, хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр

⁴ Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйл, 2015 он, www.legalinfo.mn

⁵ Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2015 он, www.legalinfo.mn

⁶ Мөн тэнд, 3 дахь хэсэг.

⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйл, 2015 он.

гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлэх тухай хуульчилжээ.

Дээр дурдсан хорих байгууллагын тодорхойлолтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар (ШШГЕГ)-ын даргын 2017 оны А/165 дугаар тушаалаар батлагдсан Арга зүйн зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлд зааснаар гаргадаг. Тус журамд “шаардлага хангасан хоригдол хугацаанаас өмнө суллагдах хүсэлтээ бичгээр гаргах ба хүсэлтийг тухайн хоригдлын зан байдлын тодорхойлолт, бусад мэдээллийн хамтаар Арга зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шаардлага хангасан гэж үзвэл саналыг хувийн хэргийн хамтаар прокурорт хүргүүлнэ” гэж заажээ.⁸

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлдэг байна. Шаардлагатай бол суллагдаж байгаа хоригдолд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих ангиас олгож болох ба уналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцон олгодог журамтай.⁹

Дээрх хуулийн заалтын дагуу хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хэн хяналт тавих вэ гэсэн асуудлыг авч үзье. Энэ талаар 2002 оны Эрүүгийн хуулийн дагуу хугацаанаас өмнө тэнссэн, ял хойшлуулсан этгээдэд цагдаагийн байгууллага хяналт тавих эрх зүйн зохицуулалттай байсан.¹⁰ Өөрөөр хэлбэл, тус хуулийн 74.6 дугаар зүйлд “ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан этгээдэд цагдаагийн байгууллага, цэргийн албан хаагчид, цэргийн анги, нэгтгэлийн дарга хяналт тавина”¹¹ гэж хуульчилж байжээ.

2015 оны Эрүүгийн хуульд хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих байгууллагын талаар тодорхойлон заагаагүй ба харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, “Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйл.

⁹ ШШГТХ-ийн 254.3 дугаар зүйл.

¹⁰ Эрүүгийн хуулийн 61.4 дүгээр зүйл. 2002 оны Эрүүгийн хууль

¹¹ Эрүүгийн хууль, 2002 он, www.legalinfo.mn

найруулгын 186 дугаар зүйлд “Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө”¹² гэсний дагуу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан шүүхийн шийдвэрийн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (ШШГБ) хэрэгжүүлж байна. ШШГБ хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тавихын зэрэгцээ ЦБ нь ГХЗУСТХ-ийн 41.1 дүгээр зүйлд заасны дагуу хяналт тавих эрх зүйн зохицуулалт 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйлчлэх боллоо.

Өмнөх ГХУСТХ-д “давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох” хэмээн хуульчилж байсан бол шинэчлэн батлагдсан ГХЗУСТХ-д “Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно” гэсэн байна.

Энэ заалт нь хугацаанаас өмнө суллагдсан хүнийг ЭХХШТХ, ШШГТХ-д заасан хяналтын хугацаа нь дууссан ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЦБ хяналт тавьж болохыг зохицуулсан. “Хяналтыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, түүний алба хаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын шийдвэрээр үйлдсэн гэмт хэргийн төрлөөс хамааран тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх

¹² ШШГТХ-ийн 186.1 дүгээр зүйл.

чиг үүргийг дагнан хэрэгжүүлж байгаа цагдаагийн байгууллагын нэгж, алба хаагчид даалгаж болно”¹³ гэжээ.

Хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, тэнсэн сулласан ялтанд хяналт тавих ажиллагааг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба ШШГТХ-ийн 268.1.4-т заасны дагуу мэргэжлийн удирдлагаар хангадаг. Хугацаанаас өмнө суллагдах шүүхийн шийдвэрээр суллагдсан этгээд ШШГБ-ын хяналтад байж шийдвэр гүйцэтгэгч хяналтын хувийн хэрэг нээж, хуулийн дагуу хяналтын дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

- тухайн этгээдэд хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулах;
- хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, ялтны хувийн байдлын талаарх бусад мэдээллийг хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсаргах;
- хуулийн дагуу үүрэг хүлээсэн зохих этгээдэд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах, үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;
- хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутамд тэмдэглэл хийх;
- шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.¹⁴

ЦБ-аас хуульд зааснаар хяналт тавих хугацаа 1-3 жил байх ба хяналтад байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн бол 2 жил нэмж тогтоодог байна.¹⁵ Хяналтад байгаа хүн хяналтаас зайлсхийсэн бол ... хяналтын хугацааг тухай бүр зургаан сарын хугацаагаар сунгаж тогтооно.¹⁶ Гэвч хугацааг сунгахдаа тухайн хүний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан хорих ялын дээд хугацаанаас хэтэрч болохгүй.¹⁷

¹³ ГХЗУСТХ-ийн 41 дүгээр зүйл, 2 дахь хэсэг, 2019 он

¹⁴ ШШГТХ-ийн 186.2 дугаар зүйл. 1-6 дугаар хэсэг.

¹⁵ ГХЗУСТХ-ийн 42 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг. 2019 он.

¹⁶ ГХЗУСТХ-ийн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. 2019 он.

¹⁷ Мөн тэнд. 6 дахь хэсэг.

1997 оны ГХУСТХ-д “хяналтад байгаа хүн засал хүмүүжил олсноо харуулбал түүний энэ талаар гаргасан өргөдлийг хянан үзэж, хугацаанаас нь өмнө захиргааны хяналтыг зогсоож болно” гэж заасан хэдий ч засал хүмүүжил олсноо харуулах гэсэн ойлголт нь хуульд тодорхойгүй байсан. Үүнийг 2019 оны ГХЗУСТХ-д “хяналтад байгаа хүн хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа бөгөөд ажил хөдөлмөр эрхлэлт, зан төлөвийн хувьд засарч нийгэмд бүрэн дасан зохицсон, цаашид гэмт хэрэг үйлдэхгүй гэх хангалттай үндэслэл тогтоогдсон, эсхүл гадаад улсад удаан хугацаагаар зорчих бол эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хугацаанаас өмнө хяналтыг дуусгавар болгож болно” гэж хуульчилжээ.¹⁸

Ийнхүү хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд ШГГБ, ЦБ хяналт тавих талаар эрх зүйн зохицуулалт нь ЭХ, ЭХХШТХ, ШШГТХ, ГХЗУСТХ зэрэг хуулиудаар хуульчлагдаж өөрчлөлт шинэчлэлт хийгдэж байна.

1.2 ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШИНЭ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ШШГБ нь ШШГТХ-ийн дагуу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хугацаанаас өмнө суллагдсан болон тэнссэн этгээдэд хяналт тавин ажиллаж байна. Хяналтад байгаа этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зохих ажилтны бүртгэлд орж, сард нэг удаа хувийн хэрэгт нь тэмдэглэл үйлдэх байдлаар хуулийн заалт практикт хэрэгжиж байна. Тухайн этгээдийг нийгэмшүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх үйл ажиллагаа дутмаг байгааг дараах хоёр ярилцлагаас харж болно.

¹⁸ Мөн тэнд. 5 дахь хэсэг.

“Би 2018 оны 10 сард шүүхээс 2 жилийн тэнсэн авсан. Сар болгон очиж шийдвэр гүйцэтгэгчтэйгээ уулзаж “Та захиргааны зөрчил гаргасан уу, хаяг дээрээ байгаа юу, эрх цүргээ мэдэж байгаа юу, ойрын хугацаанд хаашаа явах вэ” зэрэг нэгэн ижил асуултад хариулж гарын цсгээ зурдаг. Нэг удаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтад хамрагдсан. Үүнээс өөр нийгэмшүүлэх ямар нэгэн ажилд хамрагдаж үзээгүй. Хяналтад байх 1 жил үлдэж байна даа”

Иргэн П.Х-тай хийсэн ярилцлагын судалгаанаас

“Хугацаанаас өмнө суллагдаж хяналтад байгаа этгээдүүд ихэвчлэн ажилгүй байдаг. Нэг удаа тэдэнд ажлын байр хайж, албан байгууллагуудаас асууж үзэж байсан, гэхдээ олддоггүй юм билээ.”

ШШГБ-ын шийдвэр гүйцэтгэгчийн ярианаас

ЦБ дээр дурдсан ГХЗУСТХ-ийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтоохоос гадна 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө шүүхийн шийдвэрээр тэнсэн суллагдсан, хугацаанаас өмнө суллагдсан зэрэг этгээдүүдэд түүнчлэн ШШГБ тухайн нутаг дэвсгэрт байхгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журмын 1.3.2 дахь заалтын дагуу захиргааны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн I хэлтсийн харьяа 16 дугаар хороонд цагдаагийн хяналтад байгаа 2 этгээдийн талаар судалж үзэхэд ЭХ-ийн (2002 оны) 215.3 зүйлээр ял шийтгэгдсэн Я.Г гэгчид 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр цагдаагийн захиргааны хяналт эхэлсэн ба 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хяналт үргэлжлэхээр байна. Харин ЭХ-ийн (2002 оны) 147.3 дугаар зүйлээр ял эдэлж хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан Ц.Р нь мөн л 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө цагдаагийн хяналтад ирсэн этгээд байна.

Дээрх байдлаар ЦБ хяналт тавин ажиллаж буй нийт тоон мэдээг гарган авч үзвэл, 2019 онд улсын хэмжээнд 531 этгээд цагдаагийн хяналтад байгаагаас шүүхээс тэнсэн суллагдсан нийт 347 этгээдэд хяналт тавьжээ.¹⁹ Хорих ялаас хугацаанаас өмнө

¹⁹ ЦЕГ-ын НХЖХ ОНАБХА-ны статистик мэдээнээс авч ашиглав. 2019 он.

тэнсэн суллагдсан 133 этгээдэд хяналт тавьж байгаагийн 72 нь хөдөө орон нутагт 61 нь нийслэлд байна. Мөн насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 7 хүүхдэд хяналт тавьж байна. Жирэмсэн болон 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан нийт 10 хүнд хяналт тавьж байгаагаас 50 хувь нь нийслэлд хяналтад байгаа ажээ. Хорих ял эдлээд суллагдсан хүнд тавьж буй хяналтыг (ялын хугацаа дуусаж суллагдсан) 34 этгээдэд тавьж буйгаас хамгийн өндөр хувьтай аймгууд нь Хэнтий (19), Увс (5), Дорнод (5) зэрэг байна.²⁰

Түүнчлэн ЦБ-ын ГХУСТХ-ийн дагуу тавьж буй захиргааны хяналтыг судалж үзэхэд *“Суллагдаад гарч ирсэн этгээдийг оршин суугаа хаягийн дагуу бүртгэн авдаг. Нэгэнт ялаа эдлээд суллагдсан хүнийг бид тэнсэнтэй хүний нэгэн адилаар сар бүр дуудан ирүүлэх, сургалтад хамруулах зэрэг арга хэмжээ авдаггүй, нийгэмшүүлэх ажиллагаа гэж үнэндээ юм байхгүй.”*²¹ гэсэн хэсгийн байцаагчийн ярилцлагын судалгаанаас харагдаж байна. Дээрх хандлага нь цагдаагийн байгууллагын алба хаагчийн бүрэн эрхийг 2019 оны ГХЗУСТХ-ийн 44 дүгээр зүйлд нэлээд тодорхой зааж өгсөнтэй холбоотойгоор цаашид өөрчлөгдөнө гэж үзэж байна. Практикт шүүхээс тэнсэн суллагдсан, хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, хугацаанаас өмнө хорих ялаас тэнсэн суллагдсан этгээдүүдийн хяналт нь сард нэг удаа ШШГБ, ЦБ дээр очиж бүртгүүлэх төдийгөөр хэрэгжиж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

ГХЗУСТХ-д шинээр хяналтын хэлбэрийг хуульчилж өгсөн төдийгүй хяналт тавихдаа арга хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах тухай шинэ заалтууд оруулжээ.²² Хяналтын хэлбэрт гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх ярилцлага хийх, зөвлөгөө өгөх, тухайн этгээдийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх, ял шийтгүүлсэн

²⁰ Мөн тэнд.

²¹ Баянзүрх дүүргийн ... хорооны хэсгийн байцаагч н.Г-тэй 2019 оны 5 дугаар сард хийсэн ганцаарчилсан ярилцлагын судалгаанаас

²² ГХЗУСТХ-ийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. 2019 он.

гэмт хэргийн төрөл, хувийн байдлаас хамааран урьд өмнө гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэсэн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар тодорхой үүрэг өгч, биелэлтийг хангуулах, хяналтад байгаа хүний зан үйл, хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны талаар тусгайлсан шаардлага, хориглолт, хязгаарлалт тогтоох, ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааг нь биечлэн шалгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэж тэнсэн харгалзсан этгээд мансууруулах эм, бодис хэрэглэсэн эсэхийг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар шалгах, албадан эмчилгээнд хамруулах зэргийг хамруулжээ.²³

Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлснээр хяналтад байгаа этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх төдийгүй нийгэмшүүлэх нөхцөл хангагдах боломжтой болно. Түүнчлэн хяналтад байгаа хүн хуульд заасан тогтоосон хугацааны эхний хагаст зан байдлаараа нийтэд аюулгүй болсон гэдгээ нотлон харуулсан бөгөөд цаашид тогтмол хяналт тавих шаардлагагүй бол хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтын үлдсэн хугацаанд энэ хуульд заасан хяналтын түвшнийг хөнгөрүүлж болох төдийгүй тухайн хүний эерэг зан, төлөв байдлаас хамааран урамшуулах, цагдаагийн байгууллагад дуудахгүй байх, зарим үүрэг, хориглолт, хязгаарлалтыг цуцлах байдлаар хэрэгжүүлэхээр тусгасан зэргийг практикт үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний хэрэгжилтийг тодорхой хугацааны дараа судлан үзэх нь зүйтэй.

1.3 НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн нэг томоохон өөрчлөлт бол насанд хүрээгүй хүний эрүүгийн хариуцлагын асуудал юм. Тухайлбал, өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг 2015 оны Эрүүгийн хуулиар Монгол Улсад тусгай бүлэг болгон зүйлчилсэн бөгөөд хорих ялыг Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх,

²³ Мөн тэнд. 2 дахь хэсэг.

эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах зэргээр²⁴ насанд хүрээгүй хүнийг онцгойлон анхаарсан зохицуулалтыг тусгажээ. Хэдий тийм боловч хорихоос суллагдсан насанд хүрээгүй хүнд хяналт тавих ажиллагааг насанд хүрсэн этгээдийн нэгэн адил гүйцэтгэж, зохих үүргийг хүлээлгэх ба энэ талаар тусгайлсан заалт байдаггүй.²⁵

Харин 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”²⁶ батлагдаж, тус журмаар Хороо нь хүүхдийг хэвийн амьдралд эргэн ороход туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа ... хүүхэдтэй эргэх холбоо тогтоон, хамтран ажиллах тухай²⁷ заасан нь сайшаалтай. Түүнчлэн тус Хороо нь хууль зөрчсөн хүүхдийг хүмүүжүүлж нийгэмшүүлэх үйл ажиллагаанд бусад байгууллагыг татан оролцуулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар хамтран ажиллах чиг үүргийг хүлээх ба тухайн шатны Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга ахлан ажилладаг байна.²⁸

2019 оны 4 сарын 29-нд зохион байгуулсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг дэмжих төслийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан хэлэлцүүлэг”-т Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага (СХТБ)-аас суллагдсан 31 хүүхдийг үйлчилгээнд хамруулахыг санал болгоход эргэн мэдээлсэн нь 61 хувьтай гарчээ.

²⁴ Эрүүгийн хууль, 2015 он, 8.5, 8.6 дугаар зүйл.

²⁵ ШШГТХ-ийн 186 дугаар зүйл, www.legalinfo.mn

²⁶ <http://mlsp.gov.mn/uploads/op/files/d163635d0aaae3729954602b7dab0aeef54b0907.pdf>, сүүлд зочилсон 2019.09.20

²⁷ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, 3.3 дугаар зүйл.<http://mlsp.gov.mn/uploads/op/files/d163635d0aaae3729954602b7dab0aeef54b0907.pdf>

²⁸ Мөн тэнд.

“СХТБ-д хүмүүжиж байгаа хүүхдүүдтэй хорих ангид нийгмийн ажилтан сайн ажиллаж байгаа хэдий ч суллагдсаны дараагаар нийгэмшүүлэх үйл ажиллагаа маш муу байна. Хууль зүйн хорооноос эдгээр хүүхдийн алдаатай зан үйлийг засах, дахин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллахад хүндрэлтэй зүйл нэлээд байна. Тухайлбал, суллагдсан хүүхдүүдийн хаягийг тогтоох боломжгүй, хаяг нь өөрчлөгдсөн байхаас гадна хүүхдүүд өөрсдөө айдаг, эцэг эх нь дургүйцдэг. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу, нэгэндээ мэдээлэл хүргэдэггүй, өөр өөрийн чиг хүрээнд буюу хайрцаг хайрцаг дотроо ажиллаж байна. Энэ мэт бэрхшээлтэй холбоотойгоор Хууль зүйн хорооны үйл ажиллагаа жигдрэхгүй байна.”

ХЭССХ ТББ-ын ажилтны ярилцлагаас

СХТБ-д ирсэн хүүхдүүдийг сургалт хүмүүжлийн байгууллагад байх хугацаанд нь хүмүүжүүлээд зогсохгүй, түүнийг ирэхээс өмнө, буцсаны дараа нийгэмшүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай. Тухайн хүүхэдтэй төдийгүй, тэдгээрийн эцэг эх, гэр бүл, асран хамгаалагчтай нь ажилладаг нийгмийн үйлчилгээ нэн шаардлагатай байна. Түүнчлэн СХТБ, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь уялдаа холбоотой хамтран ажиллах нь зүйтэй”²⁹ гэж судлаачид дүгнэжээ.

²⁹ Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн, Хүүхдийн эрхийн форум, “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний үнэлгээ”, УБ, 2018

-ХОЁРДУГААР БҮЛЭГ-

ГЭМТ ХЭРЭГТНИЙГ ХЯНАХ, НИЙГЭМШҮҮЛЭХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх асуудал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны анхаарал татсан асуудлын нэг болоод байгаа бөгөөд энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд гаргах, олон улсын болон дотоодын хурал чуулган зохион байгуулах нь түгээмэл болжээ. Тухайлбал, Олон улсын засан хүмүүжүүлэх ба хорих ангийн холбооны 15 дугаар бага хурал 2013 онд “Хананы цаадах амьдралыг эргэцүүлэхүй” сэдвээр, 2014 оны 10 сард “Хорих ялаас нийгэмд нэгтгэх үйл явц: Зорилготойгоор өөрчлөх нь” сэдвээр тус тус зохион байгуулагджээ. Түүнчлэн 2014 оны 10 дугаар сард Пробаацийн дэлхийн анхдугаар чуулган Лондон хотноо зохион байгуулагдаж, гэмт этгээдийг нийгэмд нь хүмүүжүүлэх явдлыг дэмжиж буй олон улсын чиг хандлагад анхаарал хандуулан хуралджээ. Ази, Номхон далайн бүс нутгийн хувьд энэ чиглэлээр Тайланд Улсад сүүлийн 2 жил дараалан чуулган зохион байгуулсан нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүмүүсийг дэмжих таатай боломжийг бий болгож байна.³⁰

Олон улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих асуудал нь “хяналт-control” гэхээсээ илүүтэйгээр тусламж дэмжлэг үзүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх гэх ойлголтуудыг гол төлөв анхааран ажиллах болжээ. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд, дэлхий нийтийн хандлага ч мөн л хяналтыг халж туслах-нийгэмшүүлэх бодлогод чиглэж байна. Дэлхий дахинд шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд:

³⁰ Б.Одонгэрэл, Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцоо чухал болох нь, “Хууль сахиулах үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцсэн илтгэлээс.

1. Social control of criminals буюу нийгмийн хяналтын хэлбэр
2. Rehabilitation of criminals буюу нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр.

Энэ хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор тодорхойлогддог гэж судлаачид үздэг байна.³¹ Нийгмийн хяналт нь шоронгоос суллагдсан хүмүүсийг “засаршгүй хүмүүс” гэж үзээд “давтан, рецидив гэмт хэрэгтэн” хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж шоронгоос суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг ахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.³²

Харин либерал баримжаатай барууны гэгдэх орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын онолын үндэслэл 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.³³

2.1 ГЭМТ ХЭРЭГТНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх болон нийгэмд амжилттай эргэн нэгтгэх нь эрүүгийн процессын тогтолцооны суурь зорилтын нэг юм. Хүний эрхийн талаарх олон улсын гэрээ конвенцуудад тухайлбал, ИБУТЭТОУП-д “Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн

³¹ Г.Оюунболд, Г.Эрдэнбат, “Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь”, Бодлогын судалгааны тайлан, 2011 он

³² Г.Оюунболд, Г.Эрдэнбат, “Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь”, Бодлогын судалгааны тайлан, 2011 он

³³ Мөн тэнд.

хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана”³⁴ гэжээ.

Цаашилбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрүүгийн процессын талаарх НҮБ-ын олонх стандарт, хэм хэмжээ нь гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэхэд дэмжин тусалснаар улс орон нийгмээ хамгаалж, цаашид үйлдэгдэх олон гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадах ач холбогдлыг чухалчлан тусгасан байдаг. Тухайлбал, Хоригдлыг засан хүмүүжүүлэх НҮБ-ын наад захын жишиг дүрэм буюу Нелсон Манделагийн дүрэм (НМД)³⁵ нь хоригдлыг засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөр бүхий хорих менежментийг хэрэгжүүлэх зарчмыг тусгаж, рецидивизмыг бууруулж, нийгмийн аюулгүй байдлыг хангах талаарх хамгийн сүүлийн төдийгүй өндөр ач холбогдол бүхий олон улсын стандарт баримт бичиг юм. Түүнчлэн НМД-д гэмт хэрэгтэнд хэрэгцээтэй байгаа боловсрол, мэргэжлийн сургалт, ажлын байр, бусад халамжийн үйлчилгээ, туслалцааг онцлоод тэдгээрийн талаар хорих ангийн удирдлага, бусад эрх бүхий байгууллагууд анхаарч ажиллан хоригдлыг нийгэмд эргэн нэгтгэх явдлыг бүх талаар дэмжих ёстой гэжээ.³⁶

НҮБ-аас гаргасан дараагийн нэг нийтлэг жишиг баримт бичиг бол Эмэгтэй хоригдлыг засан хүмүүжүүлэх ба эмэгтэй гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял хэрэглэх тухай Бангкокийн дүрэм (2010)³⁷ буюу эмэгтэй гэмт хэрэгтэнд тусгайлан хэрэглэх олон улсын хэм хэмжээ юм. Тус дүрэмд хорих ангийн удирдлага, пробацийн алба, нийгмийн халамжийн үйлчилгээ, орон нутгийн нийгэмлэг, ТББ-ууд хамтран ажиллаж, суллагдахын өмнө болон

³⁴ ИБУТЭТОУП-ын 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. <https://www.legalinfo.mn/law/details/1257>

³⁵ https://www.unodc.org/documents/justice-and-prison-reform/Nelson_Mandela_Rules-E-ebook.pdf сүүлд зочилсон 2019.06.20

³⁶ НМД-ийн Дүрэм 4-ийн 1 дүгээр хэсэг. “Хорих ялын ба хүний эрх чөлөөг хязгаарлаж буй бусад арга хэмжээний зорилго нь нэн тэргүүнд гэмт хэрэгтнээс нийгмийг хамгаалах болон рецидивизмийг бууруулах юм. Энэхүү зорилго нь тэрхүү хоригдсон этгээд суллагдсаныхаа дараа нийгэмд хуулийг дагаж, өөрөө амьдрах чадвартай этгээдийг бий болгож нийгэмд эргэн нэгтгэх явдал юм.”

³⁷ https://www.unodc.org/documents/justice-and-prison-reform/Bangkok_Rules_ENG_22032015.pdf сүүлд зочилсон 2019.07.01

дараагаар нийгэмд эргэн нэгтгэх хөтөлбөрийг цогц байдлаар хэрэгжүүлж, эмэгтэй хоригдлын хүйсийн онцгой хэрэгцээг тусгайлан анхаарах ёстойг тусгажээ.

Хүүхдийн эрхийн конвенцод нэгдэн орсон улсуудын хувьд “хүүхдийг баривчлах, цагдан хорих, хорих зэрэг нь хамгийн сүүлийн арга хэмжээ байх ба хамгийн боломжит богино хугацаанд хэрэгжинэ” гээд хүүхдийг нийгэмд нэгтгэх явдлыг дэмжиж, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг анхааралдаа авах талаар заажээ.³⁸

Түүнчлэн хүүхэд, өсвөр насны хүнд зориулсан олон улсын дараагийн жишиг баримт бичиг бол НҮБ-ын Насанд хүрээгүй хүний талаарх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны наад захын жишиг дүрэм³⁹ (Бээжингийн дүрэм) юм. Дүрэмд эрх чөлөө нь хязгаарлагдсан хүүхдийг сургах, засан хүмүүжүүлэх зорилт тавьж, тэднийг халамжлан хүмүүжүүлэх, боловсрол болон мэргэжлийн чадвар олгох зэргээр нийгэмд эргэн нэгтгэх үйл явцыг дэмжих тухай заасан.⁴⁰ Мөн насанд хүрээгүй хүний зүгээс үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын удирдамж нь хүүхэд, өсвөр үеийг нийгэмшүүлэх ажиллагааны талаарх чухалчилсан заалтуудыг агуулсан байдаг.⁴¹

Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг өргөн хүрээнд авч үзэж, гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэхэд туслах болон бусад урьдчилан сэргийлэх механизмыг хэрэгжүүлснээр рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай өгүүлжээ.

Эцэст нь НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм)⁴² нь гэмт хэрэгтнийг

³⁸ НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, 37, 40 дүгээр зүйл.

³⁹ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1985 оны 11 сарын 29 өдөр баталсан. <https://www.ohchr.org/Documents/ProfessionalInterest/beijingrules.pdf> сүүлд зочилсон 2019.07.05

⁴⁰ Бээжингийн дүрэм, 24.1 болон 26.1 дүгээр зүйл.

⁴¹ Өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын удирдамж (Риядхын удирдамж) 10 дугаар зүйл.

⁴² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Гэмт хэрэгтнийг засан хүмүүжүүлэх сэдвийн хүрэн дэх НҮБ-ын 8 дугаар Конгрессоор Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм)-ийг 1990 онд баталсан.

нийгэмшүүлэх, эргэн нэгтгэх талаарх олон улсын баримт бичгийн нэг бөгөөд дээрх дүрэм, удирдамж зэрэг олон улсын нийтлэг зарчмуудын нэгэн адилаар гэмт этгээдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг дурдахаас гадна хорих ял болон түүнтэй дүйцэхүйц хүний эрх чөлөөг хязгаарласан арга хэмжээг хэрэглэх явдлыг бууруулах, олон ургалч хандлагаар хандахыг чухалчилснаараа онцлогтой юм. Түүнчлэн энэхүү дүрэмд гэмт хэрэгтнийг эргэн нэгтгэхийн ач холбогдол, түүнд олон нийтийн оролцоо ихээхэн чухал болохыг, ингэснээр иргэд нийгмээ хамгаалах, хувь нэмрээ оруулах том боломжтой болохыг нь онцолсон байдаг.⁴³

2.2 ГАДААД ОРНЫ САЙН ТУРШЛАГААС СУРАЛЦАХ НЬ

Судалгааны энэ хэсэгт гэмт хэргийн гаралт болон рецидив гэмт хэрэг багатай, нийгэмшүүлэх үйл ажиллагаагаар Азидаа төдийгүй дэлхий нийтэд сайн туршлагыг нэвтрүүлж жишиг болж байгаа эх газрын эрх зүйн тогтолцоотой Япон Улсыг сонгон авч дэлгэрэнгүй судаллаа. Япон Улсад ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагааны талаар Азийн орнуудад зориулсан томоохон хэмжээний сургалт болон бусад арга хэмжээг зохион байгуулдаг төдийгүй гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх үйл ажиллагааны 48000 сайн дурын ажилтантай гэдгээрээ дэлхийд нэгдүгээрт бичигдсээр байгаа юм.

Мөн эсрэгцүүлэн гэмт хэргийн гаралт өндөр боловч нийгэмшүүлэх үйл ажиллагааг ихээхэн анхааран ажилладаг АНУ-ыг нийтийн эрх зүйн тогтолцоотой улсуудын төлөөлөл болгон товч байдлаар харьцуулан үзлээ.

Хорих ангиас олон нийтийн дунд орох шилжилтийн хугацаа нь суллагдсан этгээдэд сэтгэлзүйн болон бусад байдлаар нэлээд хүндрэлтэй үе шат байдаг тул улс орнуудын төр засаг энэ асуудалд анхаарч, эргэн нэгтгэхэд туслах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хорих ялаас суллагдсан этгээд хөдөлмөр эрхлэх, орон байр олох,

⁴³ Токиогийн дүрэм, 1.5, 17.2, 18.3 болон 18.4 зэрэг.

бусадтай тасалдсан харилцаагаа сэргээх, нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөх, түүнийг даван туулах, төрийн албан ёсны хяналтад байх зэрэг олон төрлийн нийгмийн харилцаанд шууд орохын зэрэгцээ түүнийг дагасан айдас, стресстэй тулгардаг.

Хоригдлуудыг суллахын өмнөх болон дараах долоо хоногуудад тэднийг эргэн нийгэмшүүлэхэд хүрч болох цар хүрээг тодорхойлох нь чухал ач холбогдолтой болохыг тогтоожээ. Австралийн (Queensland) хоригдлуудын дунд явуулсан судалгаагаар ярилцлагад орсон хоригдлуудын тэн хагас нь суллагдахын өмнөх долоо хоногт сэтгэл зүйн хямралтай байгааг илрүүлжээ.⁴⁴

2.2.1 Япон Улсын туршлага

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагааны түүх, ач холбогдол, тогтолцоо

Нийгмийг хамгаалах, хувь хүний болон нийгмийн сайн сайхан байдлыг төвхнүүлэх үүднээс гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх хөтөлбөрийг Япон Улсад эрчимтэй хэрэгжүүлдэг. Гэмт хэрэгтний өөртөө итгэх байдал, хувь хүний хөгжлийг дэмжих замаар давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, хэрэг зөрчлийг бууруулах боломжтой гэж үздэг. Суллагдсаны дараах “шинэ амьдрал”-д нь төрийн болон олон нийтийн зүгээс тусалж, нийгэмшүүлэх үйлчилгээг гэмт хэрэгтэнд үзүүлэх нь тэднийг дахин нийгмийн гишүүн болж амьдрахад ихээхэн тустай.

Гэмт хэрэг, зөрчлөөс ангид нийгэмд амьдрах нь хүн бүхэнд тааламжтай байх нь ойлгомжтой. Иймд өөртөө тааламжтай тэрхүү нийгмийг бүрдүүлэхийн тулд эхний алхам бол иргэн бүр эерэг хандлагаар гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд гар гараа нийлүүлэн, зүрх сэтгэлээр хандах ёстой гэсэн төрийн бодлого Япон Улсад хэрэгждэг.⁴⁵

⁴⁴ Б.Одонгэрэл, Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцоо чухал болох нь, “Хууль сахиулах үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцсэн илтгэлээс.

⁴⁵ Хууль зүйн яамны Нийгэмшүүлэх Алба, “Ялтныг нийгэмшүүлэх нь”, UNICEF 159 дугаар сургалт-зөвлөгөөний материалаас, 2015 он, Токио, Япон Улс

Япон Улсад анх 1888 онд Шизүока мужид гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагааг хангах үүрэг бүхий гэмт хэрэгтнийг хамгаалах байгууллага байгуулагдаж, хорих ялаас суллагдсан этгээдийг орон байр, ажиллах газраар хангаж байсан ба мужийн хэмжээнд 1700 ажилтан тэднийг дэмжих үйл ажиллагаа явуулж байсан түүхтэй. Үүний дараагаар буюу 1922 онд сайн дурын ажилтнуудаар хүрээгээ тэлсэн ба үйл ажиллагаа нь зөвхөн хорих ялаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэхээс гадна тэнсэн харгалзах болон ял хойшлуулсан этгээдийг хамруулж эхэлсэн байна.

Сайн дурын пробацийн ажилтан

Азийн орнуудаас Япон Улс нь гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх ажилд олон нийтийн оролцоог чухалчилж байгаа төдийгүй сайн дурын пробацийн ажилтныг олноор нь ажиллуулдаг. Японд сайн дурын пробацийн ажилтан нь 2 жилээр томилогдох ба 76 нас хүртлээ хэдэн ч удаа улиран сонгогдож болно. Тус ажилтан нь нийгмийн өндөр ёс суртахуунтай, сайн дураараа ажиллах хүсэл эрмэлзэлтэй, амьжиргааны хувьд боломжтой, эрүүл байх ёстой. Үйл ажиллагааны зардлыг төрөөс олгох ба цалин авдаггүй сайн дурын нийтийн ажилтан байдаг.

Сайн дурын пробацийн ажилтнаас гадна Нийгэмшүүлэх туслалцааны эмэгтэйчүүдийн нийгэмлэг, ББС (Big Brothers and Sisters Movement) нийгэмлэг зэргээр төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог. Хорихоос суллагдсан гэмт хэрэгтний анкетад гэмт хэргийн мэдээлэл нь хавсарч байдаг тул суллагдсаны дараагаар ажил олох нь тус улсад нэлээд хүндрэлтэй байдаг. Иймд хамтран ажилладаг ТББ-ууд ажил олгогчтой хамтран ажиллаж гэмт этгээдэд тусалдаг. Тус улсад 11000 компани гэмт хэрэгтэнд ажил олгох асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг.⁴⁶

Түүнчлэн Нийгэмшүүлэх байр улсын хэмжээнд 104 байх ба тус байранд хорихоос суллагдсан этгээдийг түр хугацаанд байр, хоолоор хангаж үйлчилнэ. Хууль зүйн яамнаас авсан зөвшөөрлийн

⁴⁶ Хууль зүйн яамны Нийгэмшүүлэх Алба, “Ялтныг нийгэмшүүлэх нь”, UNIFEI 159 дугаар сургалт-зөвлөгөөний материалаас, 2015 он, Токио, Япон Улс

дагуу хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааг явуулдаг. Энэхүү байгууллага нь орон байр, хоолоор хангахаас гадна нийгмийн чадамжийн болон архи, мансууруулах бодист донтсон этгээдэд зориулсан сургалтууд зохион байгуулдаг байна.⁴⁷

Эрүүгийн процессын үйл ажиллагааны тогтолцоо

Япон Улсын эрүүгийн процессын тогтолцоо цагдаагийн байгууллагаас эхлэх ба прокурор, шүүх (гэр бүлийн шүүх) байгууллагаар дамжин шийдвэр гүйцэтгэх байгууллага, пробацийн буюу нийгэмшүүлэх байгууллагаас бүрдэнэ. Шүүхээс ихэвчлэн хорих ял, хорихоос өөр төрлийн ял оногдуулах, хорих ял эдлэхийг хойшлуулах, насанд хүрээгүй хүмүүсийг сургалт хүмүүжлийн байгууллагад байлгах, пробацийн хяналтад байх гэсэн шийтгэлүүдийг оногдуулна.

UNAFEI⁴⁸-аас эрхлэн гаргадаг Япон Улсын Эрүүгийн процесс 2019⁴⁹-д тус улсад цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, нийгэмшүүлэх байгууллага гэсэн 5 үе шаттай гэжээ.⁵⁰ Нийгэмшүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд Бүс нутгийн хугацаанаас өмнө суллаж хяналт тавих асуудал хариуцсан Зөвлөл хариуцах ба хорих ангийн саналыг харгалзаж шийдвэрлэдэг. Зөвлөл дараах 4 төрлийн этгээдийг нийгэмшүүлэх, пробацийн үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

1. Probationer буюу ял эдлүүлэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэр бүхий этгээд;
2. Parolee буюу зохих хугацааны хорих ялаа эдлээд эрх бүхий байгууллагын шийдвэрээр хугацаанаас өмнө суллагдсан хоригдол;⁵¹
3. Насанд хүрээгүйчүүдийн сургалт хүмүүжлийн байгууллагаас батлан даалтад гарсан этгээд;
4. Хяналтад байгаа насанд хүрээгүй этгээд болно.

⁴⁷ Мөн тэнд.

⁴⁸ United Nations Asia and Far East Institute for the Prevention of Crime and the Treatment of Offenders (UNAFEI)

⁴⁹ https://www.unafei.or.jp/publications/pdf/CJSJ_2019/00CJSJ_2019.pdf

⁵⁰ https://www.unafei.or.jp/publications/CJSJ_2019.html сүүлд зочилсон 2019.07.02

⁵¹ Тухайлбал, 2017 онд 21998 хоригдол тус улсад суллагдсанаас 12760 буюу 58.0 хувь нь хугацаанаас өмнө суллагдаж, пробацийн хяналтад орсон байна.

Пробацийн үйл ажиллагаа

Пробаци нь гэмт хэрэг үйлдсэн хүн болон насанд хүрээгүй этгээдийг нийгмийн гишүүн болгож нийгэмшүүлэхээр зорьж буй төрийн байгууллагын эрх хэмжээний хүрээнд хийгдэж буй хяналт болон туслалцааны нэгдмэл хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, тодорхой нөхцөл байдал бүхий зарим төрлийн гэмт хэрэгтэнд хорих ялыг нь эдлүүлэхгүйгээр тэнсэн харгалзаж буй албадлагын арга хэмжээ бөгөөд Япон Улсын хувьд ялын төрөл гэж үздэггүйгээрээ манай улстай ижил юм. Япон Улсад 2017 онд 52250 гэмт хэрэгтэнд хорих ял оногдуулснаас 32263 буюу 61.7 хувь нь тэнсэгдэж, түүний 2595 этгээдэд пробацийн хяналт тогтоосон байна.

Энэ үйл ажиллагааг пробацийн ажилтан, сайн дурын пробацийн ажилтан хамтран явуулах ба тус улсын Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх хуульд зааснаар “дүрэм журам-хяналт”, “зааварчилга-туслалцаа” гэсэн 2 хэлбэрийг хэрэглэдэг.⁵²

Дүрэм журам, хяналтад дээрх 4 төрлийн этгээдэд тэдний зан авирыг ойлгох үүднээс ярилцах болон бусад тохиромжтой аргыг ашиглан “харилцаа тогтоох”, хяналтын хугацаанд тэдний амьдралд дүрэм журмыг мөрдүүлэх, мөрдүүлэхээр тодорхой арга хэмжээг авах, гэмт хэрэгтний онцгой авьяас, эрмэлзлийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг багтана. Харин зааварчилгаа буюу туслалцаанд орон байртай болох, эрүүл мэндийн туслалцаа авах, мэргэжлийн зааварчилгаа авах, ажил хөдөлмөр эрхлэх, боловсрох зэрэгт нь туслах асуудлууд багтахаас гадна амьдрах хэв маягаа бүрдүүлэх, нийгмийн нөхцөл байдалд дасан зохицох зэрэгт нь тусалдаг. Түүнчлэн зарим тохиолдолд тухайн хүнд “яаралтай тусламж” үзүүлэх нь бий. Тухайлбал, 2017 онд 5452 хүн энэ тусламжийг авсан байна.⁵³

Ялтныг нийгэмшүүлж буй Япон Улсын туршлагад дурдах ёстой асуудал бол хорих ангиас суллагдаад өөрийн гэсэн орон байргүй этгээдийг улсаас байраар хангах чиг үүрэг бүхий гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх Үндэсний төвүүд юм.

⁵² Япон улсын Эрүүгийн процесс 2019, 45 дахь тал. https://www.unafei.or.jp/publications/pdf/CJSJ_2019/00CJSJ_2019.pdf

⁵³ Мөн тэнд.

2.2.2 АНУ-ын туршлага

АНУ-д хугацаанаас өмнө тэнсэн харгалзаж суллах, суллагдсаны дараагаар хянан харгалзах байдлаар хорихоос суллагдсан этгээдэд төрийн зүгээс хяналтын үйл ажиллагаа явуулдаг. Суллагдаж буй бүх гэмт хэрэгтний хувьд биш ч гэсэн ихэнх тохиолдолд өндөр эрсдэл бүхий гэмт хэрэгтэнд хяналтын механизм ажиллах ба тэдгээр гэмт хэрэгтэнд дахин гэмт хэрэг үйлдэх өндөр эрсдэл бүхий этгээдээс гадна онц ноцтой болон хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн, бэлгийн хүчирхийллийн хэрэг үйлдсэн гэмт хэрэгтнийг эрсдэлийн нөхцөл бага байсан ч хяналтад авдаг.

АНУ-д сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт өссөөр байгаа хэдий ч түүнд оногдуулж буй хорих ялын статистик буурч байгаатай холбоотойгоор тэнсэн харгалзах хүний тоо буурч байна. 2007 онд 4.3 сая хүн тэнсэнтэй байсан бол 2014 онд 3.9 сая хүн тэнсэн буюу пробацийн арга хэмжээ авагдсан гэсэн мэдээ байна.⁵⁴ 2016 онд 3.725.600 хүнд (пробацийн болон паролын арга хэмжээ) тэнсэх арга хэмжээ авагдсан нь өмнөх жилийнхээс 1.4 хувь буурсан гэж АНУ-ын Хууль зүйн яамны статистикт дурджээ.⁵⁵ Түүнчлэн 2016 оны байдлаар нийт хорих ял оногдуулсан этгээдийн 56 хувь нь тэнсэнтэй байна.⁵⁶

Харин хугацаанаас өмнө суллагдсан этгээдийн тухайд 2013 онд гэхэд 853.215 хүн (хүн амын тоонд харьцуулан үзэхэд 100.000 хүн тутамд 300 хүн гэсэн үг) хугацаанаас өмнө суллагдсан тоон мэдээ байгаа юм.⁵⁷ 2015-2016 оны хооронд 475.200 хүнээс 457.100 болж буурсан нь 1.7 хувийн үзүүлэлт юм.⁵⁸ Тус улсад Пробацийн

⁵⁴ Риан М Лабрикью, “АНУ дахь пробацийн тогтолцооны түүхэн ба орчин үеийн чиг хандлага”, https://pdxscholar.library.pdx.edu/cgi/viewcontent.cgi?article=1029&context=ccj_fac сүүлд зочилсон 2019 оны 8 сар.

⁵⁵ 2016 оны АНУ дахь пробацийн ба паролын нөхцөл байдал, АНУ-ын Хууль зүйн яамны Хууль зүйн хөтөлбөрийн алба, <https://www.bjs.gov/index.cfm?ty=pbdetail&iid=6188>

⁵⁶ Риан М Лабрикью, “АНУ дахь пробацийн тогтолцооны түүхэн ба орчин үеийн чиг хандлага”, https://pdxscholar.library.pdx.edu/cgi/viewcontent.cgi?article=1029&context=ccj_fac сүүлд зочилсон 2019 оны 8 сар.

⁵⁷ Нэгдсэн улсын ял шийтгэлийн тайлан, цуврал 28, № 2, 2015 он. 101 дэх тал.

⁵⁸ 2016 оны АНУ дахь пробацийн ба паролын нөхцөл байдал, АНУ-ын Хууль зүйн яамны Хууль зүйн хөтөлбөрийн алба, <https://www.bjs.gov/index.cfm?ty=pbdetail&iid=6188>

алба 456 байдаг бол паролын үйл ажиллагаа явуулдаг 53 агентлаг байдаг.⁵⁹ АНУ-д гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг уялдуулан халамжлах ба хянах гэсэн стратегийг баримтлах болжээ.⁶⁰

Суллагдсаны дараах хяналтын арга хэмжээ нь суллагдсанаас хойш эхний саруудад идэвхтэй байх ба Паролын алба (Parole Board) нь хяналтын хугацаа, нөхцөл зэргийг тодорхойлдог. Хяналтад байгаа этгээд паролын ажилтанд тогтмол мэдээлэл өгч, тайлагнах, гэмт үйлдлээс зайлсхийх, галт зэвсэг эзэмшихгүй байх, оршин суугаа газраасаа гадагш гарахгүй байх, хууль ёсны ажил, гэрийн хаягтай байх, хар тамхи, архи хэрэглэхээс татгалзах гэсэн нөхцөлүүдийг сахин биелүүлдэг нь манай улсын ШШГТХ-аар хяналтад байгаа этгээдэд хүлээлгэдэг үүрэгтэй ижил шинжтэй байна. Түүнчлэн хяналтын ажилтан нь тухайн этгээдийн суурь боловсрол, ял шийтгэлийн түүх, гэмт хэргийн нөхцөл байдал, хувийн болон гэр бүлийн байдал, хэрэгцээ, эрсдэлийн төвшин зэргийг шүүхэд хүргүүлж паролын хяналтад орох эсэхийг шүүхээр шийдвэрлүүлдэг.

Харин “онцгой нөхцөл”-д хохирогчтой холбоо тогтоохыг хориглох, хорт зан үйлээс татгалзах сургалтад хамрагдах, нийтэд тустай ажил үйлчилгээ эрхлэх, нөхөн төлбөр болон бусад төлбөр төлөх зэрэг багтана.⁶¹ Монгол Улсад эдгээр нь ЭХ-д заасан албадлагын арга хэмжээний төрлүүд байдаг ба хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналтын нэг хэсэг болохгүй юм. Тус улсад хугацаанаас өмнө суллагдаж буй гэмт хэрэгтэнтэй дээрх нөхцөлийг тогтоосон гэрээг хийх ба гэрээний нөхцөлийг зөрчвөл эдлэх ёстой ялын үлдсэн хугацаанд хорих ангид ял эдлүүлэхээр буцаадаг. Нэг онцлог нь тус улсад паролын хяналтад байгаа гэмт этгээд нь тодорхой хэмжээний төлбөр төлөх ба өөрөөр хэлбэл, архи, хар тамхины тестэд орох, нийтийн үйлчилгээнд хамрагдах зэрэг зардлыг өөрөө төлдөг зохицуулалттай.

⁵⁹ Мөн тэнд.

⁶⁰ Риан М Лабрикью, “АНУ дахь пробацийн тогтолцооны түүхэн ба орчин үеийн чиг хандлага”, https://pdxscholar.library.pdx.edu/cgi/viewcontent.cgi?article=1029&context=ccj_fac сүүлд зочилсон 2019 оны 8 сар.

⁶¹ Мөн тэнд.

-ГУРАВДУГААР БҮЛЭГ-

ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих ажиллагаа нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх чиг хандлагыг бус ЭХ болон ГХУСТХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд явагдаж байгаа нь эрх зүйн зохицуулалт болон өнөөгийн нөхцөл байдлаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, төрийн зүгээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх нь тэднийг нийгэмшүүлэх үйл явцаас илүү чухал гэж үзэж байна.⁶²

Иймд Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналтын хэлбэрийн *Social control of criminals* буюу нийгмийн хяналтын хэлбэрийг хэрэглэж хорихоос суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих анхаарал халамж, хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг ахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэсэн үзэл хандлагыг баримталж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсад нийт суллагдсан этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэх явдал 2014 оноос өнөөдрийг хүртэл төдийлөн буураагүй. Тухайлбал, 2014 онд Монгол Улсад 26 хорих ангид 6500 хоригдол ял эдэлж байгаагийн 47.2 хувь нь⁶³, 2018 оны байдлаар 3500 хоригдлын 1614 буюу 46.1 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн байгаагаас⁶⁴ үзэхэд гэмт хэрэгтнүүдийг нийгэмшүүлэн “хянах” төрийн механизм сул байгааг харуулж байгаа юм.

Хугацаа дуусаж хорих ялаас суллагдсан, хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, ял хойшлуулсан, чөлөөлөгдсөн, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн зэрэг нийгмийн хяналт тавих эрх зүйн зохицуулалттай гэмт этгээдэд хяналт тавих, тэднийг нийгэмшүүлэх явдлыг үр нөлөөтэй болгох үүднээс дараах хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

⁶² Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйл. 2015 он.

⁶³ Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал, судалгааны тайлан, УБ.,2014 он.

⁶⁴ ИШПГЕГ-ын 2019 оны дүн мэдээнээс авч ашиглав.

3.1 МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРЭГТНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ ИЖ БҮРЭН БҮРДҮҮЛЭХ НЬ

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх нийгмийн үүрэг нь хоригдлуудын суллагдах хугацаагаар төгсөх ёсгүй. Тиймээс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд суллагдсан хоригдолд учирч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, тэднийг нийгэмшүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн үр дүнтэй үйлчилгээг үзүүлэх чадвартай байх ёстой.⁶⁵ Монгол Улсад нийгэмшүүлэх ажлыг амжилттай, үр дүнтэй болгохын тулд гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тогтолцоог 3 үндсэн бүрэлдэхүүнтэйгээр авч үзэх нь зохистой.

3.1.1 Гэмт хэрэгтэн хорих ял эдэлж байх явцдаа нийгэмших

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх асуудлыг хорих ангид ял эдэлж байх явцад нь нийгэмшүүлэх, ялаа эдлээд суллагдсаны дараа нийгэмшүүлэх гэж 2 ангилан үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, ял эдэлж байгаа гэмт хэрэгтнийг гэр бүлийнхэнтэй нь байнгын харилцаа холбоотой байхыг төрийн зүгээс дэмжих, төрөл бүрийн сэтгэл зүйн болон бусад сургалтад хамруулах, “хананы цаадах” амьдралын талаарх мэдээллээр хангаж байх нь тухайн этгээд нийгмээс хэт тусгаарлагдахгүй байх, хорих ангиас суллагдсаны дараагаар нийгэмдээ эргэн нэгдэхэд хялбар байх боломжийг бүрдүүлнэ.

Монгол Улсад ялтан, тэдний гэр бүлийн гишүүд хоорондын харилцааг хорих ангийн зүгээс ихээхэн дэмжин ажиллаж байгааг судалгаагаар гаргажээ. Тухайлбал, хорих ангиуд нээлттэй хаалганы өдөрлөг зохиох, гэрлэлтийг нь баталгаажуулах, эргэлт уулзалт зохион байгуулах, гэр бүлийн уялдаа холбоог сайжруулах үүднээс гэр бүлтэй нь утсаар яриулах зэрэг ажлыг хэрэгжүүлдэг байна. ШШГТХ-ийн 218 дугаар зүйлийн 218.1 дэх хэсэгт хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлыг тодорхойлж, хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг

⁶⁵ Нелсон Манделагийн дүрэм 90-р заалт

үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшилтийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ гэсэн байна.

“Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.”⁶⁶ гэсний дагуу ШШГБ-ийн бүтцэд Нийгэм, сэтгэлзүйн хэлтэс ажилладаг.

Энэхүү хэлтэс нь хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна⁶⁷ гэж хуульчилсан бөгөөд үүний дагуу хорих ангид даалин хийх, зүү ороох оёдол заах ажил мэргэжлийн дадал олгох сургалтад хамруулдаг байна. Мөн бичиг үсэг сургах, ерөнхий боловсролын сургалтад хамруулж гэрчилгээ олгох, 2019 онд батлагдсан Сэтгэлзүйн ажлын зааврын дагуу сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах чиглэлээр ч ажилладаг.⁶⁸

3.1.2 Хорих ангиас суллагдсаны дараа нийгэмд нь эргэн нэгтгэх

Монгол Улсад гэмт хэрэгтнийг суллагдсаны дараа нийгэмшүүлэх нь одоог хүртэл асуудал дагуулсаар байгаа бөгөөд энэ нь хорих ялаа эдлээд гарсан хүмүүсийн 47.8 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар дахин шийтгэгдэж байгаа тоо баримтаас харагдаж байна. Хорихоос суллагдсаны дараа нийгэмдээ эргэн нэгдэхэд нь ялтанд хорих ангийн зүгээс дэмжлэг үзүүлэх ажил хангалтгүй гэж 71.2 хувь нь хариулжээ. Тэд зөвхөн ар гэрийнхэнтэйгээ

⁶⁶ ШШГТХ-ийн 219 дугаар зүйл.

⁶⁷ ШШГТХ-ийн 219 дугаар зүйл.

⁶⁸ ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс авсан ярилцлагын судалгаанаас.

ярилцдаг гэж дийлэнх хувь нь хариулсан бөгөөд гэр бүлийнхэн нь ч ойлгодоггүй гэжээ.⁶⁹

Гэмт хэрэгтнийг суллагдсаны дараагаар нийгэмшүүлэх ажиллагааг явуулдаггүй нь тэднийг гэмт хэрэг дахин үйлдэх гол шалтгаан болдог. Хорих ангиас ялаа эдлээд суллагдсан этгээдэд ШШГБ нийгэмшүүлэх чиглэлээр ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй.⁷⁰ Харин ЦБ зөвхөн ГХУСТХ-ийн дагуу зарим төрлийн гэмт хэрэг үйлдээд суллагдсан хүнд захиргааны хяналт тавьдаг. Ингэхдээ ЦБ тухайн этгээдийн оршин суугаа хаягийг тэмдэглэн жагсаалтад бүртгэн авах ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйл ажиллагааг явуулах хэдий ч нийгэмшүүлэх үйл ажиллагаа хийдэггүйг дээр дурдсан билээ.⁷¹

Иймд Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд төрийн зүгээс хяналт тавихаас бус тэднийг нийгэмд нь эргэн нэгтгэх, тусалж дэмжих, нийгэмшүүлэх ажиллагаа хийгдэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байгаа юм.

3.1.3 Хорихоос өөр төрлийн ял оногдуулах буюу нийгэмд суурилсан арга хэмжээг хэрэглэх

Гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн алтернатив ял оногдуулж, нийгэмд нь засан хүмүүжүүлэх нь олон талын ач холбогдолтой. 2015 оны Эрүүгийн хуулиар хорих ялыг багасгах, хорихоос өөр төрлийн ялыг нэмэгдүүлж нийгэмд суурилсан арга хэмжээг хэрэглэх үзэл баримтлалаар торгох, эрх хасах ялаас гадна зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг шинэ ялын төрлийг нэмсэн. Гэсэн хэдий ч Эрүүгийн хуульд шинээр хуульчилсан зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх санхүүгийн боломжгүйн улмаас хэрэгжүүлэх хугацааг 2 удаа сунгаж, одоог хүртэл үйлчилж эхлээгүй байгаа юм. Түүнчлэн нийтэд тустай ажил хийлгэх ялыг барууны сонгодог жишгээр бус

⁶⁹ Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал судалгааны тайлангаас иш татав. 2014 он, УБ хот, 62 дах тал

⁷⁰ Энэхүү асуудал нь ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс авсан ярилцлагын судалгаанд дурдагдсан болно.

⁷¹ Нийслэлийн Баянзүрх дүүргийн ... дугаар хорооны хэсгийн байцаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын судалгаанаас.

хуучин албадан ажил хийлгэх ялыг нэрийг нь өөрчлөх төдийгөөр “шинэчилсэн” зэрэг нь хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийн үр нөлөө Монгол Улсад сул байгааг харуулж байна.

Цаашид гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх үүднээс хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх, *community based treatment* буюу нийгэмд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ гадаад улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөн хүрээтэй хэрэглэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

3.2 ХОРИХ ЯЛААС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД “ШИЛЖИЛТИЙН ҮЕ”-ИЙГ ДАВАН ТУУЛАХАД ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

Хорихоос суллагдсан этгээд нийгэмд шилжиж орох үед материаллаг байдлын хомсдол, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг байхгүйгээс тэдний ихэнх нь суллагдахаас зайлсхийх, дахин гэмт хэрэг үйлдэж баригдах магадлал өндөр байдаг гэж судлаачид тогтоожээ. Суллагдсаныхаа дараа хадгаламж, хуримтлалгүй этгээдэд ажилд орж цалинтай болох хүртэл санхүүгийн хэрэгцээгээ зохицуулах, өдөр тутмын хэрэгцээгээ хангахад хүндрэл учирдаг байна. Санхүүгийн эдгээр хүндрэл бэрхшээлийг даван туулахад төрийн зүгээс туслах нь тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх төдийгүй нийгэмшихэд нь нөлөөлөх боломжтой.

Судалгаагаар хөдөлмөр эрхлэлт, орон сууц, гэр бүлийн дэмжлэг, донтох эмчилгээ болон эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамжийн хүртээмж, санхүүгийн туслалцаа, бусад хүмүүсийн тэдэнд хандах хандлага гэсэн үзүүлэлтүүд хорихоос суллагдсан этгээдэд чухал үүрэгтэйг илрүүлсэн байдаг.⁷² Эдгээрээс заримыг дэлгэрүүлж авч үзье.

⁷² НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецидивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 5 дахь тал.

3.2.1 Ажил хөдөлмөр эрхлэх

Хөдөлмөр эрхлэлт нь хорих ялаас суллагдсан тухайн этгээдэд санхүүгийн буюу материаллаг нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн ач тустайгаас гадна нийгмийн сүлжээнд бусад хүмүүстэй харилцаа холбоо үүсгэх сайн талтай. Үүнээс гадна ажил хөдөлмөр эрхэлснээрээ өөрийгөө үнэлэх, өөртөө итгэх итгэл, сэтгэл зүйн эрүүл мэнд нь сайжирдаг гэж судлаачид үздэг байна.⁷³

Ажил олгогчид “гэмт хэрэгтэн” гэсэн шошготой ажилтантай болохыг хүсдэггүй тул тэднийг ажлын байраар хангахаас татгалздаг. Энэхүү бэрхшээлийг нь арилгаснаар суллагдсан этгээдэд нийгэмших боломж ихээхэн дээшилдэг тул улс орнууд энэ асуудалд нэлээд анхаардаг. Тухайлбал, ХБНГУ-д ялаа эдэлж дууссаны дараа ялтан нь хорих ангид суралцсан чиглэлээрээ “Ажил олгох газар”-т бүртгүүлэх бөгөөд энэ байгууллага нь хорих ял эдлээд суллагдсан хэнд боловч үйлчилдэг.⁷⁴ Харин Японд гэмт хэрэгт холбогдож, хорих ял эдлээд суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлж, ажлын байраар ханган ажилладаг 11000 ажил олгогч компани, хуулийн этгээд байдаг. БНСУ-д хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг ажлын байраар хангасан компанид төрийн зүгээс татварын хөнгөлөлт олгодог эрх зүйн зохицуулалттай ба энэ нь эерэг үр дүн авчирч байна гэж үзэж байна. Ял эдлээд дууссаны дараа эргээд нийгэмд ороход нь туслах зорилгоор болон нийгэмтэйгээ адил хөгжих, хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхийн тулд Герман Улс нь ял эдэлж байгаа хүмүүст тусгай боловсрол эзэмших янз бүрийн арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд өөрөө хөгжих, эргээд нийгэмд орох зэрэгт байнга бэлддэг.⁷⁵

Ажлын байртай болгох зорилгоор хоригдлыг төрөл бүрийн сургалтад хамруулдаг сайн туршлагыг манай улсад нэвтрүүлэхээр зарим талаар оролдож байгааг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал, хорих ангид мэргэжлийн чиг баримжаа олгох, ялангуяа мужаан, гар урлал, оёдлын технологийн чиглэлээр сургалт явуулдаг сайн тогтолцоотой. Түүнчлэн сургалтад хамрагдаж мэргэжил эзэмшсэн

⁷³ Мөн тэнд.

⁷⁴ Г.Оюунболд, Г.Эрдэнбат, “Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь”, Бодлогын судалгааны тайлан, 2011 он

⁷⁵ Мөн тэнд.

хэдий ч тохирох ажлын байр олдохгүй байгаа тохиолдолд нөхөн олговор олгодог тогтолцоог судалж үзэх нь зүйтэй.⁷⁶ Өөрөөр хэлбэл, санхүүгийн хүндрэлтэй байдал нь дахин гэмт хэрэг хийх шалтгаан нөхцөл болж буй талаар төрийн байгууллагын ажилтнууд ярилцлагын судалгааны явцад өгүүлж байсан.⁷⁷ Иймд хорихоос суллагдсан этгээдийг ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэх нь тэднийг шилжилтийн үеийг даван туулж нийгмийн гишүүн болоход ихээхэн ач холбогдолтой. Манай улсад Солонгос Улсын туршлагаар хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг ажлын байраар хангасан компанид төрийн зүгээс татварын хөнгөлөлт олгох зэргээр суллагдсан этгээдийг ажлын байраар хангах тал дээр анхааран ажиллах шаардлагатай.

3.2.2 Орон байр, санхүүгийн туслалцаа

Орон байртай байх нь гэмт хэрэгтнийг нийгэмших гол хүчин зүйлийг нэг мөн. Орон гэргүй байх нь гэмт хэрэг дахин үйлдэх шалтгаан болж, хорих ангид буцаж очих зайлшгүй шалтгаан болох нь бий. АНУ зэрэг барууны орнууд, Азийн өндөр хөгжилтэй улсад bootcamp, halfway house зэрэг түр орон байраар хангах үйлчилгээг Пробацийн алба нь хариуцан гүйцэтгэнэ. Тухайлбал, Япон Улсад “Нийгэмшүүлэх байр” улсын хэмжээнд 104 байх ба тус байранд хорихоос суллагдсан этгээдийг түр хугацаанд байр, хоолоор хангаж үйлчилнэ. Хууль зүйн яамнаас авсан зөвшөөрлийн дагуу хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг сайн туршлага Япон Улсад байна. Монгол Улсад Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.3-т “хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж олгоно” гэсэн байдаг ч энэ нь 1-2 сая орчим төгрөг байдаг тул санхүүгийн асуудлыг бүрэн шийдэх хэмжээний мөнгөн тэтгэмж болж чаддаггүй төдийгүй иргэдэд хүртээмжтэй бус байна.⁷⁸

⁷⁶ ХБНГУ-д ажилгүйдлийн тэтгэмж 400 еврогоос дээш олгодог байна.

⁷⁷ Нийслэлийн Баянзүрх дүүргийн ... дугаар хорооны хэсгийн байцаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын судалгаанаас.

⁷⁸ ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс авсан ярилцлагын судалгаанаас

3.2.3 Эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын хүртээмж

Олон улсын нийтлэг стандартын дагуу хорихоос суллагдсан этгээд нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байх нь эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй байх нөхцөл биш юм гэж үздэг.⁷⁹ Улс орон суллагдсан хоригдлыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээх нь хүний эрхийг хангаж буй хэрэг юм. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын туслалцаа авах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь Монгол Улсад сайн туршлага болно. Суллагдсан хоригдлыг ДОХ, сүрьеэ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хар тамхины донтолтын эмчилгээнд хамруулах явдлыг төрийн чиг үүрэгт хамруулах нь зүйтэй гэж олон улсын баримт бичигт өгүүлжээ.⁸⁰

3.2.4 Гэр бүлийн дэмжлэг

Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх хамгийн чухал үүргийг гэр бүл гүйцэтгэдэг нь маргаангүй. Гэр бүлийн гишүүдтэйгээ ойр дотно байж, тэдний дэмжлэгийг авч байгаа этгээд бусдыгаа бодвол ажил олох, санхүүгийн болон бусад асуудлаа шийдэхэд дөхөмтэй байдгийг судлаачид нотолсон байна.⁸¹ Гэтэл Монгол Улсад хорих ялаар шийтгүүлсний улмаас амьдралд нь гарсан өөрчлөлтийн талаарх судалгаанд 35.3 хувь нь гэр бүл салсан, 16.8 хувь нь хүүхэд нь тэнэмэл болсон гэж хариулжээ.⁸²

Гэр бүл тухайн гэмт хэрэгтнийг нийгэмшихэд ихээхэн нөлөөтэй гэж үзэж АНУ-д Greenlight Family Home Reintegration хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба энд ялангуяа насанд хүрээгүй хүнийг эцэг эхтэй нь нэгтгэх, гэр бүлийн орчныг хадгалах, хүүхдийн аюулгүй

⁷⁹ НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецидивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 6 дахь тал.

⁸⁰ Мөн тэнд. 7 дахь тал.

⁸¹ Мөн тэнд.

⁸² Хорих байгууллагаас суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх шаардлага, тогтолцооны шинэчлэл, илтгэлээс авч ашиглав. <https://prezi.com/-jrxbrwnuh-b/presentation/> сүүлд зочилсон 2019.07.04

байдлыг хангах зэрэгт төрийн болон хувийн байгууллагууд хамтарч оролцдог байна.⁸³

3.3 ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨТЭЙ АРГУУДЫГ АШИГЛАХ НЬ

Ял тэнсэн хугацаанаас өмнө суллагдсан, хорих ялаас тэнсэн сулласан, хорих ялын хугацаа дуусаад суллагдсан зэрэг этгээдүүдэд тавьж буй хяналтын арга ажиллагаа нь тэднийг сард нэг удаа дуудан “хяналтын хугацаанд юу хийж байгаа, захиргааны зөрчил гаргасан эсэх, хаяг өөрчлөгдсөн эсэх, ойрын хугацаанд гадагш явах эсэх” зэрэг асуултыг бөглүүлэх төдийгөөр хяналт хийж байгаа нь учир дутагдалтай. Иймд олон улсад ашиглаж буй дараах хяналтын үр нөлөөтэй аргуудыг нэвтрүүлснээр хяналт сайжрах боломжтой. Тухайлбал, архи, хорт бодис, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох ба эдгээрийг хэрэглэж байгаа эсэхийг сорилт тавьж хянах, электрон хяналтын тусламжтайгаар газар зүйн тодорхой байршлуудаас татгалзуулах, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтний тухайд тусгай эмчилгээний хөтөлбөрт хамруулах, насанд хүрээгүй хүнтэй хамт амьдрахыг хориглох, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах зэрэг аргууд байна.⁸⁴

Канад Улсад өндөр эрсдэл бүхий гэмт хэрэгтэнд электрон гав буюу GPS зүүлгэж хиймэл дагуулаар цахим хяналт тавьж байгаа бөгөөд өртөг өндөртэй энэ арга нь болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэж байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хоригдлыг суллагаас өмнө тэдгээрийг олон нийтэд аюултай эсэхээр нь өндөр, дунд, бага эрсдэл бүхий этгээд гэж ангилан ялгадаг байна.

⁸³ НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецидивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 7 дахь тал.

⁸⁴ НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецидивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 6 дахь тал.

3.4 ГЭМТ ХЭРЭГТНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНЫ ҮҮРЭГ

Ялтныг нийгэмшүүлэх ажлыг зөвхөн хорих байгууллагад хамаатуулан ойлгож болохгүй бөгөөд төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хууль сахиулах байгууллага, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоо чухал юм. ГХЗУСТХ-ийн 45 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно.” гэсэн заалт шинээр хуульчлагдлаа.⁸⁵ Монгол Улс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэгтэнд тавих хяналтын процесст олон нийтийг хамруулах талаар хуульчилсан нь сайшаалтай бөгөөд цаашид үүнийг нийгэмшүүлэх зорилгоор хөгжүүлэх нь зүйтэй юм.

НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм)-д гэмт хэрэгтнийг нийгэмд нь засан хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцоо ихээхэн чухал болохыг тайлбарлажээ. Энэ дүрмийн 17.1-т олон нийтийн оролцоо нь гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авч гэр бүл, нийгэмтэй нь холбоотой байлгах чухал эх сурвалж болдгийг дурджээ. Энэ талаар улс орнууд ихээхэн хүчин чармайлт тавьж ажиллахыг ч мөн сануулсан байна. Тухайлбал, Япон Улсад мэргэжлийн буюу төрийн статустай Пробацийн алба ажиллахаас гадна гэмт хэрэгтнийг нийгэмд нь засан хүмүүжүүлэх ажлыг гүйцэтгэдэг сайн дурын пробацийн ажилтнууд ажилладаг.

Азийн орнуудаас Япон Улсыг гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх ажилд олон нийтийн оролцоог чухалчилж байгаа сонгодог жишээ гэж үзэж болно. 60 гаруй жилийн түүхтэй энэ сайн дурын албанд нийт 48000 хүн ажилладаг.⁸⁶ Эдгээр сайн дурын ажилтан мэргэжлийн пробацийн албатай хамтран ажиллаж, гэмт хэрэгтнийг нийгэмд нь хянах, амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хуулиар олгосон эрх зүйн статус, зэрэг дэвтэй байдаг байна. Сайн дурын пробацийн алба,

⁸⁵ 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс ГХЗУСТХ хууль хэрэгжиж байна. www.legalinfo.mn

⁸⁶ Хууль зүйн яамны Нийгэмшүүлэх Алба, “Ялтныг нийгэмшүүлэх нь”, UNIFEI 159 дугаар сургалт-зөвлөгөөний материалаас, 2015 он, Токио, Япон улс

түүнтэй ижил төстэй бүтцүүд Азийн болон дэлхийн зарим оронд байгуулагдсанаар тэдгээрийн хамтын ажиллагаа өргөжих болсон. Тухайлбал, 2014 оны 7 сард энэ асуудлаар Токио хотноо чуулган зохион байгуулагдаж, гэмт хэрэгтнийг нийгэмд нь хүмүүжүүлэх, сайн дурын пробагийн ажилтны хөтөлбөрийг хөгжүүлэх үүднээс Токиогийн тунхаглалыг баталжээ.

Гэмт хэрэгтнийг нийгмийн амьдралд эргэн нэгтгэх ажлыг Монгол Улсад төрийн байгууллагаас гадна шашны болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллага, компаниуд гүйцэтгэдэг байна. Төрийн бус байгууллагын дотроос шашны байгууллага хамгийн өндөр хувьтайгаар энэ ажилд оролцдог бол төрийн байгууллага, албан хаагчдаас хорих ангийн нийгмийн ажилтан ялтныг нийгэмд нь эргэн нэгтгэх ажилд хамгийн их оролцдог гэсэн судалгаа гарч байжээ.⁸⁷ Судалгааны явцад, эдгээр байгууллагын ихэнх нь Христийн шашны байгууллагууд байсан нь ажиглагдсан.⁸⁸

Тэгвэл хорихоос суллагдсан этгээдийг нийгэмд хүлээн авах байдлыг тандан судлах зорилгоор хорих ялаас тэнсэн суллагдсан, хугацаанаас өмнө суллагдсан болон энгийн иргэдээс түүврийн аргаар санал асуулга авсан юм. Энэхүү санал асуулга нь бүрэн дүгнэлт гаргахад хангалттай тооны иргэдийг хамруулж чадаагүй тул цаашид санал асуулгын цар хүрээг өргөтгөн гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэдгийг судлаачийн зүгээс цохон тэмдэглэж байна.

3.4.1 Ажлын байранд ялгаварлан гадуурхах хандлага

Санал асуулгад оролцогчдоос “*хорих ялаар шийтгүүлж, ял шийтгэл эдэлж байсан хүнтэй хамт ажиллахыг хүлээн зөвшөөрөх үү*” гэсэн асуултад 76 хувь нь тийм, 24 нь үгүй гэж хариулсан нь гэмт хэрэг үйлдээд хорих ял шийтгүүлсэн хүнийг олон нийт хүлээн авах хандлага давамгайлж, хамт ажиллахыг зөвшөөрч байна гэсэн дүн шинжилгээ хийж болохоор байна. Түүнчлэн “*та байгууллагынхаа удирдлагыг ял шийтгэл авч*

⁸⁷ Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал судалгааны тайлангаас иш татав. 2014 он, УБ хот, 64 дах тал

⁸⁸ Мөн тэнд. 66 дахь тал.

байсан хүнийг ажилд авахыг зөвшөөрөх үү” гэсэн асуултад 62.8 хувь нь тийм, 37.2 хувь нь үгүй гэж хариулжээ.

3.4.2 Гэр бүлийн зүгээс гадуурхах, хүлээж авахгүй байх

“Таны гэр бүлийн хүн ял шийтгэл эдэлж байгаад суллагдвал та яаж хандах вэ?” гэсэн асуултад халуун дулаанаар хүлээн авна гэж 36 хувь, ямар нэгэн сөрөг өөрчлөлт гарахгүй гэж 41.9 хувь нь хариулсан бол айдастай угтана гэж 21.2 хувь нь хариулжээ. Үүнээс үзэхэд гэр бүлийн гишүүн нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байх нь тэднийг ялгаварлан гадуурхах нөхцөл болохгүй гэсэн хариулт давамгайлж байна.

3.4.3 Нийгмийн харилцаанд оролцох, олон нийттэй харилцах

Хорих ял эдлээд суллагдсан хүнтэй яаж харилцах талаар буюу хүн бүрд хоёр дахь боломж байдаг гэдэгтэй санал нийлэх эсэх гэсэн асуултад 94.1 хувь нь тийм гэж 5.8 хувь нь үгүй гэж хариулжээ.⁸⁹ “Таны хүүхэд хорихоос суллагдсан хуучны найзтайгаа нөхөрлөхөд та хэрхэн хандах вэ” гэсэн асуултад тухайн хүүхдийг сайн мэдэх тул ач холбогдол өгөхгүй гэж 39.5 хувь, засарч хүмүүжсэн эсэхийг анхааралтай ажиглаж мэдсэний дараа найзлахыг зөвшөөрнө гэж 46.5 харин хүүхдээ найзлахыг шууд хориглоно гэж 14 хувь нь хариулсан байна.

Харин хорих ял эдлээд суллагдсан этгээдийг олон нийттэй харилцах ажилд авах талаарх асуултад ямар гэмт хэрэг үйлдээд ял шийтгүүлж байсныг нь анхаарах хэрэгтэй гэж судалгаанд оролцогчдын 44.2 хувь буюу 38 хүн хариулсан бол ямар гэмт хэрэг үйлдсэн байх нь хамаагүй гэж 30.2 хувь, олон нийттэй харилцах ажилд ажиллуулахгүй байх нь зөв гэж 25.6 хувь үзсэн байна.

Дээрх тандах судалгааны үр дүнг ажиглавал, хорихоос суллагдсан этгээдийг олон нийттэй харилцах, нийгмийн харилцаанд

⁸⁹ Түүврийн аргаар 100 иргэнийг хамруулсан энэхүү судалгааг 2019 оны 6 сард зохион байгуулав.

оролцоход сөрөг хандлага бага хувьтай байна. Хэдийгээр тэднийг ялгаварлан үзэх, хүлээн авахгүй байх хандлага багатай ч тэдэнд туслах, хамтран ажиллах, нийгэмших үйл явцыг дэмжих хандлага сул байгаа нь ажиглагдав. Энэ нь *“хорихоос суллагдсан хүнд ямар нэгэн байдлаар тусалж байсан уу”* гэсэн асуултад 92.5 хувь нь тусалж байгаагүй гэж хариулснаас харагдаж байна. Түүнчлэн гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх төрийн чиг үүргийг 81.4 хувь нь хангалтгүй, 18.6 хувь нь хангалттай гэж дүгнэжээ.

ДҮГНЭЛТ

Гэмт хэрэгтнийг хянах хяналтын загвар нь олон улсад эрсдэлд ба хэрэгцээнд суурилсан гэсэн 2 төрөл байдаг.⁹⁰ Эрсдэлд суурилсан загвар нь гэмт хэрэгтнийг нийгэмд аюултай гэж үзэн тэднийг хянаж байхыг чухалчилдаг бол хэрэгцээнд суурилсан стратеги нь дахин гэмт хэрэг үйлдэх магадлал болох гэмт хэрэгтний “криминогенийн” хэрэгцээнд анхаарлаа хандуулж тодорхой хөтөлбөрийг хэрэгжүүлдэг онцлогтой.⁹¹

Монгол Улсад гэмт хэрэгтнийг хянах үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг урьтал болгож, тэднийг нийгэмшүүлэх буюу засан халамжлахаас илүүтэй хянан харгалзах арга хэмжээ авч байгаа нь эрх зүйн зохицуулалт, тэдгээрийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагын үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдлаас харагдаж байна. 2019 онд шинэчлэн баталж, 2020 оноос хэрэгжиж эхэлсэн ГХЗУСТХ хууль нь гэмт хэрэгтнийг хянах чиглэлээр нэлээд дэвшилттэй зүйл заалтуудыг хуульчилж өгсөн хэдий ч хуулийн үзэл баримтлал нь гэмт хэрэгтнийг хянах үйл ажиллагаанд суурилсан чиг хандлагатай учир гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх бодлогод төдийлөн нөлөөлөхгүй байх магадлалтай.

Монгол Улсад 2014 онд 26 хорих ангид 6500 хоригдол ял эдэлж байгаагийн 47.2 хувь,⁹² 2018 онд 3500 хоригдол ял эдэлж байгаагийн 46.1 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн байгаа⁹³ нь давтан гэмт явдал өндөр хувьтай байгаа төдийгүй гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл явц учир дутагдалтайг харуулж байна. Иймд гэмт хэрэгтнийг хянаж-нийгэмшүүлэх үйл явцыг зөвхөн хугацаанаас өмнө суллагдсан болон тэнссэн этгээдээр хязгаарлахгүйгээр нийт суллагдаж буй гэмт хэрэгтнийг хамруулах, нийгэмд эргэн нэгтгэх

⁹⁰ НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецедивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он, 59 дахь тал.

⁹¹ Мөн тэнд.

⁹² Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал, судалгааны тайлан, УБ.,2014 он.

⁹³ ШШГЕГ-ын 2019 оны дүн мэдээнээс авч ашиглав.

үйл явцыг төрийн зүгээс анхааралдаа авах шаардлага бий болсныг харуулж байна.

Монгол Улсад эрүүгийн шинэтгэлийн хүрээнд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс ШШГБ, үүнээс өмнөх шүүхийн шийдвэрийн дагуу ЦБ нь хорихоос суллагдсан болон тэнсэнтэй гэмт этгээдэд хяналт тавьж байна. Гэмт хэрэгтнийг хянах үйл явц Монгол Улсад төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа нь өөр өөрийн үндсэн чиг үүрэгтэй дээрх хууль сахиулах байгууллагуудад хяналтын үйл ажиллагааг “дайвар” байдлаар нэмэгдүүлж өгсөнтэй холбоотой байж болох талтай. Одоогийн байдлаар ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын заалт хэрэгжиж эхлэхээс өмнө цагдаагийн хяналтад байсан этгээдийн хяналт хэвээр үргэлжилж байгаа төдийгүй ШШГБ байхгүй нутаг дэвсгэрт зохих журмын дагуу ЦБ хяналт тавьж ажилладаг. Гэхдээ эдгээр байгууллагын уялдаа холбоо сул, эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй, нийгэмшүүлэх зорилгыг агуулдаггүй зэрэг олон учир дутагдалтай тал харагдсаар байна. Эндээс үзвэл манай улсад дэлхийн бусад орны жишгээр гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тусгайлсан эрх зүйн зохицуулалт, нэгдсэн тогтолцоо, үндсэн чиг үүрэг бүхий тусдаа институцийг бий болгох хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаагаар Азид төдийгүй дэлхийд сайн туршлага нэвтрүүлж буй Япон Улсад “дүрэм журам бүхий хяналт”, “дэмжлэг, тусалцаа” гэсэн 2 хэлбэрийг хэрэглэдэг.⁹⁴ Дүрэм журам бүхий хяналт гэдэгт гэмт хэрэгтний зан авирыг ойлгох үүднээс ярилцах болон бусад тохиромжтой аргыг ашиглан “харилцаа тогтоох”, хяналтын хугацаанд тэдний амьдралд дүрэм журмыг мөрдүүлэх, мөрдүүлэхээр тодорхой арга хэмжээ авах, гэмт хэрэгтний онцгой авьяас, эрмэлзлийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг багтдаг. Харин дэмжлэг тусалцаанд орон байртай болох, эрүүл мэндийн тусалцаа авах, мэргэжлийн зааварчилга авах, ажил хөдөлмөр эрхлэх, боловсрох зэрэгт нь туслах асуудлууд багтахаас гадна амьдрах хэв маягаа бүрдүүлэх, нийгмийн нөхцөл байдалд дасан зохицох зэрэгт нь тусалдаг.

⁹⁴ Япон Улсын Эрүүгийн процесс 2019, 45 дахь тал. https://www.unafei.or.jp/publications/pdf/CJSJ_2019/00CJSJ_2019.pdf

Монгол Улсад дээрх сайн туршлагыг нэвтрүүлж, дүрэм журмыг мөрдүүлж хяналт тавихаас гадна дэмжлэг туслалцаа үзүүлж нийгэмшүүлэх үйл ажиллагааг давхар хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, суллагдсан гэмт этгээдийг орон байраар хангах, ажил хөдөлмөр эрхлүүлэх, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах иж бүрэн асуудлыг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалт байхгүй байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, гэмт хэрэгтэн хорих ял эдэлж суллагдсаны дараа гэр бүл, нийгмийн зүгээс гадуурхагдах, хавчигдах зэрэг асуудалтай тулгарч, бие хүн болон нийгмийн үнэт зүйл болох боловсрол эзэмших, ажлын байр олох зэрэг нийгмийн олон талт асуудалд сөрөг хандлагатай тулгарч бэрхшээл учирдаг. Эдгээр асуудалтай тулгарснаас болж ял эдлээд суллагдсан этгээд нийгэмд эргэн нэгдэж чадахгүйд хүрч, улмаар дахин гэмт хэрэг үйлдэж нийгмээс дахин тусгаарлагддаг. Хорихоос суллагдсан этгээд нийгэмд шилжин орох үед материаллаг байдлын хомсдол, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг байхгүй үед ихэнх гэмт хэрэгтэн суллагдахаас зайлсхийх, дахин баривчлагдах магадлалтай байдаг. Судалгаагаар хөдөлмөр эрхлэлт, орон сууц, гэр бүлийн дэмжлэг, донтох эмчилгээ болон эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамжийн хүртээмж, санхүүгийн туслалцаа, бусад хүмүүсийн тэдэнд хандах хандлага гэсэн үзүүлэлтүүд нь хорихоос суллагдсан этгээдэд чухал үүрэгтэйг илрүүлсэн байдаг.

Түүнчлэн насанд хүрээгүй хүнийг нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх үүднээс Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны үйл ажиллагааг жигдлэх, өөрөөр хэлбэл, СХТБ-д байгаа хүүхдүүдийг хүмүүжиж буй хугацаанд нь анхаарал тавих, суллагдсаны дараа тэднийг хүлээн авах, хүүхэд бүрийн гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай нь хамтран ажиллах, сэтгэлзүйн үйлчилгээнд хамруулах зэрэг цогц үйлчилгээг гүйцэтгэдэг төрийн байгууллага болгох асуудлыг цаашид судлах нь зүйтэй. Түүнчлэн ШШГБ болон бусад төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, нийгмийн ажлын үйлчилгээнүүд хоорондоо холбоотой, нэг нь нөгөөгийнхөө үр дүнд үндэслэж, залгамж халааг нь бэхжүүлж, хүүхдэд хүрдэг байх хүүхэд хамгааллын харилцан уялдаа бүхий тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх нь зүйтэй.

Эцэст нь Монгол Улсад рецидив гэмт хэргийг бууруулах үүднээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх зорилгыг нэгэн дээвэр дор оруулах шаардлагатай. Түүнчлэн гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгайлан баталж, нийгэмшүүлэх ба хяналтын тусгайлсан чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагууд болох Паролын болон Пробацийн албыг байгуулж, дорвитой шинэтгэл хийх нь зүйтэйг тэмдэглэн хэлье.

САНАЛ

- *Хорих ангиас хугацаанаас өмнө болон бусад байдлаар суллагдаж буй гэмт хэрэгтний ахуй хангамж, сэтгэл зүйн болон бусад онцлогийг харгалзан гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлийн үнэлгээ тогтоож суллах.* Ингэхдээ эрсдэлийн үнэлгээ гаргах мэргэжлийн Зөвлөл байгуулж, түүний ажиллах журмыг олон улсын туршлагын дагуу боловсруулан батлах нь зүйтэй. ГХЗУСТХ-д зааснаас гадна өндөр эрсдэлтэйд тооцогдсон этгээдийг зохих байгууллагын хяналтад хамруулах. АНУ зэрэг гадаадын зарим улс high risk буюу өндөр эрсдэл бүхий гэмт хэрэгтнийг төрийн байгууллагын болон олон нийтийн пробацийн ажилтны хяналтад хүлээлгэн өгөх байдлаар тэднийг нийгэмшүүлэх, ингэснээр рецидив гэмт хэргийг бууруулна гэж үздэг.
- *Хорихоос суллагдсан этгээдийн “шилжилтийн үе”-ийн хүндрэлтэй асуудлууд болох хөдөлмөр эрхлэлт, орон сууц, донтох эмчилгээ болон эрцүл мэндийн даатгал, нийгмийн халамж, санхүүгийн тусалцаа зэргийг шийдвэрлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд онцгой анхаарч, хамтран ажиллах.* Түүнчлэн дээрх асуудлыг төрөөс шийдвэрлэх зорилгоор “гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тусгай сан” бүрдүүлэх замаар нийгмийн хамгааллын тогтолцоо бий болгоход анхаарал хандуулах шаардлагатай байна. ХБНГУ-д хорихоос суллагдсан этгээдэд ажлын байртай болох хүртэл хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж олгодог нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.
- *Хорихоос суллагдсан этгээдийг түр хугацаанд байр, хоолоор хангаж үйлчлэх чиг үүрэг бүхий нийгэмшүүлэх байр байгуулах.* Улсын хэмжээнд 2-3 нийгэмшүүлэх байрыг ашиглалтад оруулж, цаашид Хууль зүйн яамнаас авсан зөвшөөрлийн дагуу хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааг эрхлэн явуулах боломжийг хуульчлах нь зүйтэй.

- *Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны үйл ажиллагааг жигдлэх талаар төрийн зүгээс тодорхой арга хэмжээ авах.* Ялангуяа хүний нөөцийг нэмэгдүүлэх, сайн дурын ажилтан элсүүлэх, тэдний урамшууллын төсвийг шийдвэрлэх шаардлагатай.
- *Монгол Улсад эрүүгийн процессын үйл ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэсэн үе шатаар дуусгадаг нь учир дутагдалтай төдийгүй нийгэмшүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоо, хариуцах үндсэн бүтэц байхгүй, эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй зэргийг харгалзан тогтолцооны хувьд өөрчлөлт хийх шаардлагатай.* Иймд Монгол Улсад “Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тухай” тусгайлсан хуулийг батлах, цаашлаад тус хуулийн дагуу нийгэмшүүлэх үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг бүхий “Пробацийн болон Паролын алба”-ыг ХЗДХЯ-ны харьяанд байгуулах.
- *Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нягтруулах.* Монгол Улсад Пробацийн алба байгуулснаар пробацийн болон паролын үйл ажиллагаа, ШШГБ, ЦБ, ГСУСЗ зэрэг төрийн байгууллага хамтран нягт холбоотойгоор ажиллах боломж нээгдэнэ. Ингэснээр гэмт хэрэгтнийг 3 үе шаттайгаар нийгэмшүүлэх үйл ажиллагааг цогцоор хэрэгжүүлэх боломжтой болно.
- *Сайн дурын пробацийн ажилтан ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлэх.* Цаашид гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оруулах суурь нөхцөлийг бүрдүүлж, Япон Улсын сайн туршлагыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

Олон улсын эрх зүйн баримт бичиг:

1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, 1990 он
2. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1976 он
3. Өсвөр насны хүнд явуулах шүүхийн удирдлагын талаарх НҮБ-ын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм), 1985 он
4. НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм), 1990 он
5. Өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын удирдамж (Риядхын удирдамж), 1990 он
6. Хоригдлыг засан хүмүүжүүлэх НҮБ-ын наад захын жишиг дүрэм буюу Нелсон Манделагийн дүрэм, 2015 он
7. Эмэгтэй хоригдлыг засан хүмүүжүүлэх ба эмэгтэй гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял хэрэглэх тухай НҮБ-ын (Бангкокийн дүрэм), 2010 он
8. НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй Тэмцэх Алба, “Рецедив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх”, Вена хот, 2018 он

Дотоодын ба гадаад улсын хууль тогтоомж:

9. Эрүүгийн хууль, 2002, 2015 он
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015 он
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2015 он
11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 1998 он
12. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он
13. ШШГЕГ, ЦЕГ-ын даргын хамтарсан 2017 оны 12 сарын 14-ны өдрийн А/260 тоот тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”
14. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А51/А69 тоот тушаалын хавсралт

15. Япон Улсын Сайн дурын пробацийн ажилтны тухай хууль, 1950 он
16. Япон Улсын Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тухай хууль, 2007 он

Судалгааны тайлан, өгүүлэл нийтлэл:

17. Монгол Улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал судалгааны тайлан, УБ хот, 2014 он
18. Г.Оюунболд, Г.Эрдэнэбат, “Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь”, Бодлогын судалгааны тайлан, УБ хот, 2011 он
19. Б.Одонгэрэл, Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд олон нийтийн оролцоо чухал болох нь, “Хууль сахиулах үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцсэн илтгэл, 2014 он.
20. Нэгдсэн улсын ял шийтгэлийн тайлан, цуврал 28, № 2, 2015 он
21. Япон Улсын Эрүүгийн процессын тайлан, 2019 он
22. АНУ дахь 2016 оны пробацийн ба паролын нөхцөл байдал, АНУ-ын Хууль зүйн яамны Хууль зүйн хөтөлбөрийн алба, <https://www.bjs.gov/index.cfm?ty=pbdetail&iid=6188>
23. Риан М Лабрикью, “АНУ дахь пробацийн тогтолцооны түүхэн ба орчин үеийн чиг хандлага”, https://pdxscholar.library.pdx.edu/cgi/viewcontent.cgi?article=1029&context=ccj_fac

Вэбсайт:

24. www.legalinfo.mn
25. www.police.gov.mn
26. www.moj.go.jp
27. www.unodc.org/documents/justice-and-prison-reform
28. <https://www.ohchr.org/Documents/ProfessionalInterest/beijingrules.pdf>
29. https://www.unafei.or.jp/publications/pdf/CJSJ_2019/00CJSJ_2019.pdf

